



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг



Хэрэгжүүлэгч

**giz** Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

## “МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ”



# БИДНИЙ ТУРШЛАГА - 2019

НИЙСЛЭЛИЙН ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙГ ЗАСВАРЛАЖ,  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЭЦЭГ ЭХ,  
ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ХЯНАЛТЫГ НЭМЭГДҮҮЛСЭН САЙН  
ТУРШЛАГЫН ЭМХЭТГЭЛ



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



### НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ТЭРГҮҮНИЙ 62 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



- “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл” манай цэцэрлэгт
- Бусадтай хуваалцах бидний сайн туршлага
- Зургийн цомог

## **БИДНИЙ ТУХАЙ**

Баянзүрх дүүргийн тэргүүний 62 дугаар цэцэрлэг нь тус дүүргийн 10 дугаар хороонд байрладаг. 1971 онд ашиглалтад орж, 6 бүлэг, 31 багш ажилтан, 300 хүүхэдтэй ажиллаж эхэлсэн. Манай цэцэрлэг төв зам дагуу Амгалангийн автобусны буудлын хойно 6,590м<sup>2</sup> талбайд байрладаг. 2019-2020 оны хичээлийн жилд 150 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөлийн барилга ашиглалтад орж, 13 бүлэг, 53 багш ажилтан, 500 хүүхэдтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Сургалт хүмүүжлийн ажлаа эхэлснээс хойш 48 дахь хичээлийн жилдээ амжилттай ажиллаж байна. Хамран сургах тойргийн 5 настай хүүхдийг 100%, 2-6 настай нийт хүүхдийн 70 хувьд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үзүүлж байна. Манай цэцэрлэгт магистрын зэрэгтэй 3, бакалаврын зэрэгтэй 15, тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй 3, заах аргач мэргэжлийн зэрэгтэй 4 буюу нийт 15 багш, 13 туслах багш, 25 ажилтан ажилладаг. Эрхлэгч Н.Алтанцэцэг МУЗГ-ын шагнал “Алтан гадас” одонтой, багш Ш.Насанжаргал “Хөдөлмөрийн хүндэт” медальтай, 5 багш “Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдэгтэй, арга зүйч О.Эрдэнэцэцэг, туслах багш У.Уранчимэг нар “Жуух бичиг”-гээр шагнуулж хөдөлмөр зүтгэлээ үнэлүүлсэн юм. 2015 оноос “Хүн болох багаасаа” буюу хүүхэд бүрийг зөв сайхан хүмүүжилтэй болгохыг зорилго болгон, эерэг зан чанарыг төлөвшүүлэх “Эрдэнэсийн уурхайг нээхүй” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



### **Цэцэрлэгийн амжилт:**

- 2017 онд Нийслэлийн БЗД-ийн “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”;
- 2018 онд БСШУСЯ, Боловсролын Хүрээлэнгээс зохион байгуулсан “Тогтвортой хөгжил - Сургуулийн өмнөх боловсрол” улсын II зөвлөгөөнд “Стандарт хөтөлбөр” салбар хуралдаанд амжилттай оролцон “Батламж”;
- 2018 онд “Нийслэлийн Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”;
- 2018 онд Нийслэлийн БЗД-ийн “Оны шилдэг боловсролын байгууллага”;
- 2018 онд “МОНГОЛ ЧАНАР” Өргөмжлөл, цом;
- 2019 онд “Ногоон цэцэрлэг” аяны хүрээнд зохион байгуулсан постер илтгэлийн уралдаанд “Туршилтын талбайн тохижилт, үйл ажиллагаа”-аар шилдгээр шалгарч “Сайн туршлага”-ын “Батламж”;
- 2019 онд Нийслэлийн БЗД-ийн “Тэргүүний цэцэрлэг”;
- 2019 онд багш Д.Алтан-Ай “Хамт олныг төвөлшүүлэгч шилдэг багш”-аар шалгарч Дүүргийн засаг даргын “Өргөмжлөл”-өөр тус тус шагнуулсан.



**Хүүхдүүдийн амжилт:**

- 2017 онд Нийслэлийн БЗД-ийн цэцэрлэгүүдийн дунд зохион явагддаг “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнд цэцэрлэгийн багийг бэлтгэж оролцуулсан. “Аюулгүй, шилдэг орчин бүрдүүлэгч” цэцэрлэг;
- 2018 онд Нийслэлийн БЗД-ийн цэцэрлэгүүдийн дунд зохиогдсон “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн тэмцээнд тусгай байр;
- 2018 онд Нийслэлийн БЗД-ийн цэцэрлэгүүдийн дунд зохион явагддаг “Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээнд Ү байр;
- 2019 онд Нийслэлийн шатрын клубээс зохион байгуулсан. “Цодгор хүү” тэмцээнд Бэлтгэл “А” бүлгийн Д.Цолмонбаатар I байр;
- 2019 онд Монголын “Соробан сампин”-ийн нийгэмлэгээс зохион байгуулсан тэмцээнд Бэлтгэл “А” бүлгийн Б.Батболд II байр;
- 2019 онд Нийслэлийн “Хуйрнан шуугигч” бөхийн тэмцээнд Бэлтгэл “Б” бүлгийн Б.Мөнх-Эрдэнэ II байрт тус тус шалгарлаа.

**“МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ МАНАЙ ЦЭЦЭРЛЭГТ**

**Н.Алтанцэцэг (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 62 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)**

Манай цэцэрлэгийн хуучин барилгын ангиудын цонх өвөлдөө мөстөн, хана нь хөлөрч, тааз нь мөөгөнцөртдөг, их хүйтэн, зарим ангид халаалт тавьж өвөлждөг, бохир үе үе бөглөрч үнэртдэг нэлээд хүнд нөхцөлтэй байсан. Харин 2019 онд НЗДТГ, Германы Хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн санхүүжилтээр “Хөлөг-Од” ХХК-ийн хамт олон барилгын дулаалгын засвараар дээвэр, гадна фасад дулаалах, бохирын шугам, цонх, хаалга солих зэрэг урьд хожид байгаагүй өндөр өртгөөр, томоохон засварын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн засварын ажилд “Хамтарсан баг” хяналт тавин ажилласан нь энэхүү дулаалгын ажил үр дүнгээ өгөхөд ихээхэн түлхэц болсон юм.



Хүүхэд сурч хөгжихөд ая тухтай дулаахан орчныг бүрдүүлэн өгсөн НЗДТГ, НБГ, GIZ, “Хөлөг-Од” ХХК-ийн хамт олон нийт хүүхэд, эцэг эх, багш, хамт олныхоо өмнөөс баярласнаа илэрхийлье.



### **Б.Оюунтуяа (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 62 дугаар цэцэрлэгийн багш)**

Би цэцэрлэгтээ 30 дахь жилдээ ажиллаж байна. Манай цэцэрлэгийн анги бүлгүүд цонхоороо дулаан алддаг, дээврээс ус гоождог, мөөгөнцөр үүссэн байдалтай байдаг. Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан урсгал засварыг жил бүр хийдэг боловч асуудлыг бүрэн шийдэж чаддаггүй байлаа.


2018-2019 оны хичээлийн жилд манай цэцэрлэгт гадна дулаалга, цонх, хаалга, дээврийн дулаалга зэрэг засвар хийгдсэн. Барилгын засвар эхлэхээс өмнө хамтарсан

багийн сургалтыг эцэг эх, багш ажилтны хүрээнд зохион байгуулан, тэдний оролцоог дэмжих, хамтран ажиллах, арга барилд суралцсан. Бид барилгын ажлын талаар мэдлэгтэй болж, барилгын ажлын явцад өөрсдийн хяналтын үнэлгээг хийж чаддаг болсон нь энэхүү төслийн гол ач холбогдол байсан.

### **н.Гомбо (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 62 дугаар цэцэрлэгийн дундын А бүлгийн Бямбатөгсийн аав)**

Баянзүрх дүүргийн 10 дугаар хороонд байрлах 62-р цэцэрлэгт гадна талаас дулаалах, цонх, хаалга солих, дулааны шугам янзлах ажлыг 7 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд хийж гүйцэтгэсэн. Тус үйл ажиллагааны хүрээнд хамт олон болон эцэг эхчүүд хамтран барилгын засварын ажлыг явцын шалгалт хийж ажилласан.

Тендэр удааширсанаас болж засварын ажил хугацаандаа эхлээгүй. Шалгалтын явцад засварын ажил стандартын дагуу хийж гүйцэтгэсэн гэж бодож байна. Гадна талаас хөөсөн пасадыг сайн чанарын хөөсөөр хийсэн, мөн цонх, хаалга бүгд 3 давхар шилтэй орчин үеийн стандартад нийцсэн материалаар хийсэн.



**Бусадтай хуваалцах бидний сайн туршлага:**

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

### ОРЧНЫ ЗУРАГЛАЛ ХИЙЖ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛАА ХЭРХЭН ШИЙДЭХ ВЭ?

Нөхцөл байдал,  
тулгамдсан  
асуудал

- Бид 500 орчим хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлдэг учир өдөр бүр багадаа 850-950 гаруй бага насны хүүхэд, эцэг эх, олон нийт ирж очиж, байнга цугладаг. Энэ онцлогоос хамаарч барилга байгууламжийн болон гадна орчны аюулгүй байдал, эрсдэлд байнга анхаарч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь манай цэцэрлэгийн тулгамдсан асуудлын нэг байлаа.
- Манай хамт олон, эцэг эхийн төлөөлөлтэй хамтран, цэцэрлэгийнхээ эргэн тойрон дахь барилга, хашаа, хүүхдүүдийн ирж очдог зам зэрэг 15,000 м<sup>2</sup> орчим газарт аюулгүй байдал, нөхцөлд гадаад орчны эрсдлийн үнэлгээ хийж, зураглал гаргасан.
- Бага насны хүүхдийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагын бодит амьдрал дээрх хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх хэрэгцээ нэмэгдсэн.

Эдгээр хяналт үнэлгээ, орчны зураглалыг хийснээр манай цэцэрлэгт дараах тулгамдсан асуудал байгааг тодорхойлсон юм.

Үүнд:

- Цэцэрлэгийн барилга байгууламж 1971 онд ашиглалтад орсноос хойш дээврийн их засварын ажил хийгдээгүй учир хуучирч муудсан, цас борооны ус байнга гоождог;  
Дулаан алдагдал, агааржуулалт муу, чийг ихтэй тул мөөгөнцөр үүссэн, хоёр давхарын 3 бүлэг, урлаг заалын тааз мөөгөнцөртсөн. Цэцэрлэгийн нийт талбайн хэмжээ 1,072м<sup>2</sup> бөгөөд үүний 22 хувь нь мөөгөнцөртсөн, чийгшлийн хэмжээ 70 хувь, дулаан алдалт нь барилгын дээвэр хэсгээр 22 хувь, цонхоор 18 хувь гэж тооцсон. Эдгээр үзүүлэлт нь хүүхэд багш ажилтны эрүүл аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болсон.
- Агааржуулалт, салхижуулалтын систем хүрэлцээ муу, ихэнх нь ажилладаггүй, стандартын шаардлага хангадаггүй. Цэцэрлэгийн ашигтай талбай 583м<sup>2</sup>-д байх ёстой агааржуулалт, салхижуулалтын системийн тоо 10 байгаагаас 6 нь хэвийн ажиллаж, 3 нь доголдолтой ажиллаж, 1 нь ажиллагаагүй байна.
- Анги бүлгийн байгалийн гэрэлтүүлэг хангалтгүй. Нэг ангийн талбайн хэмжээ 80м<sup>2</sup>, 3-4 цонхтой нийт цонхны хэмжээ стандарт бус, завсартай, зарим шилэнд цууралт үүссэн, цонхны тавцан дээр цэцэг байршуулж хаасан байдалтай байсан.
- Сантехникийн шугам хоолой муу, бөглөрдөг. Сантехникийн шугам хоолойд хийх засвар үйлчилгээг жил бүрийн засварын ажлын төлөвлөлтөд оруулж, их бага хэмжээний засвар үйлчилгээ хийдэг боловч, чанар муутай хийгддэгийн улмаас байнга шугам хоолойд бөглөрөл үүсдэг. Бөглөрөх гол шалтгааныг сантехникийн шугамын хоолойн хэмжээ нь стандартын бус нарийн хоолой тавигдсан, сольж сайжруулахад төсөвлөсөн мөнгө хүрдэггүй гэсэн тайлбарыг мэргэжлийн слесарь хэлдэг. Хамгийн сүүлийн засвар үйлчилгээг 2017 оны намрын засвар хийх үеэр хийсэн. Бохирын

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>шугам бөглөрөхөд эрүүл ахуйн байдалд ноцтой хүндрэл, эрсдэл учирдаг, хэвийн үйл ажиллагаа алдагдах, ариутгал халдваргүйтгэлд зарцуулах хөрөнгө мөнгөний хэмжээ нэмэгдэх, халдварт өвчин тархах зэрэг олон сөрөг үр дагавартай.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдэд оногдох ашигтай талбай бага. Цэцэрлэг нь 190 хүүхдийн хүчин чадалтай 1971 онд анх ашиглалтад орсон бөгөөд одоогоор 280 хүүхэд суралцаж байна. Нэг хүүхдэд оногдох ашигтай тайлбайн стандарт хэмжээ 5,6м<sup>2</sup> байхаас 3,7м<sup>2</sup> байгаа нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин, стандартын шаардлагад нийцэхгүй байгаа болно. Нэг хүүхдэд оногдох нийт талбайн хэмжээ бага байгаа шалтгааныг анги дүүргэлт их, хүүхдийн тоо их байгаатай холбон тайлбарлаж болох юм.</li> <li>• Төвлөрсөн шугамд холбогдоогүй, зөвхөн хүйтэн ус авдаг. Халуун ус хэсэгчлэн ирдэг. Халуун усны хэрэгцээгээ хангах зорилгоор бойлер тавьсан. Нийт талбайн 42 хувьд халуун ус ирж, 58 хувь нь хүйтэн устай байлаа. Бойлероор халуун ус ирдэг ч байнга доголдолтой хэсэгхэн хугацаанд ирээд тасрах жишээтэй. Гал тогооны бойлер байнга доголдож, хүүхдийн хэрэгцээний усыг хоолны тогоо болон өөр бусад халаах хэрэгслээр халааж хангадаг байсан. Энэ нь цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагаа явуулах, хүүхдийн эрүүл ахуйг хангахад бэрхшээлтэй байдлыг үүсгэж байв.</li> </ul>
Зорилтот бүлэг	Цэцэрлэгийн 490 хүүхэд, тэдний эцэг эх, 53 багш ажилтан
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>• 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс оролцуулан 15 хүнийн бүрэлдэхүүнтэй “Хамтарсан баг” байгуулж, цэцэрлэгийн гадаад орчинд эрсдэл аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийсэн.</li> <li>• Гадаад орчны эрсдэл, аюулгүй байдлын үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн 2019-2020 оны хичээлийн жилд цэцэрлэгийн эргэн тойронд эрсдэл, аюулгүй байдлыг 45 хувиар бууруулах төлөвлөгөө боловсруулан, эцэг эх, бусад талын төлөөлөлтэй хамтран хэрэгжүүлнэ.</li> <li>• Цэцэрлэгийн барилга байгууламжийн өнөөгийн байдал, засвар үйлчилгээ, дулаалгын нөхцөл байдлыг Нийслэл, дүүргийн ЗДТГ болон холбогдох байгууллагуудад танилцуулж 2019-2020 оны хичээлийн жилд их засварт хамрагдаж дээврийн дулаалга, барилгын болон сантехникийн засварын асуудлаа бүрэн шийдсэн байна.</li> <li>• 2019-2020 оны хичээлийн жилд цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг эхийн “Хамтарсан баг”-ийн хяналт, үнэлгээний ажлыг тогтмолжуулж, улирал бүр хэлэлцэн, тодорхой нэг асуудлыг сонгон авч гүйцэтгэнэ.</li> <li>• Хамтарсан багийн цэцэрлэгийн гадаад болон дотоод орчинд хийсэн хөндлөнгийн хяналт, үнэлгээний үр дүнд түшиглэн, цэцэрлэгт тулгамдаад байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга зүй боловсруулан бусад багш, эцэг эхчүүдтэй танилцуулан, тэдний саналыг тусган, улирал бүрээр төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлдэг уламжлалыг бий болгоно.</li> </ul>
Ашигласан эгэх хариуцлагын арга хэрэгсэл	<p><b>Оролцоот бодлого боловсруулалт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хамтарсан баг цэцэрлэгийн бодлого, эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийж, үр дүнгээ цэцэрлэгийн удирдлага, багш ажилтанд танилцуулах ярилцлага зохион байгуулсан.</li> <li>• Ярилцлагын үр дүнд эцэг эх, иргэдээс цэцэрлэгт гаргасан санал хүсэлтийн шийдвэрийг эргэн танилцуулах, ажлаа төлөвлөхдөө хамтарсан багийн</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>хяналт үнэлгээний үр дүн, эцэг эхийн санал санаачилгыг тусгах, энэ талаар эргэн мэдэгдэж байх зохицуулалтыг цэцэрлэгийн дотоод дүрэм, журамд тусган эрхлэгчийн тушаалаар баталгаажууллаа.</p> <p><b>Оролцоот төлөвлөлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Багш ажилтан, эцэг, эхийн төлөөллөөс бүрдсэн “Хамтарсан баг” зохион байгуулалтад орж, цэцэрлэгийн гадаад, дотоод орчинд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийж тулгамдсан асуудлуудыг илрүүлэв.</li> <li>• Цэцэрлэгийн нийт эцэг, эхээс хүүхдийнхээ сурч, хүмүүжиж буй цэцэрлэг сургалт болон орчны талаарх санал сэтгэгдэл, яаралтай шийдэх асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг илрүүлэх, санал асуулга авч үр дүнг нэгтгэв.</li> <li>• Дээрх санал асуулга, хяналт үнэлгээний үр дүнг нэгтгэн цэцэрлэгийнхээ 2019-2020 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулав.</li> <li>• Боловсруулсан төлөвлөгөөгөө батлахын өмнөх цэцэрлэгийн багш ажилтан, эцэг эхийн дунд 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж тэдний саналыг авсан.</li> <li>• Ийнхүү сайжруулсан үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар баталгаажуулж энэ хичээлийн жилд хэрэгжүүлж байна.</li> </ul> <p><b>Иргэдийн үнэлгээний карт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Цэцэрлэгийн удирдлага, багш, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн баг “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хяналтын зөвлөх инженерийн сургалтад хамрагдаж барилгын дулаалга, стандарт, материалын онцлогийн талаар ойлголт, мэдлэгтэй болсон.</li> <li>• Төслийн багаас барилгын дулаалга, засвар үйлчилгээний явцад хөндлөнгийн хяналт үнэлгээ хийхээр боловсруулсан “Үнэлгээний карт буюу аргачлал”-ыг ашиглан засварын эхэн, дунд, эцсийн үнэлгээ хийлээ.</li> <li>• Үнэлгээний үр дүнд тулгуурлан гүйцэтгэгч компанидаа шаардлага тавихын зэрэгцээ төслийн нэгж, цэцэрлэгийн удирдлагад тухайн бүрт нь тайлан боловсруулан илгээсэн юм.</li> <li>• Бид энэ туршлагыг хэрэгжүүлэхдээ нийгмийн эгэх хариуцлагын эдгээр арга хэрэгслийг ашигласнаар хүмүүс аливаа зүйлд өөрсдөө бүтээлчээр оролцсоноор цэцэрлэгийн бодит нөхцөл байдлыг илүүтэй ойлгож, хамтдаа хийж бүтээх хүсэл сонирхолтой болсон. Ингэж цэцэрлэгийг дэмжиж, хөгжүүлэх эрмэлзэлтэй болсон нь нийгмийн эгэх хариуцлага бодит байдалд хэрэгжиж буйн илрэл юм.</li> </ul>
<p><b>Хүрсэн үр дүн (гарц, богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• 2018-2019 оны хичээлийн жилд хамран сургах тойргийн 2-5 настай нийт 850 хүүхдээс 510 хүүхэд манай цэцэрлэгт хамрагдаж, хамран сургалт 82 хувьд хүрсэн.</li> <li>• 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд цэцэрлэгийн барилгын засвар бүрэн дуусаж, эрүүл аюулгүй орчин бүрдүүлсэн.</li> <li>• Цэцэрлэгийн нийт эцэг эх, багш, ажилтнууд хүүхдэд таатай орчин бүрдүүлэхэд идэвх санаачилга гарган, гадна орчинд “Эко-хүрээлэн” ногоон байгууламж бүхий туршилтын талбай, хүүхэд эцэг эхийг угтах өрөөг шинээр тохижуулсан.</li> <li>• Цэцэрлэгийн удирдлагаас эцэг эх, иргэдийн хурал зохион байгуулах арга зүйгээ шинэчлэн тэмдэглэл хийж хэвшсэнээр тэдний оролцоог хянах,</li> </ul>



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>хамтын ажиллагааг хөгжүүлэх гол ажил болсон. Эцэг, эх цэцэрлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагааны туршид хуримтлуулсан туршлагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бодлоготой болсон.</li> </ul>
<p><b>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхамууд</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эхийн зөвлөл, хамтарсан баг цэцэрлэгийн орчны стандарт, аюулгүй байдалд хийсэн хяналт үнэлгээний үр дүнгээ багш ажилтан, эцэг эхчүүдэд танилцуулсан. Энэ хяналт үнэлгээний үр дүн цэцэрлэгийн үйл ажиллагаанд үр өгөөжөө өгч байгаа учир тогтмол хугацаанд хийж гүйцэтгэхээр цэцэрлэгийн бодлого эрх зүйн баримт бичиг болон төлөвлөлтдөө тусгахаар харилцан тохиролцож, ажил хэрэг болгоод байна.</li> <li>• Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний хамтын ажиллагааг бэхжүүлэх үүднээс биеийн тамирын болон урлагийн наадам зэрэг төрөл бүрийн тэмцээнийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг болсон.</li> <li>• Цэцэрлэгийн тулгамдаж буй асуудлаа бодит судалгаа, хяналт үнэлгээний үр дүн, тоо баримтаар баталгаажуулж, бодит нөхцөл байдлаар төр, олон улсын байгууллагат ойлгуулж, бодлогын хүрээнд тусгуулж байх нь хамтран ажиллах, шийдвэрлэх боломж олгодогийг бодит жишээгээр ойлгож, ажил хэрэг болгож эхэллээ.</li> <li>• Жил бүр уламжлал болгон “Хүүхэд насны галт тэрэг” эцэг эх, иргэдтэй хамтарсан үйл ажиллагааг өргөжүүлсэн.</li> </ul>
<p><b>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Цэцэрлэгийн үйл ажиллагаан дахь эцэг эхийн оролцоо бага, хамтын ажиллагааны мэдлэг ойлголт харилцан адилгүй байсан нь багагүй бэрхшээл үүсгэсэн. Тиймээс цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг эхийг бие биеэ ойлгож, эерэг уур амьсгал бүрдүүлэхийн тулд урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулж, тэдний харилцаа хандлагад өөрчлөлт гаргахыг хичээсэн.</li> <li>• Эцэг эхийн мэдлэг боловсрол харилцан адилгүй, өмнө нь цэцэрлэгийн бодлого эрх зүйн баримт бичгийн өөрчлөлт, төлөвлөлтийн үйл явцад оролцож үзээгүй учир удирдах ажилтны амыг харах, санал бодлоо илэн далангүй солилцож чадахгүй, хуулиар хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагаа хангалттай сайн мэдэхгүй байсан. Эрхлэгч, арга зүйч цэцэрлэгийн дотоод зохицуулалт, үйл ажиллагааны онцлог, эцэг эхийн эрх, үүрэг хариуцлагын талаар мэдээлэл бэлтгэн эцэг эхэд хүргэсэн нь энэ асуудлыг шийдэхэд нөлөөлсөн.</li> <li>• Цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтан, эцэг эхчүүд барилгын засвар үйлчилгээ, дулаалгын ажлын явцын талаар мэдлэг дутмаг, гүйцэтгэгч компани ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадвар харилцан адилгүй учир засвар болон явцын хяналт үнэлгээний ажил эхлэхийн өмнө ойлголт, төсөөлөл харилцан адилгүй нь нэлээд бэрхшээлийг бий болгосон. Харин хяналтын зөвлөх инженер тусгайлан сургалт зохион байгуулсан нь бүгд нэг ойлголт, мэдэгдэхүүнтэйгээр ажлаа эхлэхэд ихээхэн дэмжлэг болсон</li> </ul>
<p><b>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс (үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч, орон нутгийн</b></p>	<p><b>Цэцэрлэгийн зүгээс:</b> Засгийн газар, нийслэл, дүүргийн үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөлтөө хийж, эцэг эхийн оролцоо хамтын ажиллагааг дэмжихэд удирдлага, багш, ажилтнууд баг болж хамтран ажилласан. Энэ ажлын хэрэгжүүлэх явцдаа нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслийг ашиглаж сурсан бөгөөд аль болох цэцэрлэгийнхээ бусад үйл ажиллагаатай уялдаж зохицуулахыг хичээн ажилласан.</p>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

<p><b>удирдлага, бусад оролцогчид</b></p>	<p><b>Эцэг эхийн зүгээс:</b> Цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хөндлөнгийн үнэлгээ хийсэн. Цэцэрлэгийн гадаад болон дотоод орчны үнэлгээг хийхдээ хэрэгцээг тодорхойлон хэрэгжүүлэх, бүтээлч санал, санаачилга гарган оролцохыг эрмэлзэж байсан. Энэ нь цэцэрлэгийн үйл ажиллагаа эцэг эхэд нээлттэй, ил тод болоход ихээхэн түлхэц үзүүлсэн.</p> <p><b>Бусад байгууллагын зүгээс:</b> Эцэг эх, иргэд, төр ба төрийн бус байгууллага, олон нийтийг цэцэрлэгийн үйл ажиллагаанд татан оролцуулах, хамтын ажиллагааг сайжруулах, сургалт сурталчилгаа хийх, үр дүнг тооцох, урамшуулах, алдаршуулах ажлыг цэцэрлэгийн зүгээс тусгайлан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн.</p>
<p><b>Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл</b></p>	<p><b>О.Эрдэнэцэцэг: (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 62 дугаар цэцэрлэгийн арга зүйч)</b></p> <p>Төсөл хэрэгжихэд цэцэрлэгийн удирдлага, ТББ, эцэг эх, иргэд бүгд нэгдэн цэцэрлэгийн бодлого, хэрэгжилт, хөндлөнгийн үнэлгээ, судалгаа хийхэд багийн зохион байгуулалтад орж, харилцан дэмжлэг үзүүлж, нэгэн зорилгын төлөө нэгдэж ажиллаа. Энэ ажилд оролцоноор хөндлөнгийн хяналт үнэлгээ нь ямар үр дүнтэй ажил болохыг ойлгож авлаа. Сургалтын аюулгүй орчин бүрдүүлэх ажилд эцэг эх, асран хамгаалагчдын санаачилга, оролцоо дээшилснээр сургалтын чанар ч эрс дээшилсэн. Энэ ажил цэцэрлэгийн үйл ажиллагаанд олон талаараа нөлөөлж сургалт, танин мэдэхүйн орчинг өөрчлөлтийг бий болгож байна.</p> <p><b>Э. Баярмаа: (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 62 дугаар цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл)</b></p> <p>Манай хоёр хүүхэд 62 дугаар цэцэрлэгт явдаг. Энэ зун хүүхдийнхээ цэцэрлэгийн засварын ажилд хяналт тавьж, хамтарсан багт орж ажилласан. Цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагаа, орчны нөхцөл урд нь ямар байсан, одоо хэрхэн өөрчлөгдөж байгааг сайн мэддэг хүний нэг гэж өөрийгөө боддог. Эцэг эхийн оролцоо хамтын ажиллагаа цэцэрлэгийн үйл ажиллагаанд ямар их нөлөөтэй, ач тустай болохыг одоо л сайн ойлгож мэдэрлээ. Хүүхдийн сайн сайхны төлөө цэцэрлэг- эцэг эх, иргэд, олон нийтийн байгууллагууд хамтран ажиллах нь нийгмийн хариуцлага гэдгийг ухамсарласан. Хүүхдийнхээ цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангахад гар бие оролцсондоо баяртай байна.</p>
<p><b>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Нийт багш, ажилтан, эцэг эх, иргэдийн хамтын ажиллагаа, бага насны хүүхдэд зориулсан эрсдэл аюулгүй орчин, хамгаалалал, түүний ач холбогдлын талаарх ойлголт харилцан адилгүй юм. Иймд аль болох нэгдсэн мэдээллээр хангаж орчныг зургийг хэрхэн хийдэг, хяналт үнэлгээний онцлог, анхаарах асуудлыг үйл ажиллагаа эхлэхийн өмнө ухуулан танилцуулах.</li> <li>• Орчны зураглал хийх, хяналтын хуудсаар үнэлэх, дүгнэх арга зүйд суралцуулах.</li> <li>• Цэцэрлэгээс эцэг эх, олон нийтийн оролцоот үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, бүхий л талаар дэмжиж ажиллах.</li> <li>• Эцэг эх олон нийтийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг эргэж мэдээлэх, олон нийтэд хүргэх сурталчлах.</li> <li>• Байгаль, цаг агаарын болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг сайн төлөвлөх нь учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

### Холбоо барих хаяг:



### Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 62 дугаар цэцэрлэг

Эрхлэгч Н.Алтанцэцэг (Утас: 99818622, э-шуудан: [altaa\\_3@yahoo.com](mailto:altaa_3@yahoo.com))  
 Эмч Д.Жаргал (Утас: 99837390, э-шуудан: [emch\\_62@yahoo.com](mailto:emch_62@yahoo.com))  
 Багш Б.Оюунтуяа (Утас: 88701399, э-шуудан: [oyuntuuya\\_62@yahoo.com](mailto:oyuntuuya_62@yahoo.com))  
 Багш Б.Болорцэцэг (Утас: 99204628, э-шуудан: [boloroo\\_@yahoo.com](mailto:boloroo_@yahoo.com))

### ЭЦЭГ ЭХЧҮҮД ЭЭ! ТА ХҮҮХЭДДЭЭ

ЯМАР Ч ҮЕД БИЕЭ ЗӨВ АВЧ ЯВЖ, ТУХАЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ЗӨВ ҮНЭЛГЭЭ ХИЙЖ ЭРСДЭЛЭЭС ӨӨРИЙГӨӨ ХЭРХЭН ХАМГААЛЖ СУРАХ ТАЛААР БАЙНГА ЯРИЛЦАЖ, ЗААЖ СУРГАЖ, ЗӨВӨӨР ҮЛГЭРЛЭЖ БАЙГААРАЙ!

**Аюулгүй орчны зааварчилгааны санамж**

1. Цэцэрлэгийн хүүхдийг насанд хүрсэн хүн хүргэж өгч, хүлээж авна.
2. Та хүүхдээ багшид хүлээлгэн өгч, багшаас хүлээн авч байгаарай.
3. Ногоон гэрэл ассан үед л зам хөндлөн гараарай.
4. Зам хөндлөн гарахдаа заавал явган хүний гарцаар гараарай.
5. Авто машины зам дээр тоглож болохгүйг сануулаарай.
6. Машины дундуур гүйхгүй, заавал машины араар болгоомжтой гарч байхыг ойлгуулаарай.
7. Цэцэрлэгийн хашааны хаалгаар орчноо ажиглахгүйгээр ганцаараа гүйж гарч болохгүйг сануулаарай.
8. Та хүүхдээ цэцэрлэгтээ ирэх аюулгүй зам, гарцыг зааж өгөөрэй.
9. Та аюулгүй орчны зураглалыг хүүхдэд тайлбарлан өгч ярилцаарай

ХҮҮХДИЙГ ӨӨРИЙГӨӨ АВЧ ЯВАХ ЧАДВАРТАЙ БОЛОХОД НЬ ДЭМЖИН ТУСАЛЦГААЯ

**Таних тэмдэг**

- Зогсоол
- Автобусны буудал
- Төв зам
- Цэцэрлэгийн гадна орчин
- Цэцэрлэгийн орчин
- Бохирын шугам
- Бохирын цооног
- Цэвэр усны шугам
- Дулааны шугам

## ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД “ХАМТАРСАН БАГ”-ИЙН ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

<b>Зорилго</b>	Хүүхдэд ээлтэй боловсролын үйлчилгээг эрхэмлэх, хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг хангасан, эрүүл, аюулгүй тав тухтай орчинг бүрдүүлэх
<b>Нөхцөл байдал тулгамдсан асуудал</b>	<p>Бага насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүй гүйцэд төлөвшөөгүй учир тэдэнд байнга насанд хүрэгчдийн халамж анхаарал, хамгаалал шаардлагатай байдаг. Манай цэцэрлэг хүүхдийн эрхийг дээдэлсэн, хүүхдэд ээлтэй цэцэрлэг болох нөхцөлийг бүрдүүлэхийн тулд удирдлага, багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн “Хамтарсан баг” байгуулсан.</p> <p><b>Хамтарсан багийн гишүүд цэцэрлэгийн өнөөгийн нөхцөл байдлыг судлан үзэхэд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхэд, эцэг эхийн хөгжлийн танхим, өрөөний хангамж хангалтгүй.</li> <li>• 190 хүүхдийн хүчин чадалтай ажиллах цэцэрлэгт ойролцоогоор 280 хүүхэд сурч хүмүүждэг.</li> <li>• Хүүхэд, эцэг эхийн хөгжлийн танхим, ёс заншлын танхим, хүүхдийн номын сан, эцэг эхэд зөвлөгөө өгөх төв зэрэг бага насны хүүхдийн</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>хөгжлийг дэмжих, үйлчилгээ үзүүлэхэд зориулагдсан өрөө тасалгаа зайлшгүй шаардлагатай болсон.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Манай цэцэрлэг төв авто замаас 50м орчим зайд ойрхон оршдог тул бага насны хүүхдийг зам тээврийн ослоос сэргийлэх, аюулгүй орчин бүрдүүлэх ажил бидний хамгийн тулгамдсан бэрхшээлтэй асуудлын нэг болсон.</li> <li>• Дээрх нөхцөл байдал, тулгамдсан асуудлаас үүдэн хүүхдэд тавих анхаарал, халамжийг сайжруулахад эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх сургалт сурталчилгааг хийх, хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах эрхийг хангах, аюулгүй орчин, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг сайжруулах зэрэгт анхаарч хамтран ажиллахаас “Хамтарсан баг” ажлаа эхэлсэн. Хамтарсан баг нь өөрсдийн хийж хэрэгжүүлэх ажлаа хүүхдэд ээлтэй байхаар тодорхойлж, бодлого төлөвлөлтдөө тусган, цэцэрлэгийн бусад ажилтай уялдуулан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг хичээсэн.</li> </ul>
<b>Зорилтот бүлэг</b>	Цэцэрлэгийн 500 хүүхэд, тэдний эцэг эх, 53 багш ажилтан
<b>Шалгуур үзүүлэлт</b>	<ul style="list-style-type: none"> <li>• 2018-2019 оны хичээлийн жилд хамран сургах тойргийн 2-5 настай бага насны нийт хүүхдийн 88.2 хувийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, улсын дундаж түвшинд хүрсэн байх.</li> <li>• 2019-2020 оны хичээлийн жилд цэцэрлэгийн хэмжээнд стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийн тоог 52 болгож нэмэгдүүлэх.</li> <li>• БСШУ-ны сайд, ЭМС-ын сайд, Сангийн сайдын 2015 оны А\253\251\173 тоот хамтарсан тушаалын дагуу 100 хувь аюулгүй ундны усаар хангагдсан байх</li> <li>• Гадна орчны гэрэлтүүлэг 60 хувь байгааг 2020 онд 100 хувьд хүргэнэ.</li> <li>• Цэцэрлэгийн камерын тоо 24 буюу 60 хувь байгааг 2020 он гэхэд 25 хувиар нэмэгдүүлж ний орчны 85 хувийг бүрэн камержуулсан байна.</li> <li>• 2019-2020 оны хичээлийн жилд цэцэрлэгийн гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулан налуу замыг 2 хэсэгт нэмэгдүүлэх</li> <li>• 2019 оны 9 сар гэхэд “Эцэг эх, хүүхдэд зөвлөгөө өгөх” жишиг төвтэй болох</li> </ul>
<b>Ашигласан эгэх хариуцлагын хэрэгсэл</b>	<p><b>Иргэдийн оролцоот аудит:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хамтарсан багийн гишүүд “Сайн цэцэрлэгийг дэмжих аргачлал”-ын дагуу цэцэрлэгийн засаглал, сэтгэл зүй, материаллаг орчны үнэлгээг хийж, тулгамдаж байгаа асуудлуудаа тодорхойлон, “Дэмжих төлөвлөгөө” боловсруулж, удирдлагуудтайгаа хамтран хэрэгжүүлж байна.</li> <li>• Засаглалын орчин: цэцэрлэгийн зөвлөлийг эрхлэгчийн тушаалаар байгуулан, цэцэрлэгийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны гэрээ, мэдээллийг эцэг эхэд нээлттэй байдлаар мэдээлсэн.</li> <li>• Цэцэрлэгийн дүрмийг талуудын оролцоотойгоор шинэчлэн боловсруулж, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлсэн.</li> <li>• Сэтгэл зүйн орчин: Хамтарсан баг эцэг эхчүүдэд зориулан “Хүмүүжлийн эерэг арга” сургалтыг зохион байгуулсан. Мөн “Хүүхдийн</li> </ul>



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА


	<p>насны онцлог” сэдвээр бүлэг бүр эцэг эхийн сургалтыг зохион байгуулж, хүүхдийн насны онцлог болон хүүхдийн чадвар чадамжийг мэдүүлсэн. Бэлтгэл, ахлах бүлгийн хүүхдүүдийн дунд “Өсөхөөс сурсан үндэсний хэл” аман наадам, “Миний сайхан цэцэрлэг” гар зургийн уралдаан, уламжлалт өдөрлөгүүдийг амжилттай зохион байгуулсан. Бүх бүлгүүдийн дунд “Авхаалжтай жаалууд” тэмцээн зохиосон. Багш ажилчдын дунд “АХА” тэмцээн явууллаа.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Материаллаг орчин: Бүлгүүдийн өрөөний хурц ирмэгтэй эд зүйлс, тавилга хэрэгсэлийг хөдөлгөөнгүй тогтвортой байрлуулж, хүүхэд бэртэж гэмтэхээс сэргийлсэн (булангуудын зөөлөвч наалт, сандлын зөөлөвч, гэх мэт). Эцэг, эхийн оролцоотой ойр орчмын замыг засаж сайжруулсан. Хүүхдийн цэцэрлэгт ирэх, буцах замын “Аюулгүйн зураглал”-ыг гаргаж, ангийн ариун цэврийн өрөөнүүдийн шалыг халтиргаагүй, аюулгүй болгож сайжруулсан.</li> </ul>
<p><b>Хүрсэн үр дүн (гарц, богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• 2018-2019 оны хичээлийн жилд 150 хүүхдийн багтаамжтай өргөтгөлийн барилга шинээр ашиглалтад орж хамран сургах тойргийн 250 хүүхэд хамрагдсан.</li> <li>• Сайн эцэг эх сургалтын хөтөлбөрийг боловсруулан сургалт зохион байгуулж, эцэг эхийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх зорилгоор “Насан туршийн боловсрол төв”-тэй хамтран сургалт зохион байгуулж, нийт 130 эцэг, эх оролцож хамрагдалтын хувь 52.6 байлаа.</li> <li>• Цэцэрлэгийн орчинд хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд “Аав аа ээж ээ намайг авто машинаас хамгаалаач” тэмдгийг хашааны гадна байрлуулсан. Мөн хүүхдийн аюулгүй, халдашгүй, байдлыг хангах зорилгоор цэцэрлэгт камерын хяналтын системийг нэвтрүүлсэн.</li> <li>• Цэцэрлэгийн хүүхдүүдийн хаяг, байршлын судалгаа гаргаж, олон хүүхэд явдаг гэр хорооллын гудамжийг гэрэлтүүлэгтэй болгох, гэрэлтүүлгийг сайжруулах, золбин нохой байдаг эсэхийг судлах, явган хүний замыг сайжруулах, өвлийн улиралд ус тогтож хөлдөөд халтиргаа, гулгаа үүсгэдэг гудамж замыг засаж, янзлах, ойр орчмын архи, тамхи худалдаалдаг дэлгүүр, түргэн үйлчилгээний цэгүүдийг цөөлж, зохицуулалт хийж, хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлэх тухай асуудлыг харъяа хорооны засаг дарга, ИХ-ийн төлөөлөгчид болон бусад хамтран ажилладаг байгууллагуудын оролцоо дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</li> <li>• “Монголын хөгжлийн төлөө төв” ТББ-тай хамтран “<b>Эрдэнэсийн уурхайг нээхүй</b>” зан чанар харилцааны төсөл, хөтөлбөрийг хүүхэд, багш, эцэг эхийн дунд хэрэгжүүлэн ажиллаж байна.</li> <li>• 9, 10, 11, 12, 3, 4, 5 саруудад БЗД-ийн ЗЦХ-тэй хамтран “Kinder Police” аяныг цэцэрлэгийн 6 бүлгийн 138 эцэг эхийг хамарч, хүүхдийг зориулалтын суудал, өндөрлөгчийг хэрэглэж хэвшсэн эсэхэд хяналт тавихад 60%-тай, нийт 290 эцэг эхэд зөвлөмж зөвлөгөөг өгч ажилласан.</li> </ul>

- “Гэр бүл хүүхэд хөгжлийн анхдагч орчин” сэдэвт цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж хэвшсэн. Мөн “Хүүхэд хүүхэддээ туслах хөдөлгөөн”-ийг өрнүүлэн, хүнд нөхцөлд байгаа хүүхдэд туслах үйл ажиллагааг эцэг эх дэмжин оролцож, 5 өрх айлд тусламж үзүүлсэн \хүнс, хувцас, хичээлийн хэрэглэл, тоглоом гэх мэт\.
- “Гэр бүлийн үнэт зүйл, өрх бүрийн бахархал” сэдвийн хүрээнд “Аав, ээж, би” тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулдаг. Цэцэрлэгийн зүгээс гамшгийн үед хүүхдийн эрхийг хамгаалах, тэдэнд тусламж үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэн, гамшгаас хамгаалах, дадлага сургуулилтыг жил бүр тогтмол хийж, энэ үйл ажиллагаанд эцэг эх, багш ажилтанг татан оролцуулдаг. Цэцэрлэгийн хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, сурталчилгаа нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан.
- 2019 оны 3 дугаар улиралд анги бүлгүүд болон ажиллагсадын ариун цэврийн өрөө, ариун цэврийн байгууламжийн байдал сайжирч, стандартад нийцсэн 58 ариун цэврийн байгууламжтай болсон.
- Ундны усны шинжилгээгээ аюулгүй ундны усны шаардлагыг ханган, 100 хувь аюулгүй ундны усаар хангагдсан.
- Цэцэрлэгийн хаягийг лед гэрлээр хийж, явган хүний замын гэрэлтүүлгийн тоог хоёроор нэмсэн.
- Цэцэрлэгийн камерын тоо нэмэгдэж одоо цэцэрлэгийн А, Б байранд нийт 34 камер бүрэн ажиллаж байна.
- Цэцэрлэгийн гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулан налуу замыг цэцэрлэгийн А, Б байрны хэсэгт хийж, тэгш хамруулан сургах орчинг бүрдүүлсэн.
- Энэ төсөл хэрэгжсэнээр барилгын ашиглагдахгүй байсан сул талбайг “Угтах хэсэг”, хоёр давхарын фасадыг “Эцэг эх, хүүхдэд зөвлөгөө өгөх төв”, “Ёс заншлын өргөө” болгон өөрчилж, эцэг, эхчүүдийг хүүхэдтэйгээ хамтдаа цагийг үр дүнтэй өнгөрөөх орон зайг бий болгож чадлаа.
- 9 дүгээр сарын байдлаар “Эцэг эх, хүүхдэд зөвлөгөө өгөх төв”-өөр давхардсан тоогоор 102 эцэг эх, багш ажилтан, хүүхэд үйлчлүүлжээ.
- Багтаамж муутай, өрөө тасалгаа хүрэлцээгүй боловч өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан, бүлэг бүрт номын булан, багшийн хөгжил танхимын номын санд түшиглэн, хүүхэд эцэг эхэд зориулсан номын сан, 1, 2 дугаар давхарын нийтийн эзэмшлийн талбайн зайг ашиглан ёс заншлын өргөө (гэр), шатар, даам, шагай тоглох буланг тус тус тохижуулан ашигласан. Эцэг эх, багш ажилтан, хүүхдийн дунд “Номын богц” аялуулан нийт 190 эцэг эх, хүүхэд, 21 багш ажилтан номын сангаас ном авч уншсан байна. Өдөрт 8 эцэг эх, номын сангийн байнгын уншигч болсон бөгөөд картаар ном захиалан авч уншиж байна.

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн хөгжил төлөвшлийн анхдагч орчин гэр бүл, эцэг эхийн хандлагыг өөрчлөх, хүүхдийг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд хамтран ажиллах, үүрэг оролцоог сайжруулах.</li> </ul>
<p><b>Үр дүнг тогтворжуулахад хийсэн алхмууд</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эх олон нийтийг хамарсан бүтээлч ажлуудыг зохион байгуулсан.</li> <li>• “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх нь”, “Хүүхэд нэг эрдэнэ-Хүмүүжил мянган эрдэнэ” сэдэвт сургалт, “хүүхдийг зодож шийтгэхгүй өдөр” зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан.</li> <li>• Хамтарсан баг хүүхдэд чиглэсэн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэн, хяналт шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг сайжруулан ажилласан</li> <li>• Хүүхдэд ээлтэй хичээл, үйл ажиллагаа, орчин бүрдүүлсэн багш, ажиллагсадыг дэмжин урамшуулсан</li> <li>• Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэлт, сургалтын хэрэглэгдэхүүний шалгаруулалтыг бүсийн цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулж, туршлагаа түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна.</li> </ul>
<p><b>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэдийгээр эцэг эх, асран хамгаалагчдыг цэцэрлэгийн бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах олон талт ажлыг зохион байгуулдаг ч эцэг эхийн зүгээс хүүхдийн хөгжил, төлөвшлийн талаар багштай нягт хамтран ажиллахгүй, хүүхдээ сонсохгүй, ажлаа хүүхдээсээ илүүд үздэг, нээлттэй дотно харилцдаггүй, хүүхдэд анхаарал тавьдаггүй, буруу дутуу ойлгодог, хэтэрхий дураар нь байлгах буюу эсвэл өөрийнхөөрөө байлгах зэрэг алдаатай, мэдлэг дутмаг байдал гаргадаг.</li> <li>• Мэдээлэл хүлээн авах бүртгэл хөтлөлтийн үйл ажиллагаанд туршлага дутсан. Энэ асуудлыг шийдвэрлэхээр мэдээлэл хүлээн авах дэвтэртэй болсон. Эцэг эхэд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн талаар зөвлөгөө, зөвлөмж өгдөг болсон.</li> <li>• Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт байхгүй. Эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийгдээгүй.</li> </ul>
<p><b>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</b></p>	<p><b>Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс:</b></p> <p>Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн тэдний хөгжлийг дэмжин, богино хугацаанд үр дүнд хүргэж болохыг харуулсан, мөн хүмүүст итгэл, урам өгсөн юм.</p> <p>Амжилтад нөлөөлсөн гол зүйлийн нэг нь сургалт, арга зүйн зөвлөмж, ололт амжилт, дутагдлын талаар харилцан ярилцаж, хэлэлцүүлэг хийдэг байсан нь амжилтад нөлөөлсөн.</p> <p>Бас нэг амжилтад нөлөөлсөн арга нь баг болон ажиллах арга зүйд суралцуулсан, мэдрүүлсэн зохион байгуулалт байлаа.</p> <p>Зөвлөн туслах арга зүйн зөвлөмж нь багийн гишүүдийн гол гарын авлага, үндсэн чиглүүлэг болж байв.</p>
<p><b>Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Б.Болорцэцэг (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 62 дугаар цэцэрлэгийн багш):</b> Миний энэ төслөөс суралцсан нэг чухал зүйл бол үнэлгээ мониторинг хийх, зөвлөн туслах арга зүй байлаа. Энэ төслийн зөвлөн туслах</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>багтай цэцэрлэгээр явах болоход цэцэрлэгийн ажилтай л танилцах юм байх даа гэж бодож байлаа. Гэтэл цэцэрлэг бүрийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай нэг бүрчлэн танилцаж, зөвлөгөө өгч, баримт бичиг, график, зураг хүснэгт, таблиц зэрэг бүхий л боломжит хувилбаруудыг санал болгож байв. Зөвлөж байгаа зүйлээ хэрхэн амьдралд хэрэгжүүлэх талаар оновчтой, бодит байдлаар тайлбарлан таниулж байсан нь маш сайхан байлаа. Манай цэцэрлэгийн багш ажилтан, эцэг бид нийгмийн эгэх хариуцлагын талаар ойлголт, мэдлэгтэй болсон.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>А.Уянга (Нийслэлийн Баянзүрх дүүргийн 62 дугаар цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл):</b> Хүүхдийн маань сурч хөгжих орчин сайжирч байгаад баяртай байна. Аялалаар явж засварын ажил яаж явагдаж байгаатай танилцсан маань өөрийн цэцэрлэгтээ харьцуулан манайд юу дутагдалтай байгаа талаар харилцан туршлага солилцсон. Бидний сэтгэл ханамж маш өндөр байсан. Сургалт болон арга зүйн зөвлөмж таалагдсан.</li> </ul>
<p><b>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйл</b></p>	<p>Үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх бүх үйл явцыг багаар ажиллах, санал солилцох, зөвлөлдөх, оролцуулах, зарчмыг дэмжиж ажиллах</p>
<p><b>Холбоо барих хаяг</b></p> 	<p><b>Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 62 дугаар цэцэрлэг</b>          Эрхлэгч Н.Алтанцэцэг (Утас: 99818622, э-шуудан: <a href="mailto:altaa_3@yahoo.com">altaa_3@yahoo.com</a>)          Эмч Д.Жаргал (Утас: 99837390, э-шуудан: <a href="mailto:emch_62@yahoo.com">emch_62@yahoo.com</a>)          Багш Б.Оюунтуяа (Утас: 88701399, э-шуудан: <a href="mailto:oyuntuya_62@yahoo.com">oyuntuya_62@yahoo.com</a>)          Багш Б.Болорцэцэг (Утас: 99204628, э-шуудан: <a href="mailto:boloroo@yahoo.com">boloroo@yahoo.com</a>)</p>



ЗУРГИЙН ЦОМОГ



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



## НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ТЭРГҮҮНИЙ 91 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ



- Бидний тухай
- “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл” манай цэцэрлэгт
- Бусадтай хуваалцах бидний сайн туршлага
- Зургийн цомог

## БИДНИЙ ТУХАЙ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн тэргүүний 91 дүгээр цэцэрлэг 1983 онд 280 хүүхэд, 38 багш, ажилтантай сургалт хүмүүжлийн ажлаа эхэлснээс хойш 36 дахь хичээлийн жилдээ амжилттай ажиллаж байна. Манай цэцэрлэг баруун талаараа Сонгинохайрхан дүүргийн Ханын материалын 58 дугаар байр, хойд талаараа ерөнхий боловсролын 9 дүгээр сургууль, зүүн болон урд талаараа гэр хороололтой хиллэн 10,370м<sup>2</sup> талбайд байрладаг.

2015 оны 11 дүгээр сард дөрвөн бүлэг бүхий 100 хүүхдийн өргөтгөл ашиглалтад орж, одоогийн байдлаар 380 хүүхдийн хүчин чадалтай барилгад Сонгинохайрхан дүүргийн 5, 6, 23 дугаар хорооны хамран сургах тойргийн 720 гаруй хүүхдийг 16 бүлэгт хуваарилан сургуулийн өмнөх боловсролыг олгож байна.

Манай цэцэрлэг 3 магистр, 16 бакалавр, 3 тэргүүлэх, 9 заах аргач мэргэжлийн зэрэгтэй буюу нийт 19 багш, 37 ажилтан ажилладаг. Тэднээс 4 багш, ажилтан Алтан гадас, 6 багш Боловсролын тэргүүний ажилтан цол тэмдэгтэй, 8 багш БСШУСЯ-ны “Жуух бичиг”-тэй болно.

### Бидний амжилт:

- 2015 онд Нийслэлийн “Эрүүл мэндийг дэмжигч” байгууллага
- 2018 онд Нийслэлийн хүүхдэд ээлтэй байгууллага,
- 2018 онд Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын “Шилдэг хошой байгууллага”
- 2016 онд Сонгинохайрхан дүүргийн Тэргүүний цэцэрлэгээр тус тус шалгарав.

## “МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ МАНАЙ ЦЭЦЭРЛЭГТ

### Б.Цасцэцэг (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 91 дүгээр цэцэрлэгийн нярав):

Өнгөрсөн хичээлийн жилээс “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл манай цэцэрлэгт хэрэгжиж эхэлсэн. Энэ ажлын хүрээнд цэцэрлэгийн гадна талд дулаалгын фасад хийж, нийт 110 цонх сольсон. Үүнээс дахин хэрэглэх боломжгүй 15 модон цонх эвдэрч, үлдсэн 95 вакуум цонхыг Нийслэлийн төсөвт хоёр дахь түүхий эдийн зориулалтаар төвлөрүүлэн тушаасан. Мөн гурван хос халуун, хүйтний 50 метр шугам, нийт 150 метр шугам хуванцар трубагаар хийсэн байсныг устгалаа.





## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

Цэцэрлэгийн төсвийн санхүүжилтээр төдийлөн шийдэж чаддаггүй барилга байгууламж, сантехникийн томоохон асуудлыг энэ төслийн хүрээнд шийдэж өгсөнд маш их баяртай байна. Тав тухтай тохилог орчинд ажиллаж, суралцахад хүн бүр баяртай, инээмсэглэл дүүрэн байдаг.

### **Ц.Мөнхбаяр (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 91 дүгээр цэцэрлэгийн эцэг, эхийн төлөөлөл):**

Төслийн хүрээнд анги бүлгүүдийн ариун цэврийн өрөөг бүрэн шинэчлэх, барилгын гадна фасадын дулаалга хийх зэрэг олон ажил хийгдсэн. Эцэг, эхийн төлөөлөл барилгын засварын үйл явцад хяналт тавьж ажиллалаа. Барилгын засвар, дулаалгын ажил оройтож эхэлснээс явц удаашралтай байсан нь хүндрэлтэй санагдсан. Хяналт тавих явцад бидэнд ажиглагдсан нэг зүйл тендэрт ялсан компанийн хүний нөөц дутмаг байсан. Харин барилгын материал, түүхий эдийн хувьд стандартын дагуу хангалттай сайн байсан. Засварын явцад ямар нэг зөрчил дутагдал гараагүй. Эцэг, эх засварын үйл явцад хяналт тавьснаар өөрсдөө ч барилгын засвар үйлчилгээний стандарт, барилгын материал, дулаалгын технологийн талаар ойлголттой боллоо. Өөрийн биеэр оролцож байж л бодит байдлыг илүү мэдэрч, ойлгодог юм байна.



Хүн

### **Ш.Мөнх- Амгалан (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 91 дүгээр цэцэрлэгийн ахлах тогооч, хамтарсан багийн гишүүн):**



Манай цэцэрлэгийн гал тогоонд засвар орохоос өмнө цонхоор маш их дулаан алддаг, тааз цанатаж мөстсөнөөс байнга дусаал гоожиж, шалан дээр ус их тогтдог байсан. Засвар хийгдсэнээс хойш цонхоор дулаан алдахаа больсон. Уур, цана ч багассан. Дээврийн дулаалга хийгдсэнээр хана тааз хөлөрч, мөөгөнцөр үүсдэг байсан нь арилсан. Манай цэцэрлэг энэ төсөлд хамрагдан эрсдэл аюулгүй орчин бүхий, тохилог болсондоо багш, ажилчид бид маш их баяртай байна. Миний хувьд хамт олноо төлөөлөн хамтарсан багийн гишүүнээр ажиллан, барилгын засвар, дулаалгын явцад хөндлөнгийн хяналт тавьж ажиллалаа. Тендэрт ялсан компани чанар сайтай материал ашиглаж засварын ажлыг их сайн гүйцэтгэсэн. Гагцхүү хүн хүчний хүрэлцээ багаас шалтгаалж засварын ажил удаашрахад нөлөөлсөн.



**Бусадтай хуваалцах бидний сайн туршлага:**

**ЦЭЦЭРЛЭГИЙН ОРЧИН ГУРАВДАГЧ БАГШ**

<b>Зорилго</b>	Бага насны хүүхдийг анги танхимдаа сурч хөгжих, эрсдэлгүй, аюулгүй орчинг эцэг эх, асран хамгаалагчийн хөндлөнгийн хяналт, оролцоотой бүрдүүлэх
<b>Нөхцөл байдал, тулгамдсан асуудал</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд 2-3 насныхаа хөгжил, онцлогоос хамаарч зорилгогүй хөдөлгөөн их хийдэг, анхаарал төвлөрөл сул, хөл, гарын жижиг булчин төдийлөн хөгжөөгүй учир орчны аюул ослоос өөрийгөө хамгаалах чадвар сул байдаг. Иймээс энэ насныханд насанд хүрэгчдийн зүгээс тавих анхаарал халамж сайн байх шаардлагатай.</li> <li>- Бүлэг бүрт багш, туслах багш байнга анхаарал тавьж, хүүхдүүдийг харж ханддаг ч 2018-2019 оны хичээлийн жилд 2-3 насны зургаан хүүхэд хөнгөн, гурван хүүхэд дунд зэргийн гэмтэл авсан.</li> <li>- Хүүхэд гэмтсэнээс үүдэн эцэг, эх ажлаасаа чөлөө авч хүүхдээ асрах тохиолдолд өрхийн орлого, амьжиргаанд тодорхой хэмжээний хүндрэл учруулж байв.</li> <li>- Хүүхдийн хувьд гэмтэл авч гэртээ долоогоос дээш хоног байх тохиолдолд, эргэж цэцэрлэгийн орчиндоо дасан зохицохгүй уйлах, ангийнхантайгаа ойлголцохгүй, тоглохгүй багшид давхар ачаалал үүсгэж байсан.</li> <li>- Цэцэрлэгийн хувьд хүүхэд бүртгэлтэй хэдий ч долоогоос дээш хоног цэцэрлэгтээ ирэхгүй, ирцийн бүртгэлд ороогүй тохиолдолд цэцэрлэгийн хүүхдийн тоо буурч, ирэх жилийн төсөвт нөлөөлдөг. Энэ тохиолдолд тухайн хүүхэд харьяаллын дагуу бүртгэлтэй ч, төсөвт тухайн хүүхдийн зардалд тусаагүй бол хүүхдийг элсүүлэхэд хэцүү болдог. Үүнийг эцэг эх ойлгохгүйгээс, үл ойлголцол үүсдэг байсан.</li> <li>- Цэцэрлэгийн ачааллаас хамаарч, багш ихэнх тохиолдолд хүүхэд бүрт хүрч, анхаарал халамж тавихад хүндрэлтэй. Ялангуяа 2-3 настай хүүхдийн хөдөлгөөний хурд, ангийн эрсдэлтэй орчноос хамаарч, хүүхэд гэмтэж бэртэх вий гэсэн багшийн байнгын санаа зовнил, стресс хөдөлмөрийн бүтээмж буурахад нөлөөлж, хүүхдийн сургалт, хөгжлийн үндсэн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулах байдал буурсан.</li> <li>- Дээрх байдалд үндэслэн 2018-2019 оны хичээлийн жилд эцэг, эхийн зүгээс “Эцэг, эхийн төлөөлөл хүүхдийнхээ ангид ажиглалт хийж үзье. Хүүхдүүд хөдөлгөөн ихтэйгээс болж гүйж байгаад бүдрэх, халтирч унах, ширээ, сандлын булан тохой мөргөх зэрэг ахуйгаас үүдэлтэй гэмтэлд өртөөд байна. Тиймээс ангид ажиглалт хийж үзээд, шийдэх боломжтой, ангийн эрсдэлийг бууруулахад анхаарч, хамтарч ажиллая” гэсэн санаачилга гарган, багшид хандсан.</li> </ul>
<b>Зорилтот бүлэг</b>	2-3 настай 4 бага бүлгийн 140 хүүхэд, 3-4 настай дунд 4 бүлгийн 180 хүүхэд, тэдний бүлгий багш, туслах багш болон эцэг эх
	<ul style="list-style-type: none"> <li>- Анги танхим, цэцэрлэгийн ахуйн орчноос хамаарсан хүүхдийн осол гэмтэл буурсан хувь</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

<b>Шалгуур үзүүлэлт</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нарын орчноос хамааран, хүүхэд осол гэмтэлд өртөх вий гэсэн сэтгэл зовинол буурч үндсэн ажилдаа тавих анхаарал нэмэгдсэн хувь</li> <li>- Хүүхдийн осол гэмтэлтэй холбоотой эцэг, эхээс ирсэн гомдол санал буурсан тоо</li> <li>- Цэцэрлэгийн орчинд хүүхдүүдийн дасан зохицох хувь</li> <li>- Эрсдэлээс хамгаалсан, аюулгүй орчин бүрдүүлсэн анги танхимын тоо</li> <li>- Осол гэмтэл бууруулах зорилгоор бүрдүүлсэн орчны талаарх эцэг эхийн сэтгэл ханамжийн хувь</li> <li>- Нийт анги танхимын цахилгаан хэрэгслийн хамгаалалт, аюулгүй байдал хангалтын хувь</li> </ul>
<b>Ашигласан эгэх хариуцлагын хэрэгсэл</b>	<p><b>Оролцоот төлөвлөлт</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Бага, дунд бүлгийн багш нар эцэг эхийн гаргасан санаачилгыг дэмжин эцэг, эхийн хурал зохион байгуулсан. Ангийн орчинд хүүхдийн осол гэмтэлд өртөж буй шалтгаан, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн зохион байгуулах талаар ярилцаж, төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлсэн.</li> </ul> <p><b>Эцэг, эхийн оролцоот аудит</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эцэг, эх цэцэрлэгийн анги танхимын эрсдэл, аюулгүй орчны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэхийн өмнө бүлгийн багш нартай хамтран “Анги танхимд хийх ажиглалтын хуудас” боловсруулан ашигласан. Үнэлгээний хуудсаар анги бүрт үнэлгээ хийхэд хүүхдийн тоо, сургалтын онцлогоос хамаарч анги бүрт ойролцоогоор 15-20 ширээ, 45-60 сандал, 6-8 тоглоомын тавиур, 3-4 бичил ном сан, хөгжүүлэх үйл ажиллагааны тавиур байв. Хүүхдүүд ихэнх тохиолдолд унаж бэртэхдээ хурц ирмэг, үзүүртэй зүйл мөргөж, цохиж гэмтдэг гэсэн үнэлгээ гарсан. Энэ дүгнэлтээс үүдэн нийт эцэг, эх хүүхдийнхээ ангид байгаа эд зүйлсийн хурц ирмэг үзүүрийг далдлах, эрсдэл үүсэхээс сэргийлэх аян өрнүүлсэн болно.</li> </ul>
<b>Хүрсэн үр дүн (гарц, богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</b>	<ul style="list-style-type: none"> <li>- 2018-2019 оны хичээлийн жилд орчноос шалтгаалсан осол гэмтэлд өртсөн 2-3 хүртэлх насны хүүхдийн тоо 9 байсан бол 2019 оны 9-10 дугаар сарын байдлаар орчноос шалтгаалсан осол гэмтэл гараагүй.</li> <li>- Багш нарын дундах орчноос үүдэлтэй осол гэмтэл үүсэх вий гэсэн сэтгэл зовнил буурч, сургалтын үндсэн үйл ажиллагаанд анхаарч төвлөрөх байдал 2018-2019 оны хичээлийн жилтэй харьцуулахад 2019 оны 10 сарын байдлаар 20 хувиар нэмэгдсэн.</li> <li>- 2018-2019 оны хичээлийн жилийн 9-10 сарыг 2019 оны мөн үетэй харьцуулахад орчноос үүдэлтэй хүүхдийн осол гэмтлийн талаар эцэг, эхээс ямар нэг гомдол ирээгүй.</li> <li>- Цэцэрлэгийн өдөр тутмын ирцэд судалгаа хийхэд 2-3 настай хүүхдүүд осол гэмтлээс хамаарч чөлөө авах байдал байхгүй болсон 2018-2019 оны хичээлийн жилтэй харьцуулахад хүүхдийн цэцэрлэгийн орчинд дасан зохицох байдал 98 хувьтай байсан нь энэхүү санаачилгын үр дүн гэж үзэж байна.</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

			
<p><b>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</b></p>	<p>Цэцэрлэгийн удирдлага, багш нарын зүгээс эцэг, эхтэй хамтран хүүхдийн сурч хөгжих эрсдэлгүй орчин бүрдүүлж байгаадаа сэтгэл хангалуун байна. Цаашид энэ санаачилгаа цэцэрлэгийнхээ “Загвар” ажил болгон хөгжүүлэхээр тодорхой ажлуудыг санаачлан төлөвлөгөө боловсруулж, холбогдох баримт бичигтээ тусгав.</p> <p><b>Тодруулбал;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Бага, дунд бүлгийн эцэг эхийн дунд улирал бүр хэлэлцүүлэг зохион байгуулах;</li> <li>- Багш, ажилчид, эцэг эхийн хамтарсан баг бүрдүүлж, цэцэрлэгийн засаглалын орчин, материаллаг орчин, сэтгэл зүйн орчинд үнэлгээ хийн, судалгаа авах;</li> <li>- Үнэлгээ хийсэн багш, эцэг эхийн төлөөлөлтэй цэцэрлэгийн удирдлагууд уулзаж ярилцан, тэдний саналыг сонсож, цэцэрлэгийн бусад үйл ажиллагаатай холбох;</li> <li>- Багш, эцэг эхийн хамтран боловсруулсан “Эрсдэлээс сэргийлэх үнэлгээ”-ний хуудас ашиглан улирал бүр үнэлгээ хийж, үнэлгээний тайланг цэцэрлэгийн арга зүйч нэгтгэн бусдад танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;</li> <li>- Улирал бүрийн үнэлгээний үр дүн, тайланд үндэслэн эрсдэлтэй тавилга, хэрэгслийн жагсаалт гарган анги танхим, цэцэрлэгийн мэдээллийн самбарт байрлуулж, эцэг эхэд шаардлагатай зөвлөмж мэдээллийг бэлтгэн, тараах;</li> <li>- Ангийн эрсдэлтэй тавилга, хэрэгсэлд хамгаалалтын наалт, зөөлөвч хийж, ил утас, залгуур, цахилгаан хэрэгсэлд стандартын шаардлагаа хангасан хамгаалалт хийх;</li> <li>- “Эрсдэлгүй орчин” эцэг эхийн нээлттэй өдөрлөгийг хагас жилд нэг удаа зохиох зэрэг ажлыг зохион байгуулдаг уламжлал бий болгож байна.</li> </ul>		
<p><b>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эх, асран хамгаалагчид бүлгийн багш нартай хамтран хүүхдийнхээ анги танхимыг тохижуулах, эрсдэлгүй орчин бүрдүүлэхэд анхаарч тодорхой ажлууд хийж байсан ч цэцэрлэгийн анги танхим дулаан алдалт ихтэй нь хүндрэл учруулж байсан. Харин “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл хэрэгжсэн нь энэ хүндрэлтэй асуудлыг шийдэж, эцэг эх, багшийн хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.</li> <li>- Цэцэрлэгийн зүгээс эцэг эхийн гаргасан санаачилгыг дэмжин хамтран ажиллаж байсан ч эцэг, эхийн цаг баримтлах байдал, идэвх оролцоо</li> </ul>		

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>харилцан адилгүй байсан нь эхний үед нэлээд бэрхшээл хүндрэлийг үүсгэж зарим тохиолдолд нэг мэдээллийг хэд дахин давтан эцэг, эхэд хүргэх тохиолдол гарч нэлээд бэрхшээл үүсгэж байсан. Гэвч зарим эцэг, эх идэвхтэй оролцон, цагаа баримталж эхлэхэд бусад эцэг, эхийн идэвх оролцоо аажимдаа нэмэгдэж байсан.</p>
<p><b>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</b></p>	<p><b>Цэцэрлэгийн зүгээс:</b>          Үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг чиглэлийг эцэг, эхтэй хамтран ажиллах чиглэлээр боловсруулж, аль болох эцэг, эхийн санал бодлыг сонсож, хамтран ажиллах, уур амьсгалыг бүрдүүлсэн. Ялангуяа эцэг, эхийн дунд нээлттэй хэлэлцүүлэг, өдөрлөг зохиож, эрсдэлийн үнэлгээ хийлгэж, тогтмол хамтран ажиллаж байсан нь энэ ажлын үр дүнг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.</p> <p><b>Эцэг эхийн зүгээс:</b>          Цэцэрлэгээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд эцэг, эх хөндлөнгийн хяналт үнэлгээ хийж, өөрсдийн санал бодлоо багш, цэцэрлэгийн удирдлагуудтай илэн далангүй хуваалцсан. Хүүхдийн эрүүл аюулгүй, сурч хөгжих орчинд эрсдэл байгаа эсэхийг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, шийдвэр гаргахад оролцож, бүтээлч санаачилга өрнүүлэн ажилласан. Эцэг, эх ийнхүү цэцэрлэгтэй хамтран ажилласан нь тэдний бусадтай хамтран ажиллах, санаачилга гаргах урам зоригийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. Ялангуяа өөрсдийн гаргасан санаачилга, хийсэн үнэлгээний үр дүнгийн хүрээнд тулгамдсан асуудлыг шийдэхийн төлөө чин сэтгэлээсээ хичээнгүйлэн ажиллаж байлаа.</p> <p><b>Төсөл хэрэгжүүлэгчдийн зүгээс:</b>          Энэ санаачилга үр дүнд хүрч, сайн туршлага болоход “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл гол нөлөөг үзүүллээ. Төслийн зүгээс зөвхөн цэцэрлэгийн барилгын засвар, дулаалгын асуудлыг шийдэхэд анхаарах бус цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн “Хамтарсан баг” байгуулж, “Барилгын дулаалгын засварын явцад хөндлөнгийн хяналт үнэлгээ” хийх, “Сайн цэцэрлэгийг дэмжих” аргачлалын хүрээнд цэцэрлэгийн засаглал, материаллаг болон сэтгэл зүйн орчинд үнэлгээ хийх аргачлалыг эзэмшүүлсэн. “Автобустай аялал” зохион байгуулж төсөлд хамрагдсан бусад сургууль, цэцэрлэгийн туршлагаас суралцах боломж бүрдүүлэв. “Харилцан суралцах арга зүй” сургалтад хамрууллаа. Энэ бүхэн нь бидний ур чадвар, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр боллоо.</p> <p>Цэцэрлэгийн багш, ажилтнуудын хувьд дан ганц энэ төслийн үйл ажиллагаагаар хязгаарлахгүй цэцэрлэгийнхээ бүхий л үйл ажиллагаанд хандах эерэг хандлага, хамтын ажиллагаа нэмэгдсэн.</p>
	<p><b>Ц.Ариунзаяа (Эцэг эхийн төлөөлөл):</b></p> <p>Эцэг, эх хамтран хүүхдийнхээ ангид эрсдэлгүй орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. Бид нар ангийн эд хогшилын өнцөг булан бүрт хамгаалалт хийсэн. Багшийн зүгээс хүүхэд сурч хөгжихөд эрсдэлгүй орчны ач холбогдлын талаар эцэг, эхэд мэдлэг олгох сургалт зохион байгуулснаар хүүхэд эрсдэлгүй орчинд хөгжих ёстой, хүүхдийн хөгжлийг</p>



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

<b>Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл</b>	<p>дэмжихэд орчин ямар чухал болохыг ойлгож авсан. Эцэг, эх хамтран энэ ажилд оролцсоноор өмнө нь мэддэггүй, чаддаггүй байсан олон зүйлээ сурч авлаа. Одоо гадаа явах, дэлгүүрт орохдоо ч орчныг ажиглаж хүүхэд бэртэж гэмтэх зүйл байх вий хэмээн ажигладаг болсон.</p> <p><b>Ж.Цогтбаяр (цэцэрлэгийн сантехникийн слесарь):</b></p> <p>Манай цэцэрлэгийн сантехникийн хоолойнууд зэврэлт ихтэй, энд тэндээ цоорсон, усны алдагдал их бага хэмжээгээр гардаг, бохирын шугам байнга бөглөрөх зэрэг асуудал байнга гардаг байсан. Энэ төсөл хэрэгжсэнээр гурван хос хэвтээ халуун, хүйтний 50 метр шугам, нийт 150 метр төмөр хоолойг шинээр сольсон. 12 анги бүлгийн хуучин бохирын босоо төмөр шугамыг хуванцар хоолойгоор сольсон. Засварын ажлыг шинэчилж хийснээр цэцэрлэгийн сантехникийн хүндрэлтэй асуудал бүрэн шийдэгдэж чадлаа.</p>
<b>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Энэ туршлагыг өөрийн цэцэрлэгтээ хэрэгжүүлэхийн өмнө бүх багш нараа нэг ойлголт, мэдлэгтэй болгох сургалтыг зохион байгуулж багш нар бие биеэсээ суралцах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ Нийслэл, дүүргээс зохион байгуулж байгаа хөгжүүлэх арга зүй, технологийн сургалтад хамруулах, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарах нь чухал. Багш нараа бусад цэцэрлэгийн багш нартай хамтран ажиллуулах, зөвлөн туслах баг болон бусад багш нараас зөвлөгөө авах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх нь чухал нөлөөтэй.</li> <li>- Хичээлийн жилийн эхэнд эцэг, эхтэйгээ хамтран ажиллах гэрээ байгуулж тухайн хичээлийн жилд хамтран ажиллах, төлөвлөгөөгөө танилцуулж, тэдний санал бодлыг сонсох нь цэцэрлэгийн багш ажилтан, эцэг эх нэг ойлголттой болоход нөлөөлсөн гэж үзэж байна. Эцэг, эхийн хувьд таны хүүхэд эрсдэлгүй, таатай орчинд сурч, хөгжихөд таны оролцоо чухал гэдгийг ойлгуулах нь ач холбогдолтой.</li> </ul>
<b>Цэцэрлэгийн холбоо барих хаяг, лого</b>	<p style="text-align: center;"><b>Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороо 91 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Цэцэрлэгийн эрхлэгч Д.Цэвэлмаа (Утас: 99029590, 93135409 Э-шуудан: Tsevlee91@yahoo.com)</li> <li>• Цэцэрлэгийн арга зүйч С.Дариймаа (Утас: 89254156, 99254156, Э-шуудан: <a href="mailto:dariimaa.az91@gmail.com">dariimaa.az91@gmail.com</a>)</li> <li>• Бүлгийн багш Э.Бүжмаа (Утас: 80834406, Э-шуудан: <a href="mailto:bujmaa91@gmail.com">bujmaa91@gmail.com</a>)</li> <li>• Бүлгийн багш- З.Өлзийзаяа (Утас: 88726176, 95726179 Э-шуудан: <a href="mailto:zorigoozaya89@gmail.com">zorigoozaya89@gmail.com</a>)</li> </ul>



## БИДНИЙ ХҮҮХЭД-БИДНИЙ ИРЭЭДҮЙ

<b>Зорилго</b>	25-35 насны залуу эцэг, эхийг бага насны хүүхдийн хөгжил, онцлогийн талаар мэдлэг, ур чадвар олгох сургалт, нөлөөллийн ажилд тогтмол
----------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	хамруулж, тэднийг цэцэрлэгийн бусад үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх
<b>Нөхцөл байдал тулгамдсан асуудал</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн хөгжилд нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйл эцэг эх, асран хамгаалагч болон хүүхэд хоорондын эзэнгшин дасах холбоо. Хүүхэд ямар хүн болж төлөвших нь гэр бүлээс ихээхэн хамаардаг. Эцэг, эх хүүхэдтэйгээ багаас нь яаж харилцах, хүүхдээ юунд сургах, ямар чадвар, дадал эзэмшүүлэхийг сайн мэддэг байх ёстой. Гэтэл бодит байдал дээр залуу эцэг, эх хүүхэд хүмүүжүүлэх арга туршлага багатайгаас болоод хүүхдэдээ зөв үлгэр дуурайл болж, хүүхдээ хэрхэн дэмжиж, туслахаа мэддэггүй. Энэ байдал хүүхдийн хөгжил, төлөвшилд сөргөөр нөлөөлдөг. Ялангуяа эцэг, эхийн хоорондын харилцаа, яриа хөөрөө, амьдралын хэв маяг, гэртээ сурсан дадал хэвшил цэцэрлэгийн орчинд хүүхдээс байнга илэрдэг.</li> <li>- 25-35 насны эцэг, эхийн хувьд амьдралын туршлага бага, бага насны хүүхдийн хөгжлийн онцлогийн талаарх мэдлэг, ойлголт муугаас өөрсдөө хүүхдэдээ муу үлгэр дуурайл үзүүлж байгаагаа төдийлөн ухаардаггүй. Хүн хэлэхээс нааш мэддэггүй гэдэг монгол зүйр цэцэн үгийн нэгэн адил манай цэцэрлэгийн зүгээс энэ чиглэлийн сургалтыг санаачлан зохион байгуулахад залуу эцэг, эх маш идэвхтэй оролцохын зэрэгцээ сургалтын явцад энэ чиглэлийн мэдлэг мэдээлэлгүй байгаа нь анзаарагддаг.</li> <li>- Энэ нөхцөл байдлаас үүдэн манай цэцэрлэг 1990 оноос хойш тасралтгүй 30 жилийн хугацаанд “Залуу эцэг, эхийг чадваржуулах сургалт, нөлөөлөл”-ийн ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж, сар бүр богино хугацааны сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулдаг уламжлалтай болсон.</li> </ul>
<b>Зорилтот бүлэг</b>	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн тэргүүний 91 дүгээр цэцэрлэгийн 25-35 насны эцэг, эх
<b>Шалгуур үзүүлэлт (төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ)</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Хичээлийн жил бүр цэцэрлэгээс санаачлан 25-35 насны эцэг, эхийн дунд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын давтамж</li> <li>- Цэцэрлэгээс санаачлан зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд 25-35 насны эцэг эхийн оролцсон хувь</li> <li>- Нийслэл, дүүрэг, цэцэрлэгээс зохион байгуулдаг уралдаан, тэмцээнд 25-35 насны эцэг, эхийн оролцсон хувь</li> <li>- Цэцэрлэгээс санаачлан зохион байгуулсан нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг бусад арга хэмжээнд оролцсон 25-35 насны эцэг, эхийн тоо</li> <li>- Цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжих, сайжруулах чиглэлээр эцэг, эхээс гаргасан санал санаачилгад 25-35 насны эцэг, эхээс гаргасан саналын эзлэх хувь</li> </ul>
<b>Ашигласан эгэх хариуцлагын хэрэгсэл</b>	<p><b>ОРОЛЦООТ ТӨЛӨВЛӨЛТ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хичээлийн жил эхлэнгүүт 25-35 насны эцэг, эхчүүдээс хүүхдийнхээ хөгжил, төлөвшлийг дэмжих ямар сургалт, мэдээлэл шаардлагатай байгаа талаар тэдний хэрэгцээ, сонирхлыг тандах судалгааг зохион байгуулж, судалгааны үр дүнд тулгуурлан зохион байгуулах сургалт, нөлөөллийн ажлын сэдэв чиглэлээ тодорхойлсон. Сургалтыг цэцэрлэгийн эрхлэгч Д.Цэвэлмаа болон бусад бүлгийн багш нар</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>өөрсдийн нөөц боломждоо тулгуурлан зохион байгуулахын зэрэгцээ зарим тохиолдолд туршлагатай хүмүүсийг урьж оролцуулдаг.</p> <p><b>ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ КАРТ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Залуу эцэг, эхэд зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулахдаа тэдний санал хүсэлт үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ авдаг. 16 бүлэгт сурдаг хүүхдүүдийн эцэг, эхээс авсан үнэлгээг нэгтгэн тэдний саналын дагуу сургалтын агуулга, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна.</li> </ul>
<p><b>Хүрсэн үр дүн (гарц, богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Манай цэцэрлэгийн 25-35 насны эцэг эхчүүдийн оролцоо жил ирэх тусам 15-20 хувиар өсөж байна. Тухайлбал; “Цэцэрлэгийн орчин гуравдагч багш” анги бүлгийн эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх аянг нэг сарын хугацаатай зохион байгуулахад 25-35 насны эцэг эхчүүд бусдыгаа манлайлан 94 хувийн ирцтэй оролцов. “Замын хөдөлгөөнд хүүхдээ аюулгүй тээвэрлэх нь”, “Хүүхэд хөгжил хамгаалал”, “Томуу болон томуу төст өвчгөөс сэргийлэх нь” сургалт, “Шилдэг гэр бүл”, “Аав, ээж,” би” буухиа тэмцээн, “Эцэг эхийн дундах гар бөмбөгийн тэмцээн”, “Орчин бол гуравдагч багш” нөлөөллийн ажилд 2018 онд нийт оролцогчдын 21 хувь буюу 248 нь 25-35 нас залуу эцэг эхийн эзэлж байсан бол 2019 онд 39 хувь буюу 446 болж нэмэгдлээ.</li> <li>• Нийслэлийн цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулдаг “Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн”-д хүүхдүүдээ бэлтгэхэд нийт 30 хүүхдийн 54 эцэг эх 100 хувийн ирцтэй оролцсон. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Жавхлант бүс”-ийн 11 цэцэрлэгийн эцэг эхийн спорт тэмцээнд 16 залуу эцэг эх бусдыгаа төлөөлөн амжилттай оролцов.</li> <li>• Улирал бүр 16 бүлгийн багш, туслах багш, эцэг эхчүүд хамтран зохиодог “Сургалт хичээл” арга хэмжээнд өнгөрсөн хичээлийн жилд 16 бүлгээс 25-35 насны 221 эцэг эх оролцсон. Харин “Шинэ жилийн өглөөлөг”, “Хаврын тайлант өглөөлөг” арга хэмжээнд 248 эцэг эх, “Алтан намар” нээлттэй өдөрлөгт 393 эцэг эх тус тус оролцсон.</li> <li>• Бид жил бүр эцэг эхчүүдтэйгээ хамтран “Сургалтын таатай орчин” аяныг тогтмол зохион байгуулдаг. Энэ хичээлийн жил тус аянд 25-35 насны эцэг эхчүүд 100 хувийн ирцтэй оролцож, хүүхдийнхээ сурч, хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүллээ. Эцэг эхчүүд анги бүрт “Хүүхдийн эмч”, “Дэлгүүр” сэдэвт тоглоом хандивлан, “Ангийн бичил номын сан” байгууллаа. Мөн энгийн материал ашиглан хөшиг хийж, ангиудын 87.5 хувийг ус цэвэршүүлэгчээр хангаж, “Ус чандмань эрдэнэ” арга хэмжээг бүлгийн багш нартай хамтран зохион байгуулсан нь хүүхдийг багаасаа усны үнэ цэнийг ойлгоход дэм болсон ажил боллоо.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхүүдийн эцэг, эхээс нас, хүйс, ажил мэргэжлийн судалгааг асуулгын аргаар авсан. Судалгаанд давхардсан тоогоор нийт 1,141 эцэг, эх хамрагдсан. Тухайн судалгааны үр дүн, 25-35 насны эцэг, эхийн хэрэгцээнд тулгуурлан “Залуу эцэг, эхийг хөгжүүлэх” төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлдэг уламжлалтай болсон.</li> <li>• 1990 оноос хойш төрсөн эцэг эх 446 байсан нь манай цэцэрлэгийн нийт эцэг эхийн 39 хувийг эзэлж байсан бөгөөд тэдгээр эцэг, эхийн хөгжлийг</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

<p><b>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</b></p>	<p>дэмжихийн зэрэгцээ цэцэрлэгийн үйл ажиллагаан дахь идэвх оролцоог нь нэмэгдүүлэхэд гол анхаарлаа хандуулж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бүлгийн багш нар эцэг, эхийн хурлаараа эцэг, эхийн зөвлөлийн дарга, гишүүдийг санал хураалтын үндсэн дээр томилсон. Эцэг эхийн зөвлөл хуралдаж тухайн жилд зохион байгуулагдах үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж цэцэрлэгийн эрхлэгчээр батлуулан хэрэгжүүлдэг уламжлалтай болсон.</li> </ul>
<p><b>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Залуу эцэг, эхийн хүнтэй харилцах харилцаа хандлага эерэг бус байсан.</li> <li>• Хүүхдийн талаар эцэг, эхтэй зөвшилцөхөд нэлээд бэрхшээлтэй байсан. Залуу эцэг, эх хүүхдээ хэт өмөөрөх, хүүхдээ дураар нь байлгах, буруу эрхлүүлснээс үүдэн зарим тохиолдолд цэцэрлэг, багшийн тавьж байгаа шаардлагыг буруугаар хүлээн авах тохиолдол гарч байсан</li> <li>• Залуу эцэг эх хүүхдийнхээ нас, бие, хөгжлийн онцлогийг танин мэдээгүйгээс багшийн өгч буй зөвлөгөөг хүндээр тусгаж авч багш эцэг, эхийн хоорондын харилцаанд хэрүүл маргаан үүсэх эрсдэлийг бий болгож байсан.</li> <li>• Нэг анги бүлэгт хүүхдээ өгдөг эцэг эх бие биенээ таньж мэдээгүйгээс болж жижиг маргаан үүсэх бэрхшээл гарч байсан.</li> </ul>
<p><b>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс / үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч, орон нутгийн</b></p>	<p><b>Цэцэрлэгийн зүгээс:</b> Нийт 16 бүлгийн багш нар, эцэг, эхийн дэлгэрэнгүй судалгааг хийсэн. Нийт 1141 эцэг, эх хамрагдсанаас залуу эцэг, эх 446 байсан. Бүлэг бүр эцэг, эхийн зөвлөл байгуулсан. Бүлгийн эцэг, эхийн зөвлөлийн дарга нар хуралдаж цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөлийг байгуулсан. Цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөл хуралдаж хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулдаг болсон. <b>“Оны шилдэг гэр бүл”</b>-ийг тодруулдаг болсон.</p> <p><b>Эцэг эхийн зүгээс:</b> Цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөлийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд эцэг, эх хөндлөнгийн хяналт үнэлгээ хийж, өөрсдийн санал сэтгэгдлээ багш, цэцэрлэгийн удирдлагуудтай илэн далангүй хуваалцсан. Эцэг, эхийн зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөний дагуу хүүхдийн эрүүл аюулгүй, сурч хөгжих орчныг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, шийдвэр гаргахад оролцож, бүтээлч санаачилга өрнүүлэн ажилласан. Эцэг, эх ийнхүү цэцэрлэгтэй хамтран ажилласан нь тэдний харилцаа хандлага өөрчлөгдөж, цэцэрлэгтэй хамтран ажиллах, санаачилга гаргах урам зоригийг нэмэгдүүлсэн. Ялангуяа өөрсдийн гаргасан санаачилга, хийсэн ажлын үр дүн тулгамдсан асуудлыг шийдэхийн төлөө чин сэтгэлээсээ хичээнгүйлэн ажиллаж байлаа.</p>
	<p><b>Д.Цэвэлмаа (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 91 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч):</b></p> <p>Манай цэцэрлэгийн хувьд 16 бүлгийн багш нар жил бүр эцэг, эхийн дэлгэрэнгүй судалгааг зохион байгуулдаг. 2018 оны байдлаар 1980 оноос хойш төрсөн эцэг, эх дийлэнх байсан бол 2019 оноос залуу эцэг, эх 40 хувийг эзлэх болсон. Иймээс сургалт үйл ажиллагаандаа залуу эцэг, эхийг татан оролцуулахын тулд цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөлтэй хамтран төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Цэцэрлэгийн бүхий л үйл</p>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

<b>Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл</b>	<p>ажиллагаанд залуу эцэг, эхийг түлхүү оролцуулснаар тэдний харилцаа хандлага эерэг болж, оролцоо нэмэгдсэн, залуу эцэг, эх багаар хамтран ажиллах зорилго чиглэлтэй болж ирсэн нь багш нарт дэмжлэг болж байна.</p> <p><b>3.Өлзийзаяа (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 91 дүгээр цэцэрлэгийн Дунд “Г” бүлгийн багш):</b></p> <p>Миний хувьд бүлгийн багшаар 2 дахь жилдээ ажиллаж байгаа залуу багш. Эхний жилзалуу эцэг, эхтэй хамтран ажиллах явцад үл ойлголцох байдал бага зэрэг гарч байсан. Гэр бүл бол хүүхдийн хөгжлийг тэтгэгч анхдагч орчин бөгөөд хүүхэд хамгийн чухал дэмжлэгийг гэр бүлээсээ авдаг. Эцэг, эхийн оролцоо хэдийчинээ их байх тусам хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт сайжирдаг тул залуу эцэг, эх хүүхдийнхээ хөгжил хүмүүжилд санаа тавьж багш нартай хамтран ажиллах нь хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлж байна.</p>
<b>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Энэ туршлагыг өөрийн цэцэрлэг дээрээ хэрэгжүүлэхийн өмнө эцэг эх, асран хамгаалагчдыг нэгдсэн ойлголт, мэдлэгтэй болгох сургалт, хичээл, хурлыг зохион байгуулж, эцэг эх, асран хамгаалагч нар бие биеэсээ суралцах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ Нийслэл, дүүргээс зохион байгуулж байгаа хүүхдийн дундах тэмцээн уралдаан, эцэг эхийн сургалтад хамруулах нь чухал. хичээлийн жилийн эхэнд эцэг эхтэй хамтран ажиллах гэрээ байгуулж тухайн хичээлийн жилд хамтран ажиллах, төлөвлөгөөгөө танилцуулж, тэдний санал бодлыг сонсох нь цэцэрлэг, эцэг, эхийг нэгдсэн ойлголттой болгоход нөлөөлдөг.</li> <li>- Залуу эцэг, эхийг цэцэрлэгийн үйл ажиллагаанд татан оролцуулах, хүүхдийнхээ хөгжил төлөвшилд эерэгээр нөлөөлөх сэдэвт сургалт үйл ажиллагааг зохион явуулахад анхаарах хэрэгтэй юм.</li> <li>- Цэцэрлэгийн эцэг эх, асран хамгаалагч нараа бусад цэцэрлэгийн эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран ажиллуулах, багш нараас зөвлөгөө авах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх нь чухал нөлөөтэй.</li> </ul>
<b>Цэцэрлэгийн холбоо барих хаяг, лого</b>	<p style="text-align: center;"><b>Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороо 91 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Цэцэрлэгийн эрхлэгч Д.Цэвэлмаа (Утас: 99029590, Э-шуудан: <a href="mailto:Tsevelee91@yahoo.com">Tsevelee91@yahoo.com</a>)</li> <li>• Цэцэрлэгийн арга зүйч С.Дариймаа (Утас: 89254156, 99254156, Э-шуудан: <a href="mailto:dariimaa.az91@gmail.com">dariimaa.az91@gmail.com</a>)</li> <li>• Бүлгийн багш Э.Бүжмаа (Утас: 80834406, Э-шуудан: <a href="mailto:bujmaa91@gmail.com">bujmaa91@gmail.com</a>)</li> <li>• Бүлгийн багш- 3.Өлзийзаяа (Утас: 88726176, 95726179 Э-шуудан: <a href="mailto:zorigoozaya89@gmail.com">zorigoozaya89@gmail.com</a>)</li> </ul>
	



ЗУРГИЙН ЦОМОГ



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



## НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 63 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



- Бидний тухай
- “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл” манай цэцэрлэгт
- Бусадтай хуваалцах бидний сайн туршлага
- Зургийн цомог



## НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 63 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ

Манай цэцэрлэг 1962 онд Төв аймгийн Гачуурт тосгонд 1.5-6 насны хүүхдүүдийн ясли-цэцэрлэгийн зориулалтаар 25 хүүхэд, 7 багш ажилтантай ашиглалтад орж байсан бол 1987 онд “Хүүхдийн төлөө фонд”-ын хөрөнгөөр баригдсан зориулалтын барилгад шилжин орж 150 хүүхэд, 37 багш ажилтантай болж өргөжсөн. 2019-2020 оны хичээлийн жилд 10 бүлэг, 24 цагийн 2 бүлэг, нийт 402 хүүхэд, 57 багш, ажилтантай Гачуурт тосгоны бага насны хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх зорилгоор ажиллаж байна.

Бид хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэн “Хүүхдийг бүтээлч үйлийн орчинд хөгжих хүсэл эрмэлзлийг дэмжин, өөрийн ертөнцөө бүтээхэд нь туслах” эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2015 оноос эхлэн хүүхдийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах үүднээс олон улсын шилдэг технологийн шийдэл бүхий “Ойдог баримлын шавар”-ыг сургалтын гол хэрэглэгдэхүүн болгон хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. Бүх хүүхдээ хөгжүүлэх дугуйланд хамруулахын зэрэгцээ “Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төв”, “Номын сан”, “Ёс заншлын өргөө”-г нээн, тодорхой хуваарийн дагуу ажиллаж байна.

### “МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ” МАНАЙ ЦЭЦЭРЛЭГТ

#### Н.Энхцэцэг (Нийслэлийн Баянзүрх дүүргийн 63 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

Бид “Монгол дахь барилга байгууламжийн эрчим, хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөлд хамрагдан, цэцэрлэгийн барилгын дулаалга, засвар үйлчилгээний ажлаа шийдсэндээ баяртай байна.

Манай цэцэрлэгийн 1987 онд баригдсан барилгын чанар муудан, анги танхим, ялангуяа дээд давхрын өрөө тасалгаа, ялангуяа 24 цагийн бүлэг маш хүйтэн байсан нь хүүхдийн сурч хөгжих, тав тухтай орчин, бүрдүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байсан.

Энэ төслийн бусад төслөөс ялгагдах нэг онцлог нь зөвхөн цэцэрлэгийн засвар үйлчилгээг сайжруулахад анхаараад зогсохгүй Сургуулийн эцэг эх, багшийн үндэсний нэгдсэн холбоо (СЭЭБҮНХ)-ны зөвлөгөө, дэмжлэгээр цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтан, эцэг, эхийн төлөөллөөс бүрдсэн “Хамтарсан баг” байгуулсан явдал юм. Засварын явцад “Хамтарсан баг”-аар хөндлөнгийн хяналт хийлгэсэн нь барилгын засвар дулаалгыг чанартай гүйцэтгэхэд ихээхэн түлхэц болсон. Засварыг хамгийн сүүлийн үеийн технологиор хийж гүйцэтгэсэн. Засварын явц тутамд төслийн хяналтын инженер Сарантуяа хариуцлагатай сайн ажиллаж байсанд манай хамт олон талархаж байна.



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

Хүүхдийн сурч хөгжих, тохь тухтай орчин, багш ажилчдын ажлын нөхцөлийг сайжруулахад сэтгэл зүрхээ зориулан ажилласан бүх хүмүүстээ, хамт олныхоо өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

**Бусадтай хуваалцах бидний сайн туршлага:**

### ААВ, ЭЭЖТЭЙГЭЭ 20 МИНУТ

<b>Зорилго</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Эцэг, эхийг хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах</li> <li>• Цэцэрлэгийн хэтийн төлөв, зорилго, зорилтыг хамтран бүтээх, үр дүнтэй ажиллах</li> <li>• Хүүхэд ээж, аавтайгаа хамт тоглох, наадах хугацааг нэмэгдүүлэх</li> <li>• Цэцэрлэгийн үйл ажиллагааг эцэг, эхэд таниулах</li> </ul>
<b>Нөхцөл байдал, тулгамдсан асуудал</b>	<p>БЗД-ийн 20 дугаар хороо, хуучнаар Төв аймгийн Гачууртад байрладаг. Нийслэлийн хамгийн ойр сүү цагаан идээ, газар тариалангийн бүс нутаг. Одоо тус тосгон нь алслагдмал байрлалтай баг, хэсэг олонтой, хотын нэгэн дүүргийн томоохон хэсэг суурьшилын бүс юм. Сүүлийн жилүүдэд тосгоны айл өрхийн тоо нэмэгдсэнээр хамран сургах тойргийн 0-5 насны хүүхдийн тоо нэмэгдэж, 2019 онд 0-5 насны хүүхдийн тоо 719, үүнээс цэцэрлэгийн 2-5 насны хүүхдийн тоо 685 боллоо. Тус цэцэрлэгт хамран сургах тойргийн алслагдсан гэртэй хүүхдүүд хамрагдахаас гадна, БЗД-ийн өнчин, аав, ээж нь хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй, хөдөө орон нутаг, хилийн чанадад ажил эрхэлдэг зэрэг тодорхой асуудалтай нийгмийн бүлгийн хүүхдүүд хамрагдаж байна. Эдгээр зорилтот бүлгийн хүүхдүүдийг 24 цагийн үйлчилгээтэй хоёр бүлэгт сургадаг.</p> <p>Цэцэрлэгээс санаачилан зохион байгуулдаг ажилд эцэг, эхчүүд харилцан адилгүй оролцдог. 2018-2019 оны хичээлийн жилд 24 цагийн 2 бүлгийн нийт 95 эцэг, эхийн цэцэрлэгээс зохион байгуулж буй ажилд оролцох оролцоо 64 хувь байгаа бол 2017-2018 оны хичээлийн жилд 58 хувьтай оролцлоо. Эцэг, эх намар хамгийн түрүүнд зохиогддог ажилд 82 хувь, биеийн тамирын өдөрлөг, “Дээлтэй Монгол” үйл ажиллагаанд 70 хувь, хурал, сургалтад 40-50 хувьтай оролцдог. Үүнээс дүгнэхэд сар тутмын ажилд ирэх нь цөөн, харин урлаг спортын арга хэмжээнд илүү оролцдог нь ажиглагдсан юм.</p>
<b>Зорилтот бүлэг</b>	Цэцэрлэгийн 400 хүүхэд, тэдний эцэг, эх
<b>Шалгуур үзүүлэлт (Төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ)</b>	<ul style="list-style-type: none"> <li>• “Ээж, аавтайгаа 20 минут” үйл ажиллагааг нэвтрүүлж, 7 хоног тутам 2-3 гэр бүлийг оролцуулах</li> <li>• Хүүхдийг аав, ээжтэйгээ хамтдаа тоглох, наадах, үлгэр зохиол унших, бүтээл хийх нөхцөлийг 100 хувь бүрдүүлэх</li> <li>• Орчны тав, тухтай байдлыг сайжруулж, тоглоом, ашиглах материалын тоог сар бүр шинэчилж, бүртгэл хөтөлж хэвшүүлэх</li> <li>• Эцэг, эхийн оролцоо 50-70 хувьтай байгааг 80-100 хувьд хүргэх</li> <li>• Эцэг, эхийн хүүхэдтэйгээ байх хугацааг нэмэгдүүлэх, үр дүнтэй болгох талаар улиралд нэг удаа, 200 эцэг, эхээс санал, асуулга авч, төлөвлөгөөндөө тусган ажиллах</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<ul style="list-style-type: none"> <li>• Эцэг, эхийн албан байгууллагатай зөвшилцөн, тухайн хуваарьт өдөр, хүүхдийн ээж, аавыг ажлаас чөлөөлөн, хүүхэдтэйгээ хамт байх боломжийг бүрдүүлэх</li> <li>• Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төвд 20-30 минутын туршид хүүхдийг ээж, аавтай нь хамт байлган, дуртай, сонирхолтой зүйлсийг нь хийлгэх</li> </ul>
<p><b>Ашигласан эгэх хариуцлагын арга хэрэгсэл</b></p>	<p><b>Оролцоот төлөвлөлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 2017-2018 оны хичээлийн жилд 226 хүүхэд хамрагдсан бөгөөд тэдгээр хүүхдийн амьдрах нөхцөл, амьжиргааны түвшингийн судалгаа гаргав. Эцэг, эхийн ажлын газар, албан тушаалын нэршил, утасны дугаар зэрэг дэлгэрэнгүй бүртгэл авлаа.</li> <li>- Хүүхдийн гэрээс, цэцэрлэг хүртэлх зам дагуух авто зам, аюултай нохой, гуу жалга, цахилгааны шон, өндөр хүчдэл байрладаг зэрэг эрсдэлд дүн, шинжилгээ хийн, нийт 226 хүүхдийн эцэг, эхээс “Аюулгүйн замын зураглал” -ыг гаргуулав.</li> <li>- “Хүүхдийн хөгжилд эцэг, эхийн оролцоо чухал” сэдвийг хөндөн, жил бүр нийт давтсан тоогоор 600-800 хүүхдийн эцэг, эхэд сургалт явуулсан.</li> <li>- “Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төв”-өөр дамжуулан “Аав, ээжтэйгээ 20 хором хамтдаа” үйл ажиллагааг зохион байгуулж эхлээд байна.</li> </ul>
<p><b>Хүрсэн үр дүн</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Манай цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийн түвшин улсын дундажтай харьцуулахад 2018 оны 10 дугаар сард улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй, хүүхдийн тоо 2 нас-15, 3 нас-9, 4 нас-26, 5 нас-28 байсан бол 2019 оны 5 дугаар сард нийт 67 хүүхдийг элсүүлэн сургасан.</li> <li>- “Уншлагыг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, анги бүлгүүд “Номын булан”-гаа өргөжүүлэн “Номын төв” болгон, цэцэрлэг тусгайлсан “Номын сан”-тай болсноор багш, хүүхдийн сургалтдаа ном ашиглах байдал 35 хувиар нэмэгдлээ.</li> <li>- 24 цагийн бүлгийн эцэг, эх хүүхэдтэйгээ хамтдаа тохилог орчинд цагийг үр дүнтэй тоглож өнгөрүүлснээр, тэдний эцэг эхийн сэтгэл ханамж 48 хувиар өссөн юм.</li> <li>- Баянзүрх дүүргийн бүсийн 7 цэцэрлэгийн багш нарыг урьж, “Уншлагыг дэмжих хөтөлбөр”-ийн дагуу хийсэн ажлаа сурталчлан үзүүлэх ажил зохион байгуулав.</li> <li>- Хүүхдийн зохиолч Н.Мандалыг урьж бага насны хүүхдийг номонд дуртай болгох “Хүүхдийг номтой нөхөрлүүлэх” уулзалт-өдөрлөгийг зохион байгуулав. Тус арга хэмжээ багш, эцэг, эхийн сэтгэлд ихээхэн нийцсэн учир хүүхдийн зохиолч Н.Мандалд хүсэлт тавьж, долоо хоног бүрийн Пүрэв гарагт бүлэг бүрийн хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогт нийцсэн “Үлгэрч эмээтэйгээ хамт” арга хэмжээг зохион байгуулж байна.</li> <li>- “Ээж, аавтайгаа 20 минут”-ын хүрээнд 7 хоног тутам 2-3 гэр бүл “Аав, ээжийн өргөө”-гөөр зочилж, хүүхэдтэйгээ хамтын бүтээл хийн үзэсгэлэн гаргадаг хэсгийг цэцэрлэгтээ бий болголоо.</li> </ul>
<p><b>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхам</b></p>	<p><b>“Аав, ээжтэйгээ 20 минут”</b> үйл ажиллагааг тодорхой хуваарийн дагуу 7 хоног тутам зохион байгуулж байна. Үйл ажиллагааг сурталчилах, цаашид сайжруулахын тулд 6 бүлгийн 90 эцэг, эхийн дунд санал асуулга зохион байгуулсан.</p> <p>Өрөөний тоглоом, наадам, сургалтын хэрэгдэгдхүүнийг хангамжтай болгоход санаа тавин ажиллаж байна.</p>



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

<b>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</b>	<p>“Аав, ээжтэйгээ 20 минут” үйл ажиллагааг бүрдүүлэхэд хэд, хэдэн бэрхшээл тулгарч байлаа.</p> <p><b>Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эцэг, эхийг тухайн цаг үед албан ажлаас чөлөөлүүлэх</li> <li>- Хүүхэд аав, ээжтэйгээ хамтдаа цагийг өнгөрөөж, тоглож, наадаж, бүтээж, тэвэрч хайраар дүүрэн өнгөрөөхийг ойлгуулан, чөлөөтэй байлгахын ач холбогдлыг эцэг, эхэд ойлгуулах</li> <li>- Сургалтын хэрэглэгдхүүний хангамж бага</li> <li>- Багш нарын ачааллаас хамааран хариуцаж, ажиллуулах багш сонгох нь бэрхшээлтэй байсан.</li> </ul>
<b>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйл</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Багш ажилтны санаачилга, хүчин зүтгэл, хандив, туслалцаа</li> <li>- Эцэг, эхийн зөвлөлийн санаачилгатай байдал, дэмжлэг</li> <li>- Эрхлэгчийн чиглүүлэг, бүтээлч санаачилга, чадварлаг зохион байгуулалт</li> </ul>
<b>Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл</b>	<p><b>24 цагийн Бэлтгэл Б бүлгийн Бадар- Ууганы аав Нямдорж:</b></p> <p>Бид ажил ихтэй, хүүхдэдээ цаг, зав гаргах боломж тун бага байдаг. 24 цагийн бүлэг нь бидэнд ажлаа тайван хийж, эргээд үр хүүхдээ асарч, хөгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлдэг. Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төвийн “Ээж, аавтайгаа 20 минут” нэртэй үйл ажиллагаанд оролцож үзлээ. Гэртээ ч хүүхдэдээ 5 минут гүйцэд цаг гаргахдаа боломж тааруу байдаг эцэг, эхчүүдэд тун зөв, зүйтэй ажил болжээ. Хүүхэд 20 минут орчим аавтайгаа хамт, тав тухтай, тоглоом наадмаар дүүрэн өрөөнд цагийг өнгөрөөн, зөвхөн хүүхэдтэйгээ тоглож, наадан, бүтээл хийн, цаг зарцуулна гэдэг үнэхээр сайхан байлаа. Мөн хүүхдийг минь 100 буудалт даамны дугуйланд хамруулан, тэмцээнд оролцуулж, дүүргийн 5 настны аварга даамчин болгосонд их баяртай байна. Тус цэцэрлэгийнхэндээ ажлын өндөр амжилт хүсье!</p> <p><b>Дунд А бүлгийн Тэгшжаргалын аав Тэмүүлэн:</b></p> <p>Тус цэцэрлэгийн “Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төв”-ийн “Ээж, аавтайгаа 20 минут” үйл ажиллагаанд оролцлоо. 2 хүүхдийн минь ээж энэ цэцэрлэгт багш, би өглөөнөөс шөнө хүртэл ажилладаг, амралт багатай. Ээж нь ч ажил ихтэй, хүүхдэдээ гаргах цаг бага. Энэ танхимд өнөөдөр ажлаасаа чөлөө аван, хүүхэдтэйгээ цаасаар цэцэг хийж, “Агаарт хатдаг баримал”-ын шавраар зөндөө хөөрхөн дүрс хийж тоглолоо. Яг цаг гаргаад хүүхэдтэйгээ байхад, хүүхэд ч, ээж, аав ч зөндөө зүйл сурдаг юм байна. Их сайхан санагдлаа. Энэ танхим зөвхөн эцэг, эхэд зөвлөгөө өгөөд зогсохгүй, бодит байдлаар хүүхэд, эцэг, эхийг хүмүүжүүлж байгаа юм байна гэж бодогдлоо. Энэ ажил улам олон гэр бүлийг хамраасай, олон хүүхдийг ээж, аавтай нь хамт тоглуулаасай гэж хүсэж байна. Дараагийн ээлжээ тэсэн ядан хүлээж байна.</p>
<b>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйл</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Хариуцан ажиллуулах багшийн асуудлыг оновчтой шийдэх</li> <li>- Хүүхэдтэйгээ харилцах цаг багатай, хандлага тааруу эцэг, эхийг түлхүү оролцуулах</li> <li>- Ээж, аав хүүхдийн хамтарсан үйл ажиллагааг өрнүүлж, өдөөж, чиглүүлж өгөх</li> <li>- Богино хугацаанд аль болох олон гэр бүлийг хамруулах</li> <li>- Үйл ажиллагаагаа сурталчилах</li> </ul>
<b>Холбоо барих хаяг:</b>	<p><b>НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 63 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ</b>  Эрхлэгч Н.Энхцэцэг (Утас: 88198819, э-шуудан: <a href="mailto:tsetse_63@gmail.com">tsetse_63@gmail.com</a>)</p>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



Арга зүйч Д.Долгоржав (Утас: 88198819, 80878771, э-шуудан: [dogoo9490@gmail.com](mailto:dogoo9490@gmail.com))

Багш Н.Наранзул (Утас: 88005734, э-шуудан: [naranzul\\_tegsh@yahoo.com](mailto:naranzul_tegsh@yahoo.com))


### БАРИЛГЫН ДУЛААЛГЫН ЗАСВАРЫН ЯВЦАД ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ТАВИХ “ХАМТАРСАН БАГ”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

<b>Зорилго</b>	Засвар үйлчилгээ, дулаалгын явцад эцэг, эхийн хөндлөнгийн хяналт тавьж, цэцэрлэгийн тохилог орчинг бүрдүүлэх
<b>Нөхцөл байдал, тулгамдсан асуудал</b>	<ul style="list-style-type: none"> <li>- 30 жилийн насжилттай барилгын чанар муудан, өрөө тасалгаа, дээвэр, хана, цонхноосоо цанатан, дулаанаа байнга алддаг болсон. Бүлгийн өрөө, тасалгаа, хана, таазнаасаа чийгтэн, хөлөрч, мөөгөнцөртөж эхэлсэн. Хоёр давхарт байрладаг 3 анги илүү хүйтэн болсон. 24 цагийн ангийн хүүхдүүд шөнөдөө даарч, тав тухгүй байдаг болсон.</li> <li>- Хүйтэн ангид хүүхдүүд олон цаг байснаас ханиад, томуу хүрэх, хоолой өвдөх асуудлууд байнга гардаг. Өвөлдөө хүүхдийн өвчлөл 40-45 хувьд хүрдэг. Эцэг, эхийн зүгээс анги хүйтэн сэрүүн байгаа талаар гомдол байнга ирдэг.</li> <li>- Цэцэрлэгийн зүгээс жил бүр ангийн хананд хөөсөнцөр наах, цонхны завсрыг чигжих, цахилгаан халаагуур хэрэглэх арга хэмжээг тогтмол авч байсан ч тодорхой үр дүнд хүрдэггүй байсан.</li> </ul>
<b>Зорилтот бүлэг</b>	Цэцэрлэгийн өдрийн 6 бүлгийн 240 хүүхэд 24 цагийн 2 бүлгийн 95 хүүхэд, 37 багш, ажилтан
<b>Шалгуур үзүүлэлт (Төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ)</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг, эх, багш, ажилтнаас бүрдсэн “Хамтарсан баг”-ийг байгуулж, цэцэрлэгийн засвар, бусад ажилд хөндлөнгийн хяналт тавих чиглэлээр 2-3 удаагийн сургалтад хамруулан, сургалтын өмнөх үетэй харьцуулахад хяналт хийх мэдлэг, ур чадвар эзэмшүүлсэн байх</li> <li>- 2019-2020 оны хичээлийн жилд эцэг, эхийн зөвлөлийн ажлыг тогтмолжуулж, цэцэрлэгийн цаашдын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор улиралд нэг удаа доод тал нь 200 эцэг, эхийн дунд санал асуулга зохион байгуулж, үр дүнг нь төлөвлөлтөнд ашиглаж хэвших.</li> <li>- Эцэг, эхтэй хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж өнгөрсөн хичээлийн жилд эцэг эхийн оролцоо 60 хувь байсныг 2019-2020 оны хичээлийн жилд 85 хувьд хүргэх.</li> <li>- Төр, олон улсын байгууллагуудад хандаж цэцэрлэгийн барилгын дулаалга, их засварын ажилд хамрагдаж, 2019-2020 оны хичээлийн жилд дулаан алдалтыг бүрэн арилгана.</li> </ul>
<b>Ашигласан эгэх хариуцлагын арга хэрэгсэл</b>	<p><b>Эцэг эхийн оролцоот аудит</b></p> <p>Ажлын явцад маш чухал, хамгийн том, хамгийн шинэлэг үр дүнтэй ажил нь “Багш, ажилтан, эцэг, эхийн хамтарсан баг”-ийн хөндлөнгийн хяналтын ажил байлаа. Хэдийгээр цэцэрлэгт эцэг, эхийн зөвлөл тогтмол хамтран ажилладаг боловч “Багш, ажилтан, эцэг, эхийн хамтарсан баг”-ийн ажил шинэ тутам үйл ажиллагаа байв. Багийн бүрэлдэхүүнд удирдлагаас 2, багш нар 2, туслах багш 1, эцэг, эх 7, нийт 12 хүн оролцов.</p>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>Барилгын дулааны засварт хяналт тавин, хүүхдийн сайн сайхан, тав тухтай орчныг бий болгохын тулд төслийн хүрээнд хийгдэж буй ажлыг чанартай хийж гүйцэтгүүлэхэд анхаарч, үнэлгээ, дүгнэлт хийн, шаардлага тавьж ажилласан.</p>
<p><b>Хүрсэн үр дүн</b></p>	<p><b>Барилгын засвар:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд манай цэцэрлэг төсөлд хамрагдан, дулааны засвар хийгдсэн нь тус цэцэрлэг байгуулагдсанаас хойш хийгдсэн хамгийн том хөрөнгө оруулалт байлаа. Энэхүү ажлыг Барилгын “Ган зосон” ХХК 301 сая төгрөгийн өртөгөөр гүйцэтгэв. Засварын явцад цэцэрлэгийн ашиглаж байсан 38 вакум цонх, 4 модон цонх, 5 модон хаалга, гадна талын 4 төмөр шатыг хоёрдогч түүхий эдээр Нийслэлд төвлөрүүлэхэд, 2’474’000 төгрөгөөр үнэлэгдлээ.</li> <li>• Сургуулийн Эцэг Эх, Багшийн Үндэсний Нэгдсэн Холбоо (СЭЭБҮНХ) энэ бүхэнд дэмжлэг үзүүлэн, <b>“Багш, ажилтан, эцэг, эхийн хамтарсан баг”</b>-ийн ажлын төлөвлөгөө, хяналт тавих хуваарь, хийх судалгаа, тайлангийн чиглэлийг гарган, бүхий л ажилд дэмжлэг үзүүлсэн. 2018-2019 оны хичээлийн жилд гурван удаа сургалт зохион байгуулж, “Барилгын засварыг хэрхэн хийдэг, яаж хяналт тавих, ямар шаардлага тавих талаар мэдлэг, мэдээлэл өглөө. Үүний үр дүнд хамтарсан багийн засварын үйл явцад хяналт тавих мэдлэг, ур чадвар эзэмшсэн.</li> <li>• Тухайн төсөлд хамрагдсан бусад байгууллагуудын засварын явцтай танилцуулах аяллыг амжилттай зохион байгуулж, туршлага солилцох, нээлттэй үйл ажиллагааг амжилттай явууллаа.</li> </ul>
<p><b>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхам</b></p>	<p><b>“Багш, ажилтан, эцэг, эхийн хамтарсан баг”</b>- ийн үйл ажиллагаа нь <b>“Шинэ сэргэг, хэрэгжүүлэхүйц ажил”</b> гэж үзсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цаашид цэцэрлэгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн, эцэг, эхийг хүүхдийн хөгжилд татан оролцуулах арга хэрэгсэл болгон ажиллахаар төлөвлөсөн.</li> <li>- Сар бүр эцэг, эхэд зориулсан сургалт, уралдаан, тэмцээн зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгасан.</li> </ul>
<p><b>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</b></p>	<p><b>Барилгын ажлын явцад гарсан бэрхшээл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын компани нь ажиллах хүч цөөн, материалын мөнгө ороогүй зэрэг шалтгаанаар барилгын ажил удаашралтай, хугацаандаа эхлээгүй.</li> <li>- Материалын хангамж, нийлүүлэг дутмаг, нийлүүлэлт удаан. Барилгын материал нимгэн, чанаргүй байсныг чанартай материалаар солиулж тавиулсан.</li> </ul> <p><b>“Багш, ажилтан, эцэг, эхийн хамтарсан баг”</b>- ийг бүрдүүлэхэд бэрхшээл тулгарч байлаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өмнө нь эцэг, эхчүүдийн зүгээс цэцэрлэгийн багш, ажилчидтай нэг баг болж, ийм том ажилд хяналт тавина гэсэн ойлголт байгаагүй. Тэд зөвхөн уралдаан тэмцээн, бусад үйл ажиллагаанд хамтран ажилладаг туршлагатай байсан. Тиймээс хамтарсан баг нь цоо шинэ санаачилга байлаа. Хуваарь ёсоор хяналт хийхэд багийн бүрэлдэхүүний оролцоо 70-80 хувь байсан.</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын ажил нь дэлгэр зуны цагт хийгдсэн тул багт хамрагдсан эцэг, эх, багш, ажилтнууд аялал, зугаалгаар явах зэргээр хяналтын ажилд бүрэн хамрагдах боломж бүрдэхгүй байсан.</li> </ul>
<p><b>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйл</b></p>	<p><b>Засварын ажил, “Багш, ажилтан, эцэг, эхийн хамтарсан баг”- ийн үйл ажиллагаа амжилттай явагдахад:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- СЭЭБҮНХ-ны үе шаттай зохион байгуулсан сургалт</li> <li>- Бусад байгууллагын барилгын ажилтай уялдаа холбоотой, олон талын үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан явдал</li> <li>- Байнгын хяналт, үнэлгээ</li> <li>- Хяналтын инженерийн ажлын явцад тавьж буй шаардлага зэрэг нь эерэгээр нөлөөлсөн.</li> </ul>
<p><b>Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл</b></p>	<p><b>Алтанцэцэг (Нийслэлийн БЗД-ийн 63 дугаар цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл)</b></p> <p>Манай хүүхэд тус цэцэрлэгийн 24 цагийн бүлэгт сурч хүмүүждэг. Цэцэрлэг маань тохижилт сайтай, эрхлэгч Н.Энхцэцэг маш санаачилгатай. Багш, хамт олон нь бүтээлч мундаг хүмүүс байдаг. Гэвч цэцэрлэгийн барилгын чанар муудан, дээврээс ус гоожих, дулаан алдах, хананаасаа цанатах, мөөгөнцөрдөх, цонхноос салхи сийгэх зэргээр тохь тухгүй өвөлдөө их хүйтэн байдаг байсан. Харин энэ төсөлд хамрагдан 2019 оны зун барилгын дулаалгын ажил хийгдсэнд эцэг, эх, бид баяртай байна. Одоо хүүгийн маань цэцэрлэг дулаахан, тохилог, өнгө үзэмжтэй сайхан байна. Хүүхдүүд ч цэцэрлэгтээ сэтгэл нь татагдан, тав тухтай дулаахан орчинд байх дуртай болсон. Энэ төсөлд манай хүүгийн цэцэрлэгийг хамруулж, эцэг эх биднээр барилгын засварын явцад хяналт тавиулсан. Биднийг байнга сургалт, зөвлөгөөнд хамруулан, барилгын засвар, дулаалгын явцын талаар мэдлэг, мэдээлэл өгч ажилласан. Та бүхэндээ маш их баярлалаа. Хүүхдүүд маань дулаан, сайхан орчинд, ихийг сурч, мэдэн, зөв сайхан хүн болж сурч хүмүүжинэ гэдэгт итгэлтэй байна.</p>
<p><b>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Тендэрт шалгарсан байгууллага нь гүйцэтгэгч байгууллагатай эргэх холбоотой ажиллах.</li> <li>- Гүйцэтгэгч компанийн багийн бүрэлдэхүүн, ажлын үр дүнд захиалагч тал бодитой хяналт хийж байх</li> <li>- <b>“Багш, ажилтан, эцэг, эхийн хамтарсан баг”-ийн бүрэлдэхүүнийг сонгоход анхаарах</b></li> <li>- Эцэг, эхийн идэвх оролцоо, боловсрол, амьжиргааны түвшин аль аль талыг харгалзан оролцуулах</li> <li>- Ажлын төлөвлөлтөд, хийх ажлыг тодорхой, цаг хугацааг оновчтойгоор тусгах</li> </ul>
<p><b>Холбоо барих хаяг</b></p> 	<p><b>НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 63 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ</b></p> <p>Эрхлэгч Н.Энхцэцэг (Утас: 88198819, э-шуудан: <a href="mailto:tsetse_63@gmail.com">tsetse_63@gmail.com</a>)</p> <p>Арга зүйч Д.Долгоржав (Утас: 88198819, 80878771, э-шуудан: <a href="mailto:dogoo9490@gmail.com">dogoo9490@gmail.com</a>)</p> <p>Багш Н.Наранзул (Утас: 88005734, э-шуудан: <a href="mailto:naranzul_tegsh@yahoo.com">naranzul_tegsh@yahoo.com</a>)</p>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



### НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 158 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



- Бидний тухай
- “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл” манай цэцэрлэгт
- Бусадтай хуваалцах бидний сайн туршлага
- Зургийн цомог



### **НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 158 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ**

Сонгинохайрхан дүүргийн 158 дугаар цэцэрлэг 41 дүгээр хороо, Баянхошууны Баруун салааны Жавхлан Хайрханы 14 дүгээр гудамжинд байрладаг. Нийт 38 багш, ажилтан, хичээлийн 2 байр, 8 бүлэгтэй. Үүнээс гэр салбарын 4 бүлэгтэй. Манай цэцэрлэгт хамран сургах тойргийн 1270 хүүхдийн 326 нь суралцдаг. Гэр салбар бүлэг, цэцэрлэгийн төв байраас 220 метрийн зайтай, 126 гудамжны үзүүрт өөрийн эзэмшлийн 1,100 м<sup>2</sup> талбайд нийт 10 гэрийн 8 гэрт 4 бүлэг, нэг гэрт гал тогоо, нэг гэрт сахиул байрлан ажиллаж байна. 2018-2019 оны хичээлийн жилд Швейцарийн хөгжлийн агентлаг (ШХА), ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны санхүүжилт, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ), Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ээс хамтран хэрэгжүүлж буй **"Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь"** төслийн хүрээнд цэцэрлэгийн барилгын дулаалга, техникийн шинэчлэл хийгдэж, усан сан, хэрэглээний халуун, хүйтэн усны хангамжтай боллоо.

#### **Бидний амжилт:**

- 2012-2014 онд Японы Хүүхдийг Ивээх Сан (ЯХИС)-гаас хэрэгжүүлсэн "Хүүхдэд ээлтэй цэцэрлэг" төслийн хүрээнд зохион байгуулагдсан "Тэргүүн туршлага шалгаруулах" уралдаанд гуравдугаар байр, "Харилцах дэвтрийн шилдэг хөтлөлттэй цэцэрлэг"-ээр;
- 2014 онд "Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч, итгэл хүлээсэн хамт олон" цом, өргөмжлөлөөр;
- 2014 онд багш Л.Наранчимэг, Нийслэлийн хэмжээнд сургалтын чанар, хүртээмжийн үр дүнгээрээ шалгарч 2 сая төгрөгөөр тус тус шагнагдсан үр дүнтэй байна.

#### **Багшийн хөгжил:**

- Манай цэцэрлэг жил бүр "Багшийн хөгжил"-ийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг. Өнгөрсөн жил цөм хөтөлбөрийн сургалтад 7 багш, хоёр болон дөрвөн жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтад Б.Цэнд-Аюуш, Т.Очир нар хамрагдлаа.
- Багш нар дотоод нөөцдөө тулгуурлан хууль эрх зүй, бага насны хүүхдийн хөгжлийн онцлог, сургалтын идэвхтэй аргын сургалтыг баг болж хуваагдан бие биедээ зааж, бүх багш, туслах багш, ажилтнуудаа хамруулж байна.
- Багш, ажилтнуудын дунд "Багшийн авьяасыг алдаршуулья", "Ая дууны эгшиглэн" уралдааныг тогтмол зохион байгуулдаг.
- Дархан Уул аймгийн цэцэрлэгүүдийн туршлага судлах аялалд арга зүйч Н.Цэрэндулам, СХД-ийн 119 дүгээр цэцэрлэгийн туршлага судлах аялалд 15 багш ажилтан оролцлоо.

**“МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ МАНАЙ ЦЭЦЭРЛЭГТ**

**Г.Дарьсүрэн (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 158 дугаар цэцэрлэгийн эмч)**

Миний бие 2011 оноос өнөөг хүртэл 9 жил ажиллах хугацаандаа цэцэрлэгийнхээ хүүхдүүдийн эрүүл мэнд болон эрүүл ахуйн чиглэлээр олон судалгаа, ажиглалт хийсэн. Энэ жил дулааны төсөл хэрэгжсэнээс хойш хүүхдийн өвчлөл эрс буурч, багш ажилчдын ажиллах нөхцөл сайжирч, таатай орчин бүрдсэнд баяртай байна. Хүн бүрийн хувьд ажлын орчин хоёр дахь гэр нь болдог. Энэ ч утгаараа ажил, амжилтын эхлэл гэж боддог.



**С.Азжаргал (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 158 дугаар цэцэрлэгийн тогооч)**

Дулааны төсөл хэрэгжсэнээр халаалт дулаан шийдэгдэж, өнгө төрх сайжран сайхан болсон. Миний гүйцэтгэдэг ажил үүргийн хүрээнд гүний худаг, халуун хүйтэн устай болсон нь нэн чухал амжилт юм. Хоол үйлдвэрлэл, эрүүл ахуйн болон цэвэрлэгээний ажлыг маань хөнгөвчилж өгсөнд баяртай байна. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж “Гал тогооны төхөөрөмж” богино холбоо үүсч тог цохидог байсныг газардлага хийж хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж өгсөн нь чухал байна.

**Бусадтай хуваалцах бидний сайн туршлага:**




**БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН СУРЧ, ХӨГЖИХ АЯТАЙ НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЭХ**

<p><b>Нөхцөл байдал тулгамдсан асуудал</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Манай цэцэрлэг энгийн галлагаа болон шалны халаалтаар дулааны асуудлаа зохицуулдаг. Өвлийн улиралд зогсолтгүй галладаг учир 3 галч 24 болон 48 цагаар ээлжээр ажилладаг, галлагааны нөхцөл хүнд, механик ажил ихтэй байсан.</li> <li>- Хотын төвөөс 19 км алслагдсан дулааны шугам сүлжээнд холбогдоогүй. Ус сувгийн ашиглалтын газар (УСАГ)-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, гүний худгаас усаа зөөвөрлөдөг. Нэг сард 5 тонн усыг 15-20 удаа зөөврөөр авч ашигладаг. Сүүлийн найман жил 00-ын суултуур луу ус зөөж ашигладаг зэргээр маш хүнд нөхцөлд ажиллаж байсан.</li> </ul>
------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА


	<ul style="list-style-type: none"> <li>- Цэцэрлэгийн барилга 2006 онд баригдсан боловч суулт ихтэй, дулаан алдагдал ихтэй, ашиглах боломжгүй байснаас царцсан. 2011 оноос хамран сургах тойргийн хэмжээнд өөр цэцэрлэг байхгүй учир тус барилгыг ашиглан 100 хүүхдийн цэцэрлэгт 180 гаруй хүүхэд авч ажиллаж эхэлсэн.</li> <li>- Зөөврийн устай, халаалтын систем байхгүй учраас байнга хүйтэн устай, хүүхдийн ариун цэврийг сахиулах, гар нүүрийг нь угаалгах, аяга таваг угаах, хоол үйлдвэрлэл, их цэвэрлэгээ хийх зэрэг нь маш хүнд байсан.</li> </ul>
<b>Зорилтот бүлэг</b>	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 41 дүгээр хорооны хамран сургах тойргийн 2-5 насны 380 хүүхэд, тэдний эцэг эх
<b>Шалгуур үзүүлэлт</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Цэцэрлэгийн дулаан алдалтыг бууруулсан хувь хэмжээ</li> <li>- Багш, эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг дэмжсэн болон нэмэлт өөрчлөлт оруулсан бодлогын баримт бичгийн тоо</li> <li>- Цэцэрлэгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд эцэг эхийн зүгээс хөндлөнгийн хяналт тавьж үнэлгээ хийсэн тоо</li> <li>- Эцэг, эхийн санал хүсэлтэд үндэслэн, хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо</li> </ul>
<b>Ашигласан эгэх хариуцлагын арга хэрэгсэл</b>	<p><b>Эцэг эхийн оролцоот аудит:</b></p> <p>Хамтарсан багийн гишүүдийн “Барилгын дулаалгын явцад хөндлөнгийн хяналт хийх” аргачлалын дагуу хяналт үнэлгээ хийж ажилласнаар барилгын засвар сайн хийгдэх, засварт ашиглах материалын чанар сайн байхад нөлөөлсөн. Эцэг эхийн зүгээс хүүхдийн эрүүл ахуй, ирцтэй холбоотой тулгамдаж байгаа асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар хамтран ажилласан.</p> <p><b>Үүний тулд дараах арга аргачлалыг ашигласан.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Багш, эцэг эхийн төлөөлөлтэй ярилцлага хийсэн.</li> <li>• Баримт бичигт дүн шинжилгээ хийж, эцэг эхийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх зүйл заалтыг “Цэцэрлэгийн дотоод журам”-даа нэмж оруулсан.</li> <li>• Асуудлыг илрүүлэх хяналт үнэлгээг хамтдаа хийв.</li> </ul>
<b>Хүрсэн үр дүн:</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Манай цэцэрлэг “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөлд хамрагдсанаар барилгын дулааны асуудлаа бүрэн шийдэж чадлаа. 2018-2019 оны хичээлийн жилд бүх цонх 2 давхар шилтэй дулаан алдалт их байсныг сольж 3 давхар стандарт вакуум цонхтой болов. Гадна дулаалга, барилгын суурийн хаяавч цутгалтын бүрэн хийснээр сууриасаа дулаан алдахыг зогсоож, барилгын хавтгай дээврийг шувуу нуруу болгож нэмэлт цутгалт хийж дээврээ бүрэн шинэчилсэн. Бүх хаалгаа вакуум хаалгаар солин өнгө үзэмжтэй, дулааны алдагдалгүй болгосон. Ингэснээр өмнөх хичээлийн жилд тасалгааны хэм 14 орчим байдаг байсан бол 2019-2020 оны хичээлийн жилд 24 хэмээр өсч сурч хөгжих таатай орчин бүрдэж чадлаа.</li> <li>- Зөөврийн уснаас ангижирч, 101 метр газрын гүнээс цэнгэг ус авах боломж бүхий гүний худагтай болох ажлыг “Солон” кампани 11 сая</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>төгрөгийн өртөгтэй гүйцэтгэн хүлээлгэн өглөө. Ингэснээр эрүүл ахуйн нөхцөл байдал өмнөх онтой харьцуулахад 36 хувиар сайжирсан.</p>
	 
<p><b>Үр дүнг тогтворжуулах алхмууд</b></p>	<p>Хүүхэд, багш, эцэг эхийн хандлагыг өөрчлөх, чадваржуулах, туршлага солилцох зэрэг сургалтыг хичээлийн жилээр төлөвлөн, цэцэрлэгийн багш нартай хамтран зохион байгуулж хэвшсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хамтарсан багийнхан цэцэрлэгийн дулаалга болон засварын явцад хяналт тавьж, хамтран ажилласан;</li> <li>• Хамтарсан багийнхан хүүхдэд зориулсан бусад үйл ажиллагаанд хяналт тавих, тулгамдаж буй асуудлыг шийдэх, нэгдсэн ойлголт туршлагатай болсон.</li> </ul>
<p><b>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын зураг төсөл дээр анхнаас нь хамтарсан баг, ажилчид, бусад холбогдогч талуудын саналыг тусгаж ажиллаагүй учир батлагдсан зургийн дауу ажлаа гүйцэтгэхэд тодорхой бэрхшээл тулгарч байсан.</li> <li>- Байгууллагын цахилгааны холболт далд байрласан учир түүнтэй холбоотой бэрхшээл засварын явцад тохиолдсон.</li> <li>- Эцэг, эхийн зүгээс хүүхдийнхээ сурч хөгжих чиглэлээр цэцэрлэг, багш нартай хамтран ажиллах зөвлөмж хүргүүлж байсан туршлага байхгүй.</li> <li>- Цэцэрлэгийн бодлого, эрхзүйн баримт бичигт эцэг, эхийн оролцооны талаарх заалт дутмаг байсан.</li> </ul>
<p><b>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Цэцэрлэгийн дотоод журамдаа эцэг эх, олон нийтийг хэрхэн оролцуулж, үйл ажиллагааг зохион байгуулах талаар тусгаж өгсөн.</li> <li>• Тухайн барилгын дулаалгын ажилд шалгарсан байгууллага эрх,үүргээ ухамсарлаж ажлыг хурдан шуурхай, чанартай хийж гүйтэтгэсэн</li> <li>• Эцэг эх, багш, ажилчдын нэгдсэн хамтарсан баг идэвхи санаачилгатай ажилласан</li> </ul>
<p><b>Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл</b></p>	<p><b>Н.Эрдэнэбулган (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 158 дугаар цэцэрлэгийн эцэг, эхийн төлөөлөл)</b></p> <p>Хүүхдийн тав тухтай орчин бий болж үр хүүхэд минь цэцэрлэгтээ явах дуртай болсон. Эцэг, эхчүүд бид төсөл хэрэгжиж, засвар хийгдэж эхлэхээс дуусах хүртэл хамт байсан учир өөрсдийн оролцоонд тулгуурлан тохилог дулаан орчинтой болсонд баяртай байна.</p>
<p><b>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Цэцэрлэгийн нийт багш, ажилчдыг чадваржуулах, хандлагаа өөрчлөх, хариуцлагажуулах чиглэлээрх сургалт, үйл ажиллагааг тогтмол хугацаанд төлөвлөн зохион байгуулах;</li> </ul>



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<ul style="list-style-type: none"><li>• Сургалт үйл ажиллагааг чанаржуулах талаарх эцэг эхийн үнэлгээ, санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэр гаргахад оролцуулж, хэрхэн шийдвэрлэснээ эргэж мэдэгдэж, тэдэнд цэцэрлэгт бидний оролцоо дэмжлэг хэрэгтэй гэсэн хандлагыг бий болгоход анхаарах;</li><li>• Эцэг, эхийг цэцэрлэгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хөндлөнгийн ажиглалт, үнэлгээ хийх арга зүйд суралцахад нь туслах;</li><li>• Цэцэрлэгийн дотоод журам, дүрэмд идэвхжсэн эцэг эхийн бүлэг, сайн дурын байгууллагад хэрхэн ажиллах талаар бодлогын баримт бичигт тусгаснаар тогтвортой байдлыг хангах болно.</li></ul>
<p><b>Холбоо барих хаяг</b></p> 	<p><b>Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 41 дүгээр хороо 158 дугаар цэцэрлэг</b></p> <p>Арга зүйч Н.Цэрэндулам (Утас: 86021515, Э-шуудан: <a href="mailto:tserendulam.natsagdorj@gmail.com">tserendulam.natsagdorj@gmail.com</a>)</p> <p>Багш Д.Сайхантуяа (Утас: 94119047, Э-шуудан: <a href="mailto:saihanaa.dangaa@gmail.com">saihanaa.dangaa@gmail.com</a>)</p>



БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 55 ДУГААР СУРГУУЛЬ**



- **Бидний тухай**
- **“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл манай сургуульд**
- **Бусадтай хуваалцах бидний сайн туршлага**
- **Зургийн цомог**

## БИДНИЙ ТУХАЙ

Нийслэлийн мэргэжлийн сургалттай 55 дугаар сургууль 1976 оны 10 дугаар сарын 2-нд Улаанбаатар хотын Боловсролын хэлтсийн даргын 50 тоот тушаалаар байгуулагдсан. 1978 оноос Найрамдлын районы 55 дугаар тусгай сургууль болж, хамран сургах тойргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлж ирсэн. 2001-2002 оны хичээлийн жилээс мэргэжлийн сургалттай 55 дугаар сургууль болон өргөжиж 1-9 дүгээр ангийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, 10-11 дүгээр ахлах ангийн хүүхдүүд бүрэн дунд боловсрол олгохын зэрэгцээ оёдол эсгүүр, компьютер оператор, модон эдлэлийн мужаан, тогооч нарийн боовчин, үсчин, гоо сайхан зэрэг 6 чиглэлээр мэргэжил эзэмшүүлж байна. 2015-2019 оны хичээлийн жилээс оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бие даасан амьдрал, хөдөлмөрт бэлтгэх зорилгоор 10-12 дугаар ангид мэргэжил эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа явуулж байна. 2019-2020 оны хичээлийн жилд хөгжлийн онцлог ялгаатай 500 гаруй сурагчид суралцаж, 138 багш, ажилтан боловсролын үйлчилгээ үзүүлж ирлээ.

Манай сургууль хөгжлийн онцлог ялгаатай сурагчдад боловсролын үйлчилгээг чанартай олгож, тэднийг амьдрал хөдөлмөрт бэлтгэн, бодит чадвартай иргэн болгон төлөвшүүлэх, дүүргийн хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд бүрэн хамруулж, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсрол олгох, ахлах ангийн сургалтаар бүрэн дунд боловсролыг мэргэжлийн чиг баримжаатай хослуулан олгохыг эрхэм зорилго болгон ажиллаж байна.

### Бидний амжилт:

- 2015 онд Ногоон байгууламж, цэмцгэр орчин “Нийслэлийн шилдэг байгууллага”
- 2017 онд “Хүүхдийн хөгжлийг дэмжигч” байгууллага
- 2019 онд Нийслэлийн хэмжээнд 255 сургууль, шилдэг 20 сургуулиас 7 дугаар байрт шалгаран “Индексийн урамшуулал”-ын шагналыг тус тус хүртлээ.



### “МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ МАНАЙ СУРГУУЛЬД

#### Ч.Ганбилэг (Нийслэлийн Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулийн захирал)

Манай сургуулийн барилгын дулаалга, засвар үйлчилгээний ажлыг “Great Mining” ХХК гүйцэтгэж гадна фасадны дулаалга, дотор дулааны шугам шинэчлэх, 237 цонх, 13 хаалга солих, дээврийг сэндвичээр дулаалах зэрэг 844 сая төргөгийн санхүүжилттэй иж бүрэн засварын ажил хийгдлээ. Сурагчдын сурч боловсрох таатай орчин бүрдүүлэхэд багш, ажилчдаас гадна эцэг эхчүүдийн үүрэг,

оролцоо маш чухал гэдэг энэ төслийн хүрээнд хийгдэж байгаа ажлуудаас батлагдаж байна. Эцэг эхчүүд маань энэ төслийн хүрээнд СЭЭБҮНХ-оос хэрэгжүүлдэг “Сайн сургуулийг дэмжих аргачлал”-ын дагуу сургуулийн засаглал, сэтгэл зүй болон материаллаг орчны хувьд үнэлгээ хийсэн. Барилгын засварын явцад хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийсэн. Энэ явцдаа бид хамтдаа эвлэлдэн нэгдэж, сургуультай хамтран ажиллаж, хүүхдийнхээ хөгжил, төлөвшлийг дэмжих нь чухал гэж үзэн “Эцэг эх, хүүхэд хөгжлийн төв” ТББ-ыг байгуулсан. Бид энэ ТББ, эцэг эхчүүдтэйгээ хамтран сургуулийнхаа явган хүний зам, хүүхдээ хүргэж өгч, хүлээн авдаг машины түр зогсоолыг барьж байгууллаа. Хичээлийн жилийн эхэнд эцэг эхчүүдийг байлцуулан, сурагчдын гарааны үнэлгээг хийж, түүний үр дүнд үндэслэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.



### **Б.Бямбажав (Нийслэлийн Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулийн нийгмийн ажилтан)**

2018-2019 оны хичээлийн жил манай сургуульд үр өгөөжөө өгсөн сайхан жил боллоо. Миний хувьд “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн сургууль дээр зохион байгуулалтад орсон “Хамтарсан баг”-ийн ахлагчаар ажилласан. Хамтарсан багт багш, ажилтан, эцэг эх, сурагчийн төлөөлөл бүхий 15 хүн орж, сургуулийн барилгын

засварын үйл явцад хяналт тавьж, сургуулийн удирдлага, хяналтын инженертэй хамтран, хяналтын явцад илрүүлсэн асуудлыг шийдвэрлэж ажилласан. Манай сургууль энэ төсөлд хамрагдсанаар сурагчдын эрүүл аюулгүй, сурч боловсрох, таатай орчин бүрдэж, тохилог дулаахан орчинд ажиллах болсондоо багш, ажилчид бид сэтгэл хангалуун байна. Тэр бүр томоохон төсөлд хамрагддаггүй, манай сургуулийг сонгон хэрэгжүүлсэнд баяртай байна.

### **Лхагвадорж (Нийслэлийн Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулийн 6А ангийн сурагч А.Оюу-Эрдэнийн ээж)**

Энэ төсөл хэрэгжихээс өмнө манай хүүгийн сургууль маш хүйтэн, хүүхдүүд хичээл хийхэд тухгүй, өвчлөл өндөр, хичээлийн ирц хангалтгүй, багш нарын ажиллах нөхцөл маш муу байсан. Цонхны хамгаалалт муу, хүүхэд бэртэж гэмтэх магадлал өндөр байв.

Сургуулийн хэмжээнд зарлагдсан хурал цуглаанд эцэг эхчүүдийн 30-40 хувь ирдэггүй, эцэг эхчүүд хүүхдийнхээ төлөө анхаарал халамж тавихдаа учир дутагдалтай, үүрэг хариуцлагаа ухамсарладаггүй байсан. Эцэг эхчүүд, багш нарын хооронд ч үл ойлголцох асуудал нэлээд гардаг байлаа. Манай хамтарсан багийнхан сургуулийнхаа засаглал, сэтгэл зүй болон материаллаг орчинд үнэлгээ хийсэн. Мөн нэг удаа эцэг, эх болон сурагчдаасаа санал асуулга авч, 2 удаа эцэг эхийн нэгдсэн хурал зохион байгуулсан. Одоо



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

эцэг эхийн оролцоо 70-80 хувь болж өссөн. Эцэг, эхчүүд сургуулиас санаачлан зохион байгуулдаг сургалт, уулзалт, арга хэмжээнд идэвхтэй оролцож, багш нарын ажлын ачааллыг ойлгосноор хамтран ажиллах эерэг хандлагууд ажиглагдаж эхэлсэн.

Энэ төсөл хэрэгжсэнээр хүүхэд, багшийн өвчлөл буурч, хичээлийн ирц нэмэгдэж, багш ажилчдын ажиллах нөхцөл тухтай болсон. Эцэг эхчүүд нэгдэж “Эцэг эх, хүүхэд хөгжлийн төв” ТББ байгуулж үйл ажиллагаагаа явуулснаар, эцэг эхчүүд хамтран ажиллах, хүчээ нэгтгэх сайхан эхлэл бий боллоо.

### **Б.Намуун (Нийслэлийн Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулийн сэтгэл зүйч)**



“Сайн сургуулийг дэмжих аргачлал”-ын хүрээнд сургуулийн захиргаа, багш, сурагч, ажилчид, эцэг эхийг хамруулан сургуулийн сэтгэл зүйн орчны үнэлгээ хийсэн. Үнэлгээгээр сургуулийн багш, ажилчдын харилцаа, хандлага эерэг, тааламжтай боловч тав тухтай орчинд ажиллаж чаддаггүй гэж үзсэн. Тав тухтай орчинг бүрдүүлэхэд гол тулгарч байгаа асуудал сургууль маш хүйтэн, дулаан алдалт их хэмээн үнэлсэн байсан. Дулаан алдалтаас болж багш, сурагчид гадуур хувцастайгаа хичээллэх тохиолдол ч гарч байсан. Төсөл хэрэгжсэнээс хойш дулаан алдалт арилж, сургууль, эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа эрс сайжирсан. Эцэг эхийн зөвлөлөөс санаачлан сургуулийн гадна талбайд тодорхой ажлыг хийж гүйцэтгэсэн. Төслийн дэмжлэгтэй эцэг эхчүүдийн сургууль, хүүхдийн сурах

орчинд хандах хандлага, оролцоо ихэссэн. Ингэснээр хүүхэд аюулгүй, эрүүл, тав тухтай орчинд сурч боловсрох таатай нөхцөл бүрдэж байна.

### **Бусадтай хуваалцах бидний сайн туршлага:**

#### **СУРГУУЛЬ, БАГШ, ЭЦЭГ ЭХИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ НЬ**

<b>Нөхцөл байдал тулгамдсан асуудал</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Манай сургуулийн эцэг эхчүүд сургуулиас зохион байгуулдаг аливаа ажилд идэвх санаачилга бага, 50-60 хувийн ирцтэй оролцдог. Хүүхдийнхээ нэмэлт дэмжлэг, ялгаатай байдлаас үүдэн аливаа зүйлд эмзэг ханддаг, сургууль эцэг эхийн хоорондын холбоо сул, сургуулиас тавьсан шаардлага, санаачилгыг ихэнх тохиолдолд сөрөг хандлагаар хүлээн авдаг байсан.</li> <li>- Тусгай сургууль гэж нэрлэдэг ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин бүрдээгүй, хүүхэд аюулгүй зорчих нөхцөл, явган зам, гарц, автомашины зогсоол байхгүй. Сургуулийн хашаанд автомашины зогсоол байхгүйгээс болж хүүхэд бэртэж, гэмтэх аюултай нөхцөлд байсан.</li> <li>- Нийт суралцагчдын 45 хувь нь амьдралын баталгаажих төвшин доогуур орлоготой, гэр хорооллын хүүхдүүд суралцдаг учир нэг автобус хүрэлцэхгүй, хүүхдүүдийн хичээл хоцрогдол өндөр байсан.</li> </ul>
-----------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	- Анги танхимын хүйтэн тохь муутайгаас үүдэн, анги танхимын тохижилт хангалтгүй.
<b>Зорилтот бүлэг</b>	55 дугаар сургуулийн 500 сурагч, тэдний эцэг эх, 138 багш, ажилтан
<b>Шалгуур үзүүлэлт</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эхчүүдийн оролцоог 25-30 хувиар нэмэгдүүлнэ.</li> <li>- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид, хот тохижилтын газрын удирдлага болон холбогдох төлөөлөлтэй уулзаж, сургуулийн онцлог нөхцөл байдлыг ойлгуулан, яван хүний замын газрын болон холбогдох зөвшөөрлийг авч, 2019-2020 оны хичээлийн жил эхлэхэд сургуулийн гадна автомашины зориулалтын зогсоол, явган хүний замтай болсон байна.</li> <li>- Сургуулийг нэмэлт автобустай болгоно.</li> <li>- Ангийн тохижилтыг сайжруулж, хүүхэд сурч хөгжих таатай орчинг бүрдүүлнэ.</li> </ul>
<b>Ашигласан хариуцлагын хэрэгсэл</b>	<p><b>Эгэх арга</b></p> <p><b>Оролцоот бодлого боловсруулалт:</b> Сургуулийн эцэг эх, асран хамгаалагчдын оролцоотой сургалтын таатай орчин бүрдүүлэхийн тулд эцэг эхийн төлөөллөөр сургуулийн бодлого, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ хийлгэж, бодит нөхцөл байдлыг илрүүлсэн. Ялангуяа сургуулийн хэмжээнд мөрдөж буй бодлого, эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэхэд ямар асуудал тулгамдаж байна, тэдэнд ямар хэрэгцээ шаардлага хэрэгтэй байна, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар холбогдох хүмүүсийн санал бодлыг сонсож, шаардлагатай зүйл заалтын өөрчлөлтийг сургуулийн баримт бичигт оруулсан болно.</p> <p><b>Үүний тулд дараах арга, аргачлалыг ашигласан.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Сургуулийн удирдлага, багш, эцэг эхчүүдийг хамруулсан бүлгийн ярилцлага зохион байгуулсан;</li> <li>▪ Сургуулийн өнөөгийн нөхцөл байдал тулгамдаж буй асуудлыг илрүүлэх хэлэлцүүлгийн шат шатны төлөөллийг оролцуулан зохиосон;</li> <li>▪ Сургуулийн нийт бодлого, эрх зүйн баримт бичирг, сурагчдын ерөнхий мэдээлэлд тулгуурлан баримт бичгийн судалгаа шинжилгээг тус тус хийсэн.</li> </ul> <p><b>Оролцоот төлөвлөлт:</b> Оролцоот бодлого боловсруулах аргачлалыг ашиглаж, холбогдох мэдээлэл материалд дүн шинжилгээ хийж байх явцдаа хамгийн түрүүнд идэвх оролцоо сул эцэг эхчүүдийг оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах нь чухал юм байна гэж сургуулийн удирдлага, эцэг эх, багшийн “Хамтарсан баг” үзсэн. Ингээд хүүхдийнхээ төлөө тавих хараа хяналт сул, сургууль, багш нартай хамтран ажиллах идэвх оролцоо тааруу эцэг эхэд идэвхжүүлж, тэдний оролцоог нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн. Ингэснээр тэдний санал бодлыг сонсож, сургуулиас аливаа шийдвэр гаргах болон хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхдээ аль болох тэдний оролцоог хангахад анхаарч ажилласан.</p> <p>Оролцоот төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ дараах арга аргачлалыг ашиглав.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан “Нээлттэй Зүрх” сэтгэл зүйн сургалт</li> <li>- Сургуулийн дотоод болон гадаад нөхцөл тогтоох “Аюулгүй орчин” хөндлөнгийн үнэлгээний арга</li> </ul>


## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p><b>Эцэг эхийн оролцоот аудит:</b> Эцэг эхчүүдийг хүүхдийнхээ сургалтын явц, сургуулиас зохиогдож буй бусад үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, санал хүсэлтээ илэрхийлэх боломжийг бүрдүүлэхдээ “Эцэг эхийн оролцоот аудит”-ын аргыг ашигласан.</p> <p><b>“Эцэг эхийн оролцоот аудит”-ын аргыг ашигласнаар манай сургуульд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эхчүүд сургуулийн үйл ажиллагааны талаар сургуулийн удирдлага, багш нарт санал бодлоо хуваалцах “<b>Цахим харилцаа</b>”-г бий болгосон. Ингэснээр эцэг эхчүүд сургуулийн удирдлагатай цаг алдахгүй холбогдож, хүүхдийнхээ хөгжил, төлөвшил, сурлагын амжилт, сургуулиас шаардлагатай дэмжлэгийн талаар санал бодлоо солилцдог болж байна.</li> <li>- Эцэг эхчүүд, сургуулийн нөхцөл байдал, шаардлагатай дэмжлэгийн талаар нарийвчлан мэдээлэлтэй болж, цаашид зохион байгуулалтад орж, байнга хамтран ажиллаж хүүхдийнхээ сурч, хөгжихөд дэмжлэг үзүүлэхээр санаа нэгдэн “<b>Эцэг эх, хүүхэд хөгжлийн төв</b>” төрийн бус байгууллага (ТББ) байгуулагдсан.</li> </ul>
<p><b>Хүрсэн үр дүн</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эх, асран хамгаалагчдын дунд 2 удаа нэгдсэн хурал, 1 удаа хэлэлцүүлэг, 2 удаа сургалт мэдээлэл явагдснаар эцэг эхийн оролцоо засарч, 70-80 хувь нь хурал цуглаанд идэвхтэй хамрагдаж, тэдний хандлага эерэг болэ байгаад баяртай байгаа.</li> <li>- Эцэг эхийн санаачилгаар сургуулийн гаднах явган хүний замын асуудлыг бүрэн шийдэж чадлаа. Энэ ажилд сургуулийн нийт эцэг эхчүүдийн 75 хувь нь идэвхтэй оролцсон. Зохион байгуулалтад орсон эцэг эхчүүд сургуульд тулгамдаж байгаа асуудлыг шийдэхдээ өөрсдийн боломжийг эрэлхийлэхээс гадна бусад боломжийг хайж байгууллага, аж ахуйн нэгжтэй холбогдож эхэлсэн нь сайшаалтай.</li> <li>- Эцэг эхийн төлөөлөл Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, хот тохижилтын газрын удирдлагатай уулзалт сургуулийн ойролцоох явган хүний газрын асуудлыг шийдүүлж чадлаа.</li> <li>- “Таван толгой түлш” ХХК-ны удирдлагатай уулзаж, сургуулийн нөхцөл байдлаа ойлгуулан, тус компанийн хөрөнгө оруулалтаар болох 2 сая төгрөгөөр сургуулийн хашаанд автомашины зогсоолын асуудлыг бүрэн шийдэж чадлаа.</li> <li>- Сургуулийн эмчид нэн шаардлагатай байсан 630.0 мянган төгрөгийн өртөг бүхий иж бүрэн автомат орыг “Таван толгой түлш” ХХК-ны санхүүжилтээр худалдан авлаа.</li> <li>- Эцэг эхчүүд нийт суралцагчдын сургуульдаа ирж очиход үүсдэг хүндрэл, амьдарч байгаа газар зүйн байрллаар нарийвчилсан судалгаа хийж, сургуулийн удирдлага бусад төлөөлөлд танилцуулснаар сургуулийн захиргааны зүгээс нэмэлт нэг автобустай болгов.</li> </ul>
<p><b>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургуулийн эцэг эхчүүдийн санаачилгаар байгуулагдсан “Эцэг эх, хүүхэд хөгжлийн төв” ТББ нь сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулж, тухайн хичээлийн жил хамтран зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан хамтран баталж хэрэгжүүлдэг болсон. Энэ нь сургуулийн захиргаа, эцэг эхчүүд нэгдмэл ойлголттой хамтран ажиллахад үр дүнтэй зохицуулалт болж байна.</li> <li>- Жил бүр сургуулийн захиргаатай хамтран нийт эцэг эхийн нэгдсэн хурал хагас жил тутам зохион байгуулдаг уламжлал бий болгож эхлэв.</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эх, амран хамгаалагчдад зориулан улирал тутам сэтгэлзүйн сургалт зохион байгуулж байна.</li> </ul>
<p><b>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургуулийн бодлого, эрх зүйн баримт бичигт эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо, хариуцлага, хамтын ажиллагааны талаар тусгасан зүйл, заалт хангалттай байсан ч эцэг эхчүүд тухайн зүйл заалтын талаар ямар ч мэдээлэлгүй байв. Энэ нь эцэг эхчүүдэд сургуулийн талаар буруу ойлголт төрүүлж, сөрөг хандлагатай болоход нөлөөлж байгаа нь анзаарагдсан юм.</li> <li>- Бусад сургуулийн эцэг эхчүүдийг бодоход хүүхдүүд нь дан болон хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй учир ихэнх эцэг эхчүүд сэтгэл зүйн хямрал, бухимдалтай, алвиаа зүйлд итгэх итгэл муутай нь эцэг эхчүүд нэгэн зорилгын төлөө нэгдэн хамтран ажиллах уур амьсгалыг бүрдүүлэхэд бэрхшээлтэй байсан учир хамгийн түрүүнд тэдэнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сургалт, бусад үйл ажиллагаанаас эцэг эхийн идэвх оролцоог нэмэгдүүлэх аждаа эхлэхээр шийдсэн.</li> </ul>
<p><b>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургуулийн хэмжээнд бий болж байгаа эдгээр эерэг өөрчлөлт, ололт амжилтыг бий болоход олон байгууллага, хүмүүсийн хүчин зүтгэл нөлөөлсөн. Ялангуяа сургуулийн удирдлага, багш нар эцэг эхчүүдийн зүгээс гаргасан аливаа санал, санаачилгыг байнга дэмжин, бүхий л зохицуулалтыг хийж байна.</li> <li>- Энэ санаачилгыг эхлүүлэхэд эцэг эхчүүдийн сургуулийн талаар ойлголт хандлага харилцан адилгүй байсан бол аажмаар өөрчлөгдөж одоогийн байдлаар тэдний оролцоо 50 хувьд хүрсэн төдийгшү сургуулийн үйл ажиллагаанд оролцдог, дэмжлэг эерэг хандлагатай болж байгаа нь сайнг эхлэл юм.</li> <li>- Сургуулийн тулгамдаж буй асуудлыг дан ганц сургуулийн удирдлага, багш нуруундаа үүрэх бус эцэг эхчүүдтэйгээ хамтран ажиллаж хүчээ нэгтгэснээр олон боломж бий болдогийг энэ хугацаанд мэдрэгдсэн. Төр, төрийн бус, олон улс, хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагууд сургуулийн нөхцөл байдлыг ойлгосноор тусалж дэмжихэд бэлэн байдгийг мэдэрлээ.</li> </ul>
<p><b>Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл</b></p>	<p style="text-align: center;"><b>ХҮСЭЛ МӨРӨӨДЛӨӨР ЖИГҮҮРЛЭСЭН ХӨӨРХӨН ЗҮРХ БҮРТ ИТГЭЛ БЭЛЭГЛЭЕ...</b></p> <p><b>Т.Түмэн-Өлзий (Нийслэлийн Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулийн эцэг эхийн төлөөлөл)</b></p> <p>Би энэ сургуулийн 2г ангийн эцэг эхийн зөвлөлийн даргын үүрэгт ажлыг хийдэг. Манай сургуулийн “Эцэг эхийн зөвлөл ТББ” нь эцэг эхчүүдэд сургууль багш нартай хэрхэн хамтран ажиллах талаар нэлээдгүй арга хэмжээ авч байгаа. Үүнд эцэг эх сургуультай хамтарсан хурал, сэтгэл зүйн сургалт семинар зохион байгуулсан. Энэ нь эцэг эхчүүдийн сургуульд хандах хандлагыг эергээр эргүүлж багш нараа дэмжин ажиллах тал дээр нэлээдгүй ахиц гарсан.</p> <p>Мөн сургуулийн гаднах орчинг сайжруулж хүүхэд явах явган хүний зам, зорилтот бүлгийн хүүхдүүдийн эцэг эхчүүдийн машиныг сургуулийн хашаанд оруулах таатай нөхцлийг бүрдүүлсэн. Сургуулийн нийт багш ажилтан болон нийт эцэг эхчүүддээ ажлын амжилт хүсье.</p>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

<b>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</b>	<ul style="list-style-type: none"><li>- Эцэг эхчүүдийг сургуулийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч, хөндлөнгийн ажиглалт, үнэлгээ хийх аргад суралцахад тусалж сургуулийн орчинд тулгамдаж буй асуудлыг тэдний оролцоотойгоор илрүүлж, шийдвэрлэхэд анхаарах;</li><li>- Сургуулийн дүрэм, дотоод журам, эцэг эхийн эрх, үүрэг, хариуцлагыг эцэг эхчүүдэд энгийн ойлгомжтой байдлаар тайлбарлан ойлгуулж, хүүхдийнхээ хөгжил, төлөвшлийг дэмжихэд эцэг эх таны оролцоо дэмжлэг чухал гэдэг сэтгэл зүйг бий болгоход анхаарах;</li><li>- Сургалтын чанарыг сайжруулахад эцэг эхчүүдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэр гаргахад оролцуулж, хэрхэн шийдвэрлэсэнээ эргэн мэдэгдэж, тэдэнд сургуульд бидний оролцоо, дэмжлэг хэрэгтэй гэсэн хандлагыг бий болгох нь чухал санагдсан.</li></ul>
<b>Холбоо барих хаяг:</b> 	Сургуулийн захирал: Ч.Ганбилэг (Утас: 99152215, э-шуудан: <a href="mailto:ganbileg.ch1@gmail.com">ganbileg.ch1@gmail.com</a> ) Нийгмийн ажилтан: Б.Бямбажав (Утас: 99712010, э-шуудан: <a href="mailto:banzragchbyamjaw@gmail.com">banzragchbyamjaw@gmail.com</a> ) ТББ-ын тэргүүн: Д.Зандантулга (Утас: 88903638)



ЗУРГИЙН ЦОМОГ





## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



### НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 74 ДҮГЭЭР СУРГУУЛЬ



- Бидний тухай
- “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл” манай сургуульд
- Бусадтай хуваалцах бидний сайн туршлага
- Зургийн цомог

## БИДНИЙ ТУХАЙ

Нийслэлийн Ерөнхий боловсролын 74 дүгээр сургууль нь 1970 онд байгуулагдсан, Улаанбаатар хотоос 56 километрийн зайтай Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Жаргалант тосгонд байрладаг. Хамран сургах тойргийн буюу Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Жаргалант тосгоны төв, Нарийн, Шар хад, Гүнт, 335 дугаар зөрлөг, төмөр замын 347 дугаар зогсоол, Сааль, Халзангийн ам, Мухрын ам зэрэг өргөн хүрээг хамран, малчид, төмөр замчдын хүүхдэд ерөнхий боловсролын үйлчилгээг үзүүлж байна. Тус сургуулийн 20 бүлэгт 284 эрэгтэй, 294 эмэгтэй нийт 578 суралцагч буюу бага ангид 332, дунд ангид 176, ахлах ангид 70 суралцагч тус тус суралцаж байна.

Нийслэлийн дотуур байртай цөөн сургуулийн нэг нь 74 дүгээр сургууль бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд нэгдүгээр байрны 12 тасагт, 9-18 насны 50 охин, 7 тасагт, бага бүлгийн 6-8 насны 53 сурагч, хоёрдугаар байрны 8 тасагт, 9-18 насны 73 хөвгүүд буюу нийт 176 хүүхэд амьдарч байна.

Нийт 62 багш, ажилтантай. Багш нарын 82 хувь боловсролын магистр, 58 хувь мэргэжлийн тэргүүлэх болон заах арга зүйч зэрэгтэй. Анги танхимын 66 хувь кабинетын гэрчилгээтэй, 2 ээлжээр хичээллэдэг анги дүүргэлт дунджаар 27.6 сурагчтай байна.

### “МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ МАНАЙ СУРГУУЛЬД

**М.Сэрсэндагва (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 74 дүгээр сургуулийн физик мэдээлэл зүйн багш)**


Манай анги модон цонхтой, цонхны засвараар салхи, шороо их орж ирдэг. маш хүйтэн, тухгүй байсан. Сурагчид гадуур хувцастайгаа суухаас аргагүй, өвөл болохоос өмнө цонх дулаалах гэдэг айхавтар ажил байлаа. Зургаан настнууд гадаа нойлд бие засах их амаргүй байсан. Энэ жил энэ бүхэн шийдэгдэж дулаахан тав тухтай сайхан байна. Сурагчид маань ч маш их баяртай байгаа нь илт харагддаг. Одоо манай сургууль дулаахан, өнгө үзэмжтэй болсноос гадна нойлын асуудлыг шийдэж, дотуур байрын сурагчид усанд ордог душтэй болсон. Энэ төсөл нь бүтээн



байгуулалт хийснээс гадна “Хамтарсан баг” байгуулж эцэг эх, багш, сурагчид хамтдаа өөрсдийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагынхаа талаар үзэл бодлоо илэрхийлж, сургуулийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад хамтран ажиллаж байгаа нь их таалагдсан. Энэ бүхнээс үүдсэн хамгийн чухал өөрчлөлт бол багш, эцэг эх, сурагчдын сургуульдаа, хичээл сургалтдаа, өөр хооронд харилцах хандлага сайнаар өөрчлөгдөж байгаа нь хамгийн чухал юм.

**Бусадтай хуваалцах бидний сайн туршлага:**

**СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД СУРАЛЦАГЧДЫН ОРОЛЦОО, САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ НЬ**

<p><b>Зорилго</b></p>	<p>Дунд, ахлах ангийн сурагчид болон Сурагчдын өөрөө удирдах зөвлөл (СҮӨЗ)-ийн оролцоотой сургуулийн орчинд тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэн шийдэж, сургалт, сэтгэл зүйн орчинд эерэг өөрчлөлт бий болгох</p>
<p><b>Нөхцөл байдал тулгамдсан асуудал</b></p>	<div style="display: flex; align-items: flex-start;"> <div style="flex: 1;"> <p>Жил бүр манай сургуулиас багш нарын дунд зохион байгуулдаг сурган хүмүүжүүлэх илтгэлд багш М.Сэрсэндагва “<b>Ээлжит хичээлийн технологи ба хүүхдийн хөгжил</b>” илтгэл тавьсан юм. Илтгэлд сурагчдын хэрэгцээ сонирхлыг харгалзан, хичээл сургалт болон сургуулийн бусад ажилд тэдний идэвх оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатайг судалгааны үндсэн дээр дэвшүүлсэн.</p> <p><b>Тухайлбал;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сургууль дээр сурагчдын санаачилга, зохион байгуулалтаар байгуулагдсан Сурагчдын өөрөө удирдах зөвлөл (СӨУЗ) ажилладаг боловч тухайн зөвлөл жилд 1-2 удаа сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулах төдийгөөр үйл ажиллагаа нь хязгаарлагддаг болсон учраас СӨУЗ-ийн үйл ажиллагааг идэвхжүүлж, сурагчдыг үзэл бодлоо илэрхийлэх, эрх ашгийг хамгаалах, эвлэлдэн нэгдэхэд чиглүүлэх хэрэгтэй байна.</li> <li>- СӨУЗ-ийн гишүүд сургуулийн бодлого, үйл ажиллагаанд нөлөөлөх зорилгоор санал бодлоо хуваалцахыг хүсдэг ч хэрхэн илэрхийлэх учраа олохгүй байгаа нь ангийн дарга нар болон СӨУЗ-тэй хийсэн бүлгийн ярилцлагаар тодорхой болсон.</li> <li>- Анги бүрээс хичээл сургалтын үйл ажиллагаанд нийт сурагчдын 25-30 хувь идэвхтэй оролцож бусад нь дагалдан дуурайх байдлаар идэвхгүй оролцдог нь ажиглалтаар илэрхий болсон.</li> <li>- Сурагчид сургуулийн эд хогшилд хайр гамгүй, өөрт огт хамаагүй мэтээр санаатай болон санамсаргүй эвдэлж гэмтээж байгаа нь ажиглалтаар харагдаж байсан.</li> <li>- Дотуур байрын сурагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх хөгжлийн төв, тоглоомын талбайгүйгээс ангийнхаа хүүхдийнд очих нэрийдлээр гадуур хэсэх, дэмий сэлгүүцэх, гар утсаар хэт удаан тоглож байгаа нь ажиглалтаар илэрсэн байна.</li> </ul> </div> <div style="flex: 1; text-align: right;">  </div> </div>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА



- “Сайн сургуулийг дэмжих аргачлал”-аар сургуулийн өнөөгийн байдлыг засаглал, сэтгэл зүй болон материаллаг орчны хүрээнд үнэлэхийн зэрэгцээ жижүүр багшийн хөтөлсөн сурагчдын ирц, өвчлөлийн мэдээлэлд үндэслэн сургуульд тулгамдаж буй асуудлаа дараах байдлаар тодорхойлсон юм.

### Үүнд:

- Сургуулийн зарим анги 0-10°C орчим хэмийн хүйтэн учир хүүхдүүд ханиад тусах, өвчлөх байдал өвлийн улиралд илүү өндөр хувьтай байсан. 2018-2019 оны хичээлийн жилд I улиралд нийт суралцагчдын 12%, II улиралд 18%, III улиралд 14%, IV улиралд 10% гэх мэтээр нийт суралцагчдын дунджаар 13.5% ханиад болон бусад эрүүл мэндийн шалтгаанаар 2-5 хоногийн чөлөөг багшаас болон эмчээс авчээ.
- Өнгөрсөн өвөл 3 удаа нойль бөглөрч, гар угаагуурын 6 крантаас 5 крант эвдэрч, засварлах шаардлагатай болсон.
- Сурагчид анги танхимын эд хогшилд гамгүй хандсанаас нийт эд хогшлын 35-40 хувь эвдрэлтэй.
- Сургуулиас нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг ажил, бодлого эрх зүйн баримт бичгийн зүйл заалтын мэддэг эсэхийг сурагчдаас тодруулахад тэдэнд ямар ч мэдээлэл байхгүй байв. Энэ нь сургуулийн зүгээс аливаа бодлого эрх зүйн баримтад оруулах өөрчлөлт, төлөвлөлт хийхдээ сурагчдын санал бодлыг тусгадаггүй. Тэдэнд сургуулийн ажил бидэнд хамаагүй гэсэн “хүниймсэг” хандлагыг суулгаж байгаа нь анзаарагдав.
- Дотуур байранд 176 хүүхэд амьдардаг, ариун цэвэр, эрүүл ахуйн орчин бүрдээгүй, угаалтуур, суултуур хүрэлцээгүй нь тогтоогдсон юм.

### Зорилтот бүлэг

Дунд, ахлах ангийн 246 сурагч, 32 багш, дотуур байрны 176 хүүхэд

### Шалгуур үзүүлэлт(төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ)

- 2019 оны 10 дугаар сарын 20 гэхэд дотуур байрын сурагчдын чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх боломжийг хангаж гадна талбайн сагсны шийдийг иж бүрэн тохижуулснаар дотуур байрны сурагчдын 65 хувь нь чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчинтой болно.
- 2019 оны 10 дугаар сарын 1 гэхэд ашиглагдахгүй байсан заалыг стандартын дагуу засварлан ашиглалтад оруулж нийт суралцагчдын 70 хувьд нь тухайн заалыг ашиглах, хөгжих, чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх орчин бүрдсэн байна.
- 2018-2019 оны хичээлийн жилд “Монгол дахь эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд Герман технологийн дагуу сургуулийн барилгын дулаалга, дээврийн асуудлыг бүрэн шийдэж, 45 цонх, сантехникийн шугамыг бүрэн засварласан.
- 2019-2020 оны хичээлийн жил эхлэх үеэр дотуур байрны ариун цэврийн өрөөг эрүүл ахуйн шаардлага хангахуйц байдлаар бүрэн тохижуулж, гурван нойл,



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>хоёр душтэй болгон засварлаж, дотуур байрны нийт 85 сурагч ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2019-2020 оны хичээлийн жилд сургуулийн зорилго, зорилт тодорхойлох, хичээлийн жилийн төлөвлөгөө боловсруулах, сургуулийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх зэрэгт дунд, ахлах ангийн сурагчдын оролцоог нэмэгдүүлэн 80 хувьд хүргэнэ.</li> <li>- 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн сургуулийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт, хичээлээс гадуур хүүхдийг хөгжүүлэх хөтөлбөр болон сургуулийн үйл ажиллагаанд дунд, ахлах ангийн суралцагчид, эцэг эх, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр зохион байгуулах ажлын талаар санал асуулга, хэлэлцүүлэг зохион байгуулах, энэ талаарх сургуулийн дүрэм, дотоод журам зэрэг эрх зүйн баримт бичиг тусган захирлын тушаалаар баталгаажуулах.</li> </ul>
<b>Ашигласан эгэх хариуцлагын хэрэгсэл</b>	<p><b>Оролцоот төлөвлөлт</b></p> <p>Сурагчдын өөрөө удирдах зөвлөл, хамтарсан баг, эцэг эхийн оролцоотой сургуулийн тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлага, түүнийг хэрхэн шийдвэрлэх боломжийг эрэлхийлж “Оролцоот төлөвлөлт” аргыг ашиглан ажиллав.</p> <p>Манай хамт олон багш нарын сурган хүмүүжүүлэх илтгэл, “Сайн сургууль”-ийг дэмжих аргачлалаар мэдээлэл цуглуулах явцад үндэслэн бид хамгийн түрүүнд суралцагчдаа сургуулиа гэсэн сэтгэлтэй, аливаа зүйлд сэтгэлээсээ ханддаг оролцоотой болгох нь хамгийн чухал юм байна гэдэг дээр санал нэгдсэн.</p> <p><b>Ингэхдээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Сайн сургууль” төслийн хүрээнд авсан судалгаа, жижүүр багшийн ирцийн тэмдэглэл дээр үндэслэн эцэг эх, суралцагчдын төлөөллийг тус тусад нь оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн явцад эцэг эх, сурагчид тус бүртээ сургуулийнхаа ямар үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг, юунд сэтгэл зовнидог, ямар өөрчлөлтүүдийг хэрхэн хийх боломжтой байгаа талаарх санал бодлоо илэн далангүй илэрхийлсэн.</li> <li>- Сургуулийн удирдлага багш нарын зүгээс ч сургуульд тулгамдаад байгаа, яаралтай шийдэх шаардлагатай асуудуудыг танилцуулахад эцэг эх, суралцагчид нааштайгаар хүлээн авч, шийдэх арга замыг эрэлхийлж ямар боломж байгааг чин сэтгэлээсээ эрэлхийлж байсан юм.</li> <li>- Энэхүү хэлэлцүүлгийн үеэр тулгамдаж буй асуудлаа хэрхэн шийдэх, хэн анхаарах, хэнээс дэмжлэг хүсэх, хэн хариуцах зэргээ нэгтгэн төлөвлөгөө боловсруулсан.</li> <li>- Тухайн боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ сургуулийн удирдлага, багш, СӨУЗ-ийн гишүүдийн хариуцаж хэрэгжүүлэх ажлыг нарийвчлан тодорхойлсон.</li> <li>- Ийнхүү ажиллахдаа багш, суралцагч, эцэг эхийн төлөөлөл төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаандаа дотоод хяналт тавих үнэлгээний хуудас боловсруулан ашигласан болно.</li> </ul>
<b>Хүрсэн үр дүн(гарц, богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</b>	<p>Энэ хичээлийн жилд сургуулийн цонх, дээвэр, сантехник, ханыг дулаалснаар анги танхим дулаахан, тав тухтай орчин бүрдэж чадлаа. Анги танхимын дулааны хэм 2018-2019 оны хичээлийн жилийн 10 дугаар сард дунджаар 0-10°C хүйтэн байсан бол 2019-2010 оны хичээлийн жилийн мөн үед +12°C хэмтэй болов.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд дотуур байрны гурван нойлийн өрөөг иж бүрэн засварлаж, усанд орох зориулалттай хоёр душтэй болсноор дотуур</li> </ul>




## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>байрны сурагчдын 45 хувийнх нь хувьд эрүүл ахуйн нөхцөл боломж сайжирсан</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2018-2019 оны хичээлийн жилд дотуур байрны сурагчдын 45 хувь нь ханиад болон бусад ахуйн гаралтай өвчнөөр өвчилдөг байсан нь 15 хувиар буураад байна.</li> <li>- Нийт сурагчдын 47 хувь нь сургууль, анги танхим, дотуур байрны орчин, нөхцөлдөө сэтгэл дундуур байдаг байсан бол энэхүү засвар үйлчилгээ, тохижилтын ажил хийгдсэнээр тэдний сэтгэл ханамж 30 хувиар нэмэгдэн 77 хувь болсон. Дотуур байрны хүүхдүүдийн дунд гадуур сэлгүүцэх байдал эрс буурсан.</li> <li>- 2019-2020 оны хичээлийн жилд “Дэлхийн Зөн-Монгол” ОУБ-ын хөрөнгөөр сургуулийн гадаах болон сагсан бөмбөгийн талбай, <b>Солонгосын KSD Foundation, HANGONGSE</b> бизнесийн байгууллагын хөрөнгө оруулалтаар спорт заалыг стандартын дагуу засварлаж иж бүрэн шинэчлэн ашиглалтад оруулснаар спортоор хичээллэх сурагчдын тоо 23 хувиар нэмэгдсэн. 2018-2019 оны хичээлийн жилд нийт суралцагчийн 62 хувь спортоор хичээллэдэг, сонирхдог байсан. Манай сургуулийн спортын амжилт нийслэлд 8, улсад 1 медалиар ахисан үзүүлэлттэй байна.</li> <li>- Сургуулийн орчин нөхцөл сайжирч, заалтай болсноор сурагчдын дундах гар утасны хэрэглээ, интернэт ашиглан тоглоом тоглох байдал 18 хувиар буурлаа.</li> <li>- Цонхыг вакуумжуулж сольсноор цонх дулаалах, цонх будах зэрэг ажлыг хийхгүй болж үйлчлэгч нарын хавар, намрын ажлын ачаалал 20 хувиар буурав.</li> </ul>
<p><b>Үр дүнг тогтворжуулахад ар хийсэн алхмууд</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- СӨУЗ-ийн сурагчид “Манлайлал”-ын сургалтыг дунд, ахлах ангийн сургагчдын дунд бие даан зохион байгуулж, анги танхим, сургуулийнхаа эд хогшилд ариг гамтай хандах уриалга гарган нөлөөллийн ажлыг улирал, хагас жилээр төлөвлөж, тогтмол зохион байгуулдаг уламжлалтай болж байна.</li> <li>- Сургуулийн дүрэм, дотоод журамд сургуулийн үйл ажиллагаанд суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх талаар орсон зүйл заалт, захирлын тушаалыг нийт сурагчдад танилцуулж, сургуулийн төлөвлөгөөнд тусган, нийгмийн ажилтны ажил үүргийн хуваарийн нэг үзүүлэлт болгон тусгав.</li> <li>- Сурагчдын өөрөө удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд сурагчид сурагчдадаа хяналт тавих, уриалга гарган хэрэгжүүлэх ажлыг тогтмол зохион байгуулахаар тусган, хэрэгжүүлж байна.</li> <li>- Багш, сурагч, эцэг эхийн хандлагыг өөрчлөх, чадваржуулах сургалтыг улирал бүр тогтмол зохион байгуулж хэвшүүлэхээр “Сургуулийн хичээлийн жилийн нэгдсэн төлөвлөгөө”-нд тусган хэрэгжүүлж байна.</li> </ul>
<p><b>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Манай сургуулийн нийт сурагчдын дийлэнх нь буюу 70 хувь нь нийгмийн идэвх оролцоо бага, сургуулиас тэдний нийгмийн идэвх оролцоог дэмжин, идэвхжүүлэх ямар нэг ажил санаачлан зохион байгуулахад аль болох хойш сууж үлддэг, идэвхтэй хэдэн хүүхдээ юмны түрүүнд барьж өөрсдөө хойш суух хандлага байнга ажиглагддаг. Сургуулийн удирдлага, багш, үе тэнгийнхнээс ямар нэг шаардлага тавихад буруугаар ойлгох, үг даах чадвар сул байсан нь бэрхшээл болж байсан.</li> <li>- Нийт сурагчдын 26 хувь багаар ажиллах чадваргүй, аль болох ганцаараа байх, чөлөөт цагаараа гар утсаа оролдох, тоглоом тоглож өнгөрөөдөг дадал зуршилтай болсон байсан. Мөн сургуулийнхаа эд хөрөнгөд өөриймсөг бус ханддаг, ширээн дээрээ юм зурж эрээчиж сараачих, бохь наах, сандал бусад</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>эд хогшлийг эвдэж, ариг гамгүй хандах зуршилтай тогтсон байсан нь хамгийн хүндрэлтэй асуудал байв.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сургуулиас зохион байгуулж байгаа аливаа ажилд сурагчдын оролцооны асуудал чухлаар тавигдаж байсан учир сурагчид эвлэлдэн нэгдэх, багаар ажиллах чадвартай холбоотой бэрхшээлүүд тулгарч байсан.</li> <li>- Багш сурагчдыг хичээлдээ идэвхитэй оролцуулахын тулд бүтээлч даалгавар, уралдаан тэмцээн зохион байгуулахад сурагчид идэвхи муутай оролцдог байсан.</li> </ul>
<p><b>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс (үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч, орон нутгийн удирдлага, бусад оролцогчид)</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Бид энэхүү туршлагыг хэрэгжүүлэх явцад хамгийн их эерэг нөлөөл үзүүлсэн зүйл нь сургуулийн барилгын засвар, дулаалгын явцад хөндлөнгийн хяналт тавихаар зохион байгуулалтад орсон “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагаа юм. Хүүхэд эргэн тойрноосоо алхам тутамдаа суралцаж байдгийн нэг нотолгоо нь “Хамтарсан баг”-ийн зохион байгуулалт, санаачлан хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа сурагчдад сайнаар нөлөөлж, тэд ч сургуулийнхаа орчин нөхцөлийг сайжруулахад анхаарч, дэмжлэг үзүүлэх хүсэл сонирхлыг бий болгосон явдал юм.</li> <li>- Сурагчдын өөрөө удирдах зөвлөл (СӨУЗ) ч үйл ажиллагаагаа идэвхжүүлж ганцхан урлаг, спортын тэмцээн зохион байгуулах бус сургуулийнхаа бусад сурагчдын дунд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдний санал бодлыг сургуулийн удирдлага, багш нарт уламжлан тэдэнтэй хамтран ажиллаж эхэлсэн нь сурагчдын өөрийгөө илэрхийлэх болон багаар ажиллах идэвх, сонирхлыг өрнүүлж бусад сурагчдад сайнаар нөлөөлсөн юм.</li> <li>- Эцэг эхчүүд идэвхжин, сургуулийн үйл ажиллагааг ойлгож, сургуулийн удирдлага, багш нартай хамтран ажиллаж, сургуулиар орж гарч, сургуулийн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулдаг болсон хандлагын өөрчлөлт нь сурагчдад эерэг нөлөө үзүүлж тэд эцэг эхээсээ суралцаж, бас тэднээр бахархан өөрсдөө ч идэвхжин эерэг хандлагатай болж эхэлсэн.</li> <li>- “Сайн сургуулийг дэмжих аргачлал”-аар үнэлгээ хийх явцад хамтарсан багийн үйл ажиллагаанд сурагчдыг татан оролцуулж хамтран асуудлуудыг шийдвэрлэх арга зүй, оролцоог дэмжих арга зүйд суралцсан.</li> <li>- Сургуулийн зүгээс сурагчдын өөрөө удирдах зөвлөлийн үйл ажиллагааг нь дэмжин ажиллах, сурагчдаас гарсан саналыг хэрэгжүүлэхэд анхааран ажилласан.</li> <li>- Хамтарсан багийн багш нарын төлөөлөл төсөлтэй холбоотой санал асуулга авах, дотоод хяналт тавих, сурагчдыг чиглүүлэхэд хамтран ажилласан.</li> <li>- Хамтын ажиллагаатай байгууллагууд болох Дэлхийн Зөн ТББ сурагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, дотуур байрны сурагчдын спорт чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн Спортын гадаа сагсны шийдийг байгуулж өгсөн,</li> <li>- Солонгосын KSD Foundation, HANGONGSE бизнесийн байгууллагын хөрөнгө оруулалтаар спорт заалыг ашиглалтад оруулж сурагчдад суралцах таатай орчинг бүрдүүлсэн. Спорт заал ашиглалтад орсноос хойш сурагчдын спортын амжилт, багаар ажиллах чадвар сайжирч, жудо бөхийн төрлөөр Г.Гүндэгмаа улсын аварга болсон мөн “хуурнин шуугигч” хүүхдийн үндэсний бөхийн төрөлд Т.Түвшинтогтох улсын аварга болсон.</li> </ul>
<p><b>Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл</b></p>	<p><b>В.Дуламсүрэн (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 74 дүгээр сургуулийн бага ангийн багш):</b></p> <p>Сурагчдын оролцоог нэмэгдүүлэх нь багш нарын хувьд тулгамдсан асуудал болоод байна. Сурагчдын хэрэгцээ шаардлагыг судлах, сурагчдын төлөөлөл</p>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>сурагчдаа төлөөлж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байх нь хамгийн чухал гэж боддог. Сурагчид өөрсдийн хэрэгцээ шаардлагадаа тохируулан үзэл бодлоо илэрхийлж сургуулийн бодлого боловсруулахад хамтран ажиллах үр дүнтэй эхлэл бий болж байгаа нь их таалагдсан.</p> <p><b>Б.Солонго (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 74 дүгээр сургуулийн 12а ангийн сурагч):</b></p> <p>Сургууль маань энэ хичээлийн жил орчин нөхцөлөө өөрчлөн дулаалга хийж, өнгө үзэмжээ сайжруулаад дулаахан сайхан болсон. Одоо сургууль дээрээ байхаар их гоё. Нэг л гоё дулаахан, тохь тухтай. Би сургуулийн хамтарсан багт сурагчдын төлөөллөөр орсон. Намайг саналаа хэлэхээр манай сургуулийн багш, удирдлага, ажилтнууд сайхнаар хүлээн аваад, үйл ажиллагаандаа тусгаад хэрэгжүүлэхээр их гоё санагдсан. Та бүхэндээ нийт сурагчдынхаа өмнөөс баярлаж, талархаж байгаагаа илэрхийлж байна.</p>
<p><b>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Аливаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд төсөв, санхүүгийн хүндрэл их тулгамддаг. Энэ байдлаас гарахын тулд “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл, Дэлхийн зөн-Монгол ОУ-ын ТББ, Солонгосын Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (KOICA) болон орон нутгийн байгууллагад хандан сургуулийн өнөөгийн нөхцөл байдлаа бодит судалгаа, баримт мэдээлэлд тулгуурлан ойлгуулж, үйл ажиллагаандаа дэмжлэг авч чадсан нь хамгийн үр дүнтэй алхам болсон. Иймээс бидний хувьд сургуулийнхаа тулгамдаж буй асуудлыг шийдэхийн тулд хэн нэгнээсээ дэмжлэг хүсэхдээ бодит нөхцөл байдлаа судалгаа, тоо баримтад тулгуурлан, тухайн асуудлаас үүдэн ямар бэрхшээлүүд тохиолдож байгаагаа хамтран ажиллаж байгаа, дэмжлэг хүсч буй байгууллагадаа зөвөөр ойлгуулах нь чухал юм.</li> <li>- Сургуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нэг зорилго чиглэлтэй сургуулийн зөвлөл, эцэг эхийн зөвлөл, сурагчдын өөрөө удирдах зөвлөлийн гишүүдийг чадваржуулах, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх, ялангуяа насанд хүрэгчдийн зүгээс зарим тохиолдолд СӨУЗ-д дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах нь үр дүнтэй зохицуулалт юм.</li> </ul>
<p><b>Холбоо барих хаяг, лого</b></p> 	<p><b>НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 74 ДҮГЭЭР СУРГУУЛЬ</b></p> <p>Сургуулийн захирал: Ө.Энхцэцэг (Утас: 96649779, э-шуудан: <a href="mailto:enkhe_74@yahoo.com">enkhe_74@yahoo.com</a>)</p> <p>Нийгмийн ажилтан: О.Гансүх, Утас: 96444869</p> <p>Физикийн багш: М.Сэрсэндагва (Утас:91671961, э-шуудан: <a href="mailto:serse2009@gmail.com">serse2009@gmail.com</a>)</p>

### ХАМТАРСАН БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОГТВОРЖУУЛАХ

<p><b>Зорилго:</b></p>	<p>Сургуулийн удирдлага, багш, эцэг эх, сурагчийн төлөөллөөс бүрдсэн “Хамтарсан баг” байгуулж, хамтын бүтээлч оролцоо, нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслийн тусламжтай, тулгамдаж байгаа асуудлаа хамтаараа шийдэх боломжийг эрэлхийлнэ.</p>
------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

<p><b>Нөхцөл байдал гулгамдсан асуудал</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Манай сургуулийн нийт эцэг эхийн 85 хувь төмөр замчид болон малчид учраас сургуулиас санаачлан зохион байгуулдаг аливаа ажилд оролцоо багатай, дунджаар 45-50 хувийн ирцтэй байдаг. Эцэг эх сургуульд байнга шүүмжлэлтэй хандаж, сургуулийн талаарх буруу ташаа мэдээлэлд итгэсэн байдаг.</li> <li>- Сургуулийн зүгээс эцэг эхийн идэвх санаачилгыг нэмэгдүүлэхээр зохион байгуулж байгаа ажил нь эцэг эхийн хурал, жилд нэг удаа зохион байгуулдаг эцэг эхийн өдөрлөг, спортын уралдаан тэмцээнээр хязгаарлагддаг. Сургуулийн үйлчилгээний чанар, сурагчдын сурлагын амжилтыг сайжруулахад чиглэгдсэн ямар нэг хөндлөнгийн хяналт үнэлгээг тэдний оролцоотой зохион байгуулж байгаагүй.</li> <li>- Жил бүр сургуулийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, дотоод журам, эцэг эх, сурагчдын хамтын гэрээний заалтад өөрчлөлт оруулж, хичээлийн жилийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлдэг. Эдгээр бодлого эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулахдаа эцэг эх, сурагчдаас санал авч тусгах ажлыг хийдэггүй хийдэггүй байсан.</li> <li>- Нийслэлээс 56 км алслагдсан манай сургуульд олон тулгамдсан асуудлууд байсан. Тухайлбал, дотуур байрны өрөө тасалгаа зориулалтын бус, ариун цэврийн өрөө хангалтгүй, сурагчдын чөлөөт цагаа өнгөрөөх орчин бүрдээгүй.</li> <li>- Сургуульд байгаа бэрхшээлтэй асуудлыг зөвхөн сургуулийн удирдлага шийдэх үүрэгтэй гэж оролцогч талууд үздэг, тодорхой нэгэн асуудлыг хамтдаа шийдэхээр зохион байгуулалтад орж, хамтран ажилласан тохиолдол байхгүй.</li> </ul>
<p><b>Зорилтот бүлэг</b></p>	<p>74 дүгээр сургуулийн 578 сурагч, 62 багш, ажилтан</p>
<p><b>Шалгуур үзүүлэлт (төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ)</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- 2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн удирдлага, багш, эцэг эх, сурагчдын төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй баг байгуулагдсан байна.</li> <li>- Хамтарсан багийн гишүүд 2018-2019 оны хичээлийн жилд төсөл хэрэгжүүлэх нэгжээс зохион байгуулсан болон “Сайн сургуулийг дэмжих аргачлал”-ыг туршин хэрэгжүүлэх 3-4 удаагийн сургалтад хамрагдаж чадваржина.</li> <li>- Зохион байгуулалтад орсон “Хамтарсан баг”-ийн гишүүд хичээлийн жилийн эхэн болон төгсгөлд 2 удаа “Сайн сургуулийг дэмжих аргачлал” ашиглан сургуулийн засаглал сэтгэл зүй болон материаллаг орчинд үнэлгээ хийдэг уламжлалыг бий болгоно.</li> <li>- 2019 оны 5 дугаар сард төсөл хэрэгжүүлж байгаа 2 сургууль, цэцэрлэгийн туршлагаас солилцох “Автобустай аялал”-ыг зохион байгуулж, сургуулийн удирдлага, багш, эцэг эх, сурагчийн 25 төлөөллийг хамруулж, бусдаас суралцах боломж бүрдүүлнэ.</li> <li>- 2019 оны 6-9 дүгээр сард хамтарсан багийн гишүүд “Барилгын дулаалгын засварын үйл явцад хөндлөнгийн хяналт тавих” үнэлгээний аргачлал ашиглан засварын эхэн, явц, төгсгөлд 3 шатны үнэлгээ хийсэн байна.</li> <li>- 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд хамтарсан багийн гишүүд сургуультайгаа хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан багш, эцэг эхийн төлөөллөөр хэлэлцүүлэн баталж, хэрэгжүүлж эхэлнэ.</li> </ul>
<p><b>Ашигласан эгэх хариуцлагын хэрэгсэл</b></p>	<p><b>Барилгын засварын үйл явцад хөндлөнгийн хяналт тавих аргачлал буюу иргэдийн оролцоот аудит</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүн бүрийн барилгын засвар, үйлчилгээний ажлын туршлага, мэдлэг, ур чадвар харилцан адилгүй. Хамтарсан баг сургуулийн засвар, дулаалгын ажилд хяналт тавихын тулд төсөл хэрэгжүүлэх нэгжийн барилгын чанарын</li> </ul>

зөвлөх инженерийн сургалтад хамрагдсан. Энэ сургалтаас барилгын дулаалга, стандарт, материалд тавигддаг шаардлагыг талаар бүгд нэг ойлголттой болж ажлаа эхэлсэн нь хяналт тавихад гол чиглүүлэг болсон.

- Сургалтын дараа төсөл хэрэгжүүлэх нэгжээс боловсруулсан, барилгын засварын үйл явцад хөндлөнгийн хяналт тавих аргачлал ашиглан, хамтарсан багийн гишүүд 3 багт хуваагдан үнэлгээний ажлаа гүйцэтгэсэн. Үнэлгээг багийн гишүүд нэг чиглүүлэг ашиглан, тодорхой удирдамжийн дагуу хийсэн учир нэг багийн анзаараагүй зүйлийг нөгөө баг анзаарсан байснаараа үр дүнтэй байв.
- Явцын болон эцсийн үнэлгээ хийх үед засвар хийж байгаа компанийн талбайн болон хяналтын инженерт үнэлгээний явцад илэрссэн алдаа дутагдлыг хэлж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.
- Баг бүрийн хяналт үнэлгээний хуудсыг нэгтгэн тайлан боловсруулж сургуулийн удирдлага, төсөл хэрэгжүүлэх нэгжид хүлээлгэн өгсөн юм.

#### **Сайн сургуулийг дэмжих аргачлал буюу иргэдийн онооны карт**

- Хамтарсан багт орсон эцэг, эхийн төлөөлөл сургуулийн засаглал, сэтгэл зүй, материаллаг орчны талаарх ойлголт тааруу байсан учир сайн сургуулийг дэмжих аргачлалын талаар хамтарсан багийн гишүүдийн дунд сургалт зохион байгуулсан.
- Хамтарсан багийн гишүүд боловсруулсан аргачлалын дагуу засаглал, сэтгэл зүй, материаллаг орчны хувьд үнэлгээ хийх явцад өөрсдийнх нь ойлголт илүү нэмэгдэж илүү итгэл үнэмшилтэй ажиллаж, сургуулийн орчин дахь удирдлага, багш нарын ч тэр бүр анзаардаггүй асуудлыг гаргаж ирснээрээ үр дүнтэй ажил болсон.
- Үнэлгээний аргачлалыг ашиглан хамтарсан багийн гишүүд сургуулийн үйл ажиллагаан дахь олон тулгамдсан асуудлыг илрүүлэхийн зэрэгцээ тухайн тулгамдсан асуудлыг шийдэх нь дан ганц сургуулийн удирдлагын ажил биш бидний хамтын идэвх оролцоо чухал гэдгийг ухамсарлан, эерэг хандлагын өөрчлөлт бий болгож байсан нь энэ аргачлалын гол ач холбогдол оршиж байсан.

#### **Оролцоот төлөвлөлт**




- Хамтарсан багийн гишүүд “Сайн сургуулийг дэмжих” аргачлал болон “Барилгын засварын явцад хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх” аргачлалыг ашиглан сургуульд тулгамдаж буй асуудлыг бодитоор ойлгохын зэрэгцээ сургуулийн нөхцөл байдлын талаар нарийвчилсан мэдээлэлтэй болсон. Тэдний хувьд нөхцөл байдлыг мэдрээд өнгөрөх бус сургуультай хамтран ажиллаж, зарим тулгамдсан асуудлыг шийдэхээ сургуульд мэдэгдсэн.
- Сургуулийн зүгээс нөхцөл байдлын мэдээлэлд тулгуурлан хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулсан юм.
- Боловсруулсан төлөвлөгөөг багш, эцэг эхийн төлөөллөөр хэлэлцүүлсэн. Мөн төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх боломж, хүсэл сонирхолтой эцэг эх, багш нарыг аль болох татан оролцуулахыг эрмэлзсэн.
- Ингэж оролцоот төлөвлөлтийн арга ашиглаж сургууль, хамтарсан баг хамтран ажиллах төлөвлөгөөгөө боловсруулснаар хүлээх үүрэг хариуцлага, хэрэгжүүлэх ажил, холбогдох байгууллага нь анхнаасаа тодорхой болсон.
- Бидний хувьд өмнөх боловсруулан хэрэгжүүлж байсан төлөвлөгөөнөөс энэхүү төлөвлөгөө нь боловсруулахад оролцсон хүн бүр хариуцаж авсан



## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>ажлаа үр дүнтэй хэрэгжүүлэхийн төлө анхнаасаа маш хариуцлагатай ажил хэрэгч хандаж байсан нь “Оролцоот төлөвлөлт”-ийн аргын ач холбогдол гэж үзэж байна.</p>
<p><b>Хүрсэн үр дүн (гарц, богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- 2018-2019 оны хичээлийн жилд хамтарсан багийн бүрэлдэхүүнд багш, сурагч, эцэг эх, удирдлага, ажилчдын төлөөллийг оруулан байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан, тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх аргыг төлөвлөн хэрхэн ажиллаж буйд хяналт тавин ажилласан.</li> <li>- Хамтарсан багийн гишүүд “Сайн сургуулийг дэмжих аргачлал”-ыг туршин хэрэгжүүлэх 3-4 удаагийн сургалтад хамрагдаж хамтарсан багаар ажиллах арга зүйд суралцсан</li> <li>- Зохион байгуулалтад орсон “Хамтарсан баг”-ийн гишүүд хичээлийн жилийн эхэн болон төгсгөлд 2 удаа “Сайн сургуулийг дэмжих аргачлал” ашиглан сургуулийн засаглал, сэтгэл зүй, материаллаг орчны үнэлгээ хийх мэдлэг чадвар эзэмшсэн.</li> <li>- Мэргэжлийн инженерээс дотоод хяналтыг хэрхэн хийх талаар сургалт, зөвлөгөө авсан. (Хөөсөнцөрийн чанар, вакуум цонхны чанар стандарт, барилгын суурийн дулаалга гэх мэтийг хэрхэн чанартай хийх талаар)</li> <li>- Хамтарсан багийн гишүүд “Барилгын дулаалгын засварын үйл явцад хөндлөнгийн хяналт тавих” үнэлгээний аргачлал ашиглан эхний, явцын, төгсгөлийн гэсэн 3 шатны үнэлгээ хийх аргачлалд суралцсан.</li> <li>- “Харилцан суралцах арга зүйн” сургалтад сууснаар багш, сурагч, эцэг эхийн оролцооны талаарх ойлголт авч түүнийгээ үйл ажиллагаандаа тусган ажилласан</li> <li>- Зохион байгуулалтад орсон “Хамтарсан баг”-ийн гишүүд “Сайн сургуулийг дэмжих аргачлал” сургуулийн үйл ажиллагаанд үнэлгээ хийснээр сурагчдын чөлөөт цагаа өнгөрүүлэхэд хамгийн их хэрэгтэй зүйл болох биеийн тамирын спорт заал дутагдалтай байна гэж үзээд төрийн бус байгууллага, олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран шаардлага хангасан спорт заал, сургуулийн гадаа сагсны талбайг барьсан.</li> <li>- “Автобустай аялал”-д эцэг эхийн төлөөлөл 2, багшийн 2 төлөөлөл оролцож төслийн үйл явц бусад сургуулиуд дээр хэрхэн явагдаж байгаа, материал сонголт, үйл ажиллагааны явцад ямар хүндэрлүүд гарч байгаа цаашид юун дээр анхаарах тал дээр туршлага солилцсон.</li> <li>- Хамтарсан багийн гишүүд барилгын дулаалгын засварын үйл явцад хөндлөнгийн хяналт тавьсанаар сантехникийн шугамыг таазаар явуулсан нь хүүхдүүдийн толгой дээр халуун ус асгарах эрсдэл үүсэж болзошгүй гэж үзээд халуун усны шугамыг доогуур байрлуулсан. Хамтарсан багаар үйл ажиллагаанд хяналт тавих нь багш, сурагчид, эцэг эхчүүд сургууль дээр хэрэгжиж байгаа төслийн талаар нэгдсэн нэг ойлголттой байж үйл ажиллагаа ямар шатантайдаа яваа, ажлын явцад ямар алдаа дутагдал гарсан хэрхэн шийдвэрлэж болох талаар төсөл хэрэгжүүлэж байгаа багтай хамтран ажиллах боломж бүрдсэн</li> <li>- Эцэг, эхчүүд сургуультайгаа хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан сэтгэл зүйн, материал, засаглалын орчинд анализ хийж хамтрсан багийн эцэг эхийн төлөөлөл эцэг эхийн зөвлөлд, сурагчдын төлөөлөл сурагчдын өөрөө удирдах зөвлөлтэй хамтран үйл ажиллагааг хэлэлцэн шаардлага хангасан спорт заал, сургуулийн дотуур байранд уштэй болсон, гал тогооны уур сорогч агааржуулагчийг</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

	<p>шинэчилсэн. Сурагч эцэг эхийн гурвалсан гэрээг байгуулахдаа эцэг эхийн санал санаачилгыг тусгадаг болсон.</p>   
<p><b>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтворжуулахаар захирлын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн тушаалаар хамтарсан баг байгуулж сургуулийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулан дотоод журмын 6.4-д сургуулийн эрсдлийн үнэлгээг хамтарсан багаар жилд 1-2 удаа, хагас жилд нэг удаа дотоод хяналт тавин ажиллах заалтыг тусгасан.</li> <li>- Хамтарсан багийг үйл ажиллагааг тогтвортой болгох үүднээс 8, 12, 4 дүгээр сард хамтарсан багаар сургуулийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх, 10, 2 дугаар сард сургуулийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх гэсэн хуваарийн дагуу улиралд нэг удаа уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахаар болсон.Тухайн уулзалт хэлэлцүүлгийн мэдээллийг нийгмийн ажилтан сургуулийн удирдлагад мэдээлэх, хамтарсан багийн үйл ажиллагааг жилд нэг удаа эцэг эхчүүдэд тайлагнаж байхаар төлөвлөв.</li> <li>- Сургуулийн удирдлагаас хамтарсан багийг нийгмийн ажилтан хариуцан ажиллах, ажиллах орчин нөхцөл анги танхимаар хангах ажлыг зохион байгуулсан.</li> <li>- Сургуулийн хичээлийн жилийн нэгдсэн төлөвлөгөөнд хамтарсан баг сургуулийн эрсдлийн үнэлгээг хичээл эхлэх болон хичээл дуусахын өмнө хоёр удаа хийх, сургуулийн үйл ажиллагааны үйл явцад хамтарсан багаар дотоод хяналтыг 2 улиралд нэг удаа хийх үйл ажиллагааг төлөвлөсөн.</li> </ul>
<p><b>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Манай сургуульд өмнө нь сургуулийн удирдлага, багш, эцэг эх, сурагчийн төлөөллөөс бүрдсэн хамтарсан баг ажиллаж байгаагүй. Бидний хувьд янз бүрийн мэдлэг, ур чадвар, хандлагатай хүмүүсийг хэрхэн зохион байгуулж зөвлөн чиглүүлэх туршлага байхгүй байсан. Энэ нь сургуулийн удирдлагын хувьд бас нэгэн шинэ ур чадвар шаардаж, үйлдэн суралцах үйл явц болсон юм.</li> </ul>
<p><b>Амжилтад нөлөөлсөн хүчин</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- “Сайн сургууль” хөтөлбөр хэрэгжүүлсэн нь хамтарсан багийн талаар ойлголттой болж сургуулийн барилгын засвар, дулаалгын явцад</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

<p><b>зүйлс (үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч, орон нутгийн удирдлага, бусад оролцогчид)</b></p>	<p>хөндлөнгийн хяналт тавиад зогсохгүй сургуулийн үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийх, дотоод хяналт тавих сургуулийн үйл ажиллагаанд сурагч, эцэг эхийн санал оролцоог дэмжих гэсэн чухал үйл ажиллагаанд суралцав.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сурагчдын өөрөө удирдах зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж хамтарсан багаас гарсан шийдвэрийг сурагчдад сурталчлах, уриалах, сурагчдаас судалгаа авах, сурагчдын үзэл бодлыг төлөөлөх гэх мэт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан</li> <li>- Сургуулийн эцэг, эхийн зөвлөл хамтарсан багаас гарсан шийдвэрийг дэмжин ажилласан, эцэг эх өөрсдийн саналыг хамтарсан багийн төлөөлөгчөөрөө дамжуулан тухай бүрд мэдэгдэх, сургуулийн үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд боломж нөцлөөр тусалсан тухайлбал сагсны шийдийг цементлэхэд эцэг эхийн төлөөллөөс ирж хийлцсэн.</li> </ul>
<p><b>Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл</b></p>	<p><b>О.Гансүх (Нийгмийн ажилтан)</b></p> <p>Сургуулийн үйл ажиллагааг дэмжихэд сургуулийн удирдлага, багш ажилтан суралцагчид, эцэг эх, хамтран ажиллаж доголдож байгаа асуудал дээр үнэлгээ дүгнэлт хийж хамтран ажлаа төлөвлөж боловсролын харилаанд оролцож байгаа нь маш үр дүнтэй юм. Өмнө жилүүдэд сургуулийн удирдлага, багш эцэг эхчүүд бие биенээ ойлголцоогүйгээс болж янз бүрийн асуудлууд их гардаг байлаа. Тухайлбал манай хүүхэд юу ч сурахгүй байна сургуулийн удирдлага юу ч санаачлахгүй байна, дотуур байрны сурагчид чөлөөт цагаа үр дүнгүй өнгөрөөж байна гэх мэт ойлголцлын зөрөө их гардаг байсан. Харин одоо бол эцэг эхчүүд боловсролын үйл ажиллагаанд санаа бодлоо илэрхийлэх, шаардлагатай бол үйл ажиллагаанд хамтран оролцох боломж байгааг сайн ойлгож оролцоо нь нэмэгдсэн. Сурагчдын хувьд өөрсдийн үзэл болдлоо маш сайн илэрхийлэн юу хэрэгтэй байгаа цаашид багш, хамтарсан багтай яаж хамтран ажиллах тухайд ахиц гаргасан. Энэ нь нийгмийн ажилтны ажлыг хөнгөвчилж өгч байна. Хамтарсан багаар ажиллах аргачлалыг бид бүхэнд түгээн дэлгэрүүлсэн “Сайн сургууль” төслийн хамт олондоо талархал илэрхийлье.</p> <p><b>Эцэг эхийн төлөөлөл Ч.Шүрэнцэцэг (Хамтарсан багийн гишүүн):</b></p> <p>Би энэ сургуулийн эцэг, эхийг төлөөлөн хамтарсан багийн гишүүнээр ажиллаж байна.Эцэг, эхчүүд бидний санал үзэл бодлыг сургуулийн үйл ажиллагаанд тусган хамтарсан багаар асуудлаа шийдэх нь хамгийн зөв арга шийдэл гэж бодож байна. Эцэг, эхчүүд бид нар сургуулийн үйл ажиллагааг болж байгаагаас нь болохгүй байгааг нь хүртэл шүүмжлэхээсээ илүү суруулийг хөгжүүлэх, ая тухтай орчин бүрдүүлэх, сурагчдын авьяас чадварыг хөгжүүлэхэд хамтран оролцоотой байх нь чухал гэдгийг эцэг, эхчүүдэд уриалан эцэг эхийн зөвлөлтэй хамтран ажиллаж байна. Цаашид хамтарсан багийн үйл ажиллагааг улам эрчимжүүлж олон сайхан үйл ажиллагааг зохион байгуулна гэдэгт найдаж байна баярлалаа.</p>
<p><b>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хамтарсан багийн гишүүдийг сонгохдоо нийгмийн идэвхтэй оролцоо сайтай эцэг эхийг сонгох (хамтарсан багаар ажиллах үед зарим эцэг, эхийн ажлын цаг давхцдаг тул аль болох оролцох боломжийг нь харгалзан үзэх)</li> <li>- Хамтарсан багийг сургалтад хамруулах, хэрхэн ажиллах арга зүйд сургах</li> <li>- Сурагчдын оролцоог нэмэгдүүлэх үүднээс СӨУЗ -тэй хамтран ажиллах</li> <li>- Тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд төрийн бус болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах зэргийг анхаарах хэрэгтэй.</li> </ul>

## БИДНИЙ САЙН ТУРШЛАГА

**Холбоо барих  
хаяг**



### **НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 74 ДҮГЭЭР СУРГУУЛЬ**

Сургуулийн захирал Ө.Энхцэцэг (Утас: 96649779, э-шуудан:

enkhe\_74@yahoo.com)

Нийгмийн ажилтан О.Гансүх (Утас: 96444869)

Физикийн багш М.Сэрсэндагва (Утас: 91671961, э-шуудан:

serse2009@gmail.com)